

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-79

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	11-28
2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./	28-35
3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл	36-66
4.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан	66-77
5.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	78-79

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
04 дүгээр сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Х.Баттулга,
Х.Баасанжаргал, Д.Ганбат, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Б.Заяабал.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг, Э.Бат-Амгалан, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, П.Сайнзориг, Э.Бат-Амгалан, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн ... саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасны “... дутуу ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Чанар, хяналтын газрын дарга И.Хайратбек нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Ажлын хэсгийн тусгайлсан саналыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	8
Бүгд:	13

38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 61.5 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.4.спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэх	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
---	---

Тайлбар:

Спорт бооцоот таавар гэж оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх, эсхүл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, цахим спортын тэмцээн, уралдааны талаар үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавих үйл ажиллагааг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйл нэмсүгэй:

“20.18 дугаар зүйл.Бооцоот таавар зохион байгуулах

1.Эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад хэлбэрээр оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эсвэл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй үйл явдлын үр дүнг тааварлаж, тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавьдаг бооцоот тааврыг ашиг олох зорилгоор олон нийтийн газар болон мэдээллийн технологи ашиглан зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19 дүгээр зүйл.Мөрийтэй тоглоом, бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

1.Мөрийтэй тоглоом зохион байгуулах, эсхүл хууль бусаар бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн, эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтын “төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг дээрх ажлын хэсгийн саналаа татаж авав.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 18 дугаар зүйлийн 18.6.5 дахь заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом” гэснийг “спорт бооцоот таавар” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом” гэснийг “спорт бооцоот таавар” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар, П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, мөн

комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, референт Г.Дэлгэрбаяр, Р.Нэнсэндэн, ахлах мэргэжилтэн Д.Нямдорж, Д.Оюу-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, референт Г.Нямдэлгэр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, мөн газрын референт Ш.Бумаажав, ахлах шинжээч Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, референт А.Амармэнд, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 09 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 56 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Гишүүдийн ирц үсгийн дарааллаар Норовын Алтанхуяг гишүүн ирсэн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэнэ. 1-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.4 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх. 2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. 3.Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл. 4.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан. 5.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гэсэн 5 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу, алга уу? 5 дахь нь Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд санал хэлэх гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудлаа, хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны дутуу гэсэн нь

Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг гишүүдэд, та бүхэнд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Итгэмжлэн төлөөлөгчөөр Уянгахишиг гишүүн томилогдон ажилласан байгаа. Нэрс авъя. Асуулт, уг тусдаа. Танилцуулга хийх үү Уянгахишиг гишүүн товч? Хийсэн нь дээр дээ, уг нь хийдэг шүү дээ. Энд харин байхгүй л юм байна, Дэг дээр яг тийм юм байхгүй гээд эд нар дараалалдаа оруулаагүй л юм байна. Уг нь таны тайлбар юмыг хэрхэн, яаж тайлбар танилцуулсан гэдгийг нь хийчхээд, тэгээд түүн дээр чинь үндэслээд гишүүд асуултаа асуувал уг нь илүү зохимжтой байна. Тэгвэл эхлээд Уянгахишиг гишүүний Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр Цэцэд гаргасан тайлбарыг сонсчоод, тэгээд гишүүд асуултаа асууя. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Байнгын хорооны гишүүдэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 сарын 28-ны 4 дэх дүгнэлттэй холбоотой итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд өгсөн тайлбараа танилцуулъя.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын иргэн Н.Туяагаас Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн. Энэ нь болохоор Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам эвсэл санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасан. Мөн хуулийн 71.10 дахь хэсэгт сонгогч нэг ч нэр дэвшигч эсвэл нам, эвслийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолох ба тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудсанд тооцно уу гэсэн. Энэ нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэсэн нь Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2. 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, 4 жилийн хугацаагаар сонгоно гэж заасныг зөрчсөн гэж үзэж байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд мандатын тооноос дутуу санал тэмдэглэсэн бол хүчингүй байхаар зохицуулсан нь сонгогч иргэнд заавал мандатын тоотой тэнцүү сонголт хийхийг тулгасан, чөлөөт сонголт хийх Үндсэн хуулиар олгосон хууль ёсны эрхийг зөрчиж байна гэсэн ийм мэдээлэл гаргасан байна.

Үүнд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг миний бие Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа 1 дүгээрт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад шууд буюу төлөөлөгчийн байгууллагаар уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэж Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох үндсэн эрхийг баталгаажуулсан. Улмаар Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий этгээд, иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэсэн нь сонгогчдод сонголт хийх боломжтой хувилбарыг санал болгож, сонгогч тэдгээрээс өөрийн хүсэл зорилгоор хэн нэгний хөндлөнгийн оролцоо нөлөөлөлгүйгээр чөлөөт сонголт хийх боломж юм. Түүнчлэн чөлөөт сонгуулийн үндсэн зарчим нь хууль зүйн утгаараа иргэн сонгуульд заавал оролцох үүрэг хариуцлага хүлээхгүй байх явдал бөгөөд сонгогч саналаа өгөх үед нөлөөлөх, албадах, хүчээр өөрийнх нь сонгохыг хүсээгүй хүнийг нэр заан тулгаж, түүний төлөө санал өгүүлэхээс сонгогчийг хамгаалахад чиглэдэг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны дутуу гэсэн нь сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуульд оролцох, эс оролцохыг албадсан эсвэл хориглосон аливаа агуулгагүй бөгөөд хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж сонголт хийхэд нь нөлөөлөх утга илэрхийлээгүй гэж үзэж байна.

2 дугаарт Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Монгол Улсын, хэсэгт Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт мандатын тооноос илүү эсвэл дутуу гэсэн нь сонгогч сонгуульд чөлөөтэй сонгох эрхээ эдлэхэд анхаарах арга зүйн асуудлыг хуульчилсан зохицуулалт юм. Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 25 дугаар зүйлд сонгох эрхийг аливаа алагчлалгүй, үндэслэлгүй, хязгаарлахгүйгээр эдлүүлэх ёстойг заасан бөгөөд уг фактыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 1996 онд гарсан НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25 дугаар ерөнхий тайлбарт иргэд төрийн хэргийг явуулахад чөлөөтэй сонгогдсон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох нөхцөлд 25 дугаар зүйлд заасан агуулгаар тэдгээр нь засгийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ гэсэн үг бөгөөд сонгуулийн тогтолцоогоор дамжуулан эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлсэн тухайгаа тайлагнана.

Мөн төлөөлөгчид зөвхөн өөрт нь Үндсэн хуулийн дагуу олгосон эрх мэдлийг л хэрэгжүүлэх тухай ойлголт юм. Чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөр дамжуулан төрийн хэргийг явуулахад оролцох эрхээ иргэд сонгох процессоор дамжуулан, сонгох процессоор дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд процессыг Б-д заасны дагуу хуулиар тогтоосон байх ёстой гэж тайлбарлажээ. Тодруулбал Үндсэн хуулийн эрх зүйн онол ёсоор Засгийн газар, засгийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай бөгөөд ард түмэн өөрийг нь төлөөлж төлөөлөгчдийн байгууллагад сонгогдон ажиллах хүнийг тухайн мандатын тоонд нийцүүлэн сонгох нь төрийг удирдах хэрэгт ард түмнийг бүрэн утгаар нь оролцоход нь хуулиар тогтоосон журмын дагуу арга зүйн дэмжлэг үзүүлж буй явдал болно. Ийнхүү сонгогч тухайн мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дэвшигчийг дугуйлахгүйгээр өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийг мандатын тоонд нийцүүлэн нэр дэвшигчдийн дундаас чөлөөтэй сонгох бүрэн боломжтой. Судлаачид Үндсэн хуульд заасан сонгох эрхийг тайлбарлахдаа Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуульд оролцож, хэн нэгний

төлөө санал өгч сонголт хийж байгаа нь тухайн этгээдийг өөрийгөө төлөөлөн хууль тогтоох эрхийг шилжүүлэн өгч буй хэрэг гэсэн бөгөөд сонгогч мандатын тоотой тэнцүү тоогоор өөрийг нь төлөөлөх этгээдийг сонгосноороо уг эрхээ дутуу дулимаг бус харин бүрэн утгаар эдэлж буй хэрэг юм.

3 дугаарт өмнө нь үүнтэй ижил төрлийн маргааныг хянан хэлэлцсэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэр өдгөө хүчин төгөлдөр байна. Тухайлбал Үндсэн хуулийн цэц 1993 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтдээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хянан хэлэлцсэн баримтуудад үнэлэлт хийж, үнэлэлт хийж үзэхэд Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд сонгогчдын эрх тэгш байх, чөлөөтэйгөөр сонгох эрхийг алдагдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчив гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Маргагч талуудын гомдолд өөрсдийн сонгохыг хүссэн нэр дэвшигчид нь уг тойргоос сонгох мандатын тоонд хүрэхгүй байх тохиолдолд сонгохыг хүсээгүй бусад нэр дэвшигчийн төлөө хүчээр санал өгүүлж, сонгуулийг чөлөөт зарчмыг алдагдуулав гэсэн нь тодорхой баримтаар нотлогдохгүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн зарим заалт Үндсэн хуультай харшилдав гэж үзсэн иргэн Ө.Сэргэлэн, Баасанжав нарын хүсэлтийг хангах үндэслэлгүй байна гэжээ. Иймд Монгол Улсын Их Хурлаас мянга есөн зуун үгүй ээ, Их хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам эвсэлд санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны дутуу гэсэн нь Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна гэсэн үндэслэлээр тайлбар хийсэн болно.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн гишүүнд баярлалаа. Уянгахишиг гишүүн Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбар мэдээлэлтэй танилцаж дууслаа. Одоо гишүүд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асуух гишүүд нэрсээ өгсөн байна. Энхбаяр гишүүнийг нэмчхээрэй, асуух юм уу? Өөр асуух асуулттай хүн байна уу? Энхбаяр гишүүнийг нэмээд, Энхбаяр гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би зүгээр 2, 3 статистик тоог л тодруулъя гэж бодоод асууж байгаа юм. Яах вэ зүгээр манайд Үндсэн хуульдаа сонгох, сонгогдох эрх гээд байдаг боловч ер нь бусад орны Үндсэн хуулийн эрх зүй, зохицуулалтыг судлахаар нэр томъёоны хувьд санал өгөх болон санал өгөх эрх гэж байдаг. Олон сонгогчийн саналууд нэгдэж байж нэг нэр дэвшигч гэдэг юм уу тодорхой нам, эвсэл дээр нэгдэж байж тэр нь сонгох эрх болж төлөөлдөг ийм зарчимтай юм байна лээ. Тэгээд бид нар нөгөө санал өгөх эрхийг сонгох эрх гээд туйлын абсолют эрх маягаар ойлгоод хэрэглэчихсэн зүйл байгаад байх шиг байгаа юм. Тэгэхээр сонгох эрх маань ер нь бол ийм хамтын эрх, дангаараа ерөөсөө сонгох бололцоогүй байдаг. Тэр сонгуульд оролцож байгаа нийт сонгогчдын олонх нь ч гэдэг юм уу тодорхой хүчинтэйд тооцох ирцэд хүрээд тэр олон, нэг хүний төлөө байна уу, нам, эвслийн төлөө өгч байгаа тухайн хувь хүний санал өгөх эрх нь нэгдэж байж сонгох эрх болдог ийм л зүй тогтолтой юм байна лээ л дээ.

Тэгээд мэдээж тодорхой санал өгөх эрхийн хүрээнд нөгөө талаасаа онолын түвшиндээ нэр дэвшигчдээс татгалзах эрх гэж онолын хувьд байдаг. Тэгэхдээ 1 нэр дэвшигчийг онцолж татгалздаггүй, бүх нэр дэвшигчдээс татгалзах эрх буюу цагаан хуудас илгээх байдлаар эрхийг ерөнхийдөө эдэлж байгаа. Манайх ч гэсэн энэ агуулгын хувьд энэ ороод ирчихсэн. Зүгээр яах вэ энийг хатуу үг үсгийн хувьд хуульчилсан орон бол Энэтхэг байдаг. Нэр дэвшигчдийг бүр татгалзах эрхтэй гээд ингээд бичиж тэмдэглэдэг. Тэгэхдээ энийгээ нэг хэрэгжүүлээд сүйд болдоггүй юм байна лээ, зүгээр яах вэ онолын түвшиндээ. Би энэ зохицуулалтын цаад агуулга нь уг нь аль нэг намыг ингэж туйлшруулж өгөх биш олон намын төлөөллөө сонгох, өнөөдөр 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй нийцүүлээд олон намын тогтолцоог л бий болгох агуулгатай зохицуулалт байсан юм болов уу гэж зүгээр бодож байгаа. Манай итгэмжлэгдсэн төлөөлөгч яг энэ үндэслэлүүдээ гарч ярихдаа статистик тоог авч үзсэн үү? Жишээ нь 24 оны сонгуулийн үр дүнгээр хэчнээн ийм дутуу санал өгсөн байдлаар саналын хуудас хүчингүйд тооцогдсон юм гэдэг агуулгыг авч үзсэн үү? Ер нь зүгээр сонгогчдын зонхилох хандлага нь ямар байгаа юм бэ? Энийг нэг тийм талаас нь судалж, эргээд сонгогчийн тэр мэдрэмж, хандлага нь ямар байгаа юм, үүнд таарсан зохицуулалтуудыг бид нар бодохоос өөр аргагүй л гэсэн үг л дээ.

Нөгөөтээгүүр уг нь улс төрийн үйл ажиллагаа сонгох, сонгогдох эрхээ эдлэх гэдэг бол эрхээсээ гадна уг нь цаад талдаа ардчилсан Үндсэн хууль буюу бид нарын зорьж байгаа нийгмийг л бэхжүүлэхэд оролцох ёстой үүрэг гэж хараад байгаа. Тэгэхээр яах вэ бусад оронд Нидерландын жишээгээс ч авч болно сонгуульд оролцохгүй бол торгодог ийм зүйл байгаа. Эрхээ эдлэхийн хажуугаар.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Яг энэ талаар Үндсэн хуулийн цэц, судалгааны төвүүд нөгөө нэг мэдээлэл гомдлыг урьдчилан шалгах болон маргааныг Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанд бэлтгэх ажиллагааны хүрээнд баримт бичиг, тайлбар, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцсан байгаад байгаа. Дээр нь Нээлттэй нийгэм форумын 24 оны 11 сарын 22-ны албан бичиг, мөн Сонгогчдын боловсрол төв тайлбар хүргүүлэх тухай албан бичиг эдгээр байгууллагуудаас бол яг тэр статистик тоо судалгааг авч гаргуулж дүгнэлт гаргасан гэдэг тайлбар байгаа. Яг Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс тийм тооцоо судалгаа, статистик судалгаа хийж авч оруулсан зүйл байхгүй. Үндсэн хуулийн цэц харин маргааныг шийдвэрлэхдээ тэр тоо судалгаан дээр үндэслэсэн гэж харж байгаа.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн тодруулъя 1 минут.

П.Сайнзориг: Би асуултаа гүйцэд сая асууж чадсангүй. Тэгэхдээ тодорхой ийм судалгаануудыг бид нар тооны үзүүлэлтийг нь авч үзэх ёстой юм шиг байгаа юм. 2 дугаарт энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээж авлаа гэхэд яах вэ зүгээр улс төрийн сонгуулийн хугацаан дахь өрсөлдөөний явц болон нам дотроо үзэх их л тийм улс төрийн соёлын хувьд их буруу тийшээгээ явах магадлал өсөхийг үгүйсгэхгүй байгаа юм. Зөвхөн намайг сонго тэр 5 мандаттай тойргийн хувьд ярихад зөвхөн надад санал өгчхөөрэй, 4-ыг нь битгий ч гэдэг юм уу. Энэ өөрөө эргээд нөгөө сонгуулийг зохион байгуулах зардал мөнгө, мэдээж цаана нь углуургатай хүний хэнд саналаа өгөх эрхийн асуудал байгаа, сонголт өргөн байгаа боловч ийм явцуу байдлаар PR сонгуулийн үзэгдлүүд явах, энэ нөгөө сонгуулийн

үнэ цэн гэдэг юм уу, Үндсэн хуулийн үзэл санаа бүдгэрээд явчих ийм сөрөг талуудыг авчрахыг үгүйсгэхгүй байгаа юм. Тэгэхээр энийг бодолцож л бид хэд шийдвэрээ гаргах ёстой юм болов уу гэж зүгээр хувь гишүүнийхээ хувьд үзэж байна.

Ц.Сандаг-Очир: Үг хэлчихлээ. Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Энэ маргаан ер нь яах вэ хүний сонгох, сонгогдох эрх чөлөөтэй сонгох эрх гээд зарчмын хувьд олон улсын жишгийг харахаар манайх зохицуулалт ямар бол доо гэдэг дээр би ч гэсэн өөрөө ингээд юу эргэлзэж явдаг хүн. Гэхдээ өнөөдөр Цэцийн дүгнэлтийн хүрээнд итгэмжилсэн төлөөлөгчийн байр суурийн хүрээнд нөгөө асуулт асуухад итгэмжилсэн төлөөлөгч уг нь хуулиа хамгаалсан, энэ бол зөрчөөгүй байна гэдэг тайлбар өгсөн юм байна шүү дээ. Гэхдээ мэтгэлцээнд очоогүй гэж ойлголоо. Яагаад ер нь очоогүй юм бэ? Итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд нөгөө мэтгэлцэх процесс аягүй чухал байдаг. Таны тайлбарт ер нь 93 оны нөгөө юуны Үндсэн хуулийн цэцээс гарсан шийдвэр, тэрний үндэслэлүүдийг ерөнхийдөө оруулчихсан байгаа юм байна. Тэгээд дээр та тайлбартаа 93 оны 12 сарын 22-ны өдрийн 4 дүгээр дүгнэлт угаасаа ингээд шийдчихсэн хүчин төгөлдөр ийм дүгнэлт байна гэдэг ийм энийг өөрчлөх үндэслэл гараагүй байна гэдэг ийм тайлбар өгсөн. Гэтэл энийг харгалзаж үзэлгүйгээр Цэц шийдвэрээ гаргасан байна. Энийг та яагаад гэж үзэж байна вэ? Уг нь мэтгэлцээнд орсон бол та энийг илүү яах байсан болов уу? Би яагаад харин таныг мэтгэлцээнд орсонгүй вэ? Итгэмжилсэн төлөөлөгчийн ажил байр сууриа ингээд илэрхийлчихсэн юм байна шүү дээ энэ бол хамгаалах ёстой гээд.

2 дугаарт юу байна энэ нөгөө уг нь энэ чинь 93 онд тэгвэл ийм сонгуулийн тогтолцоотой байсан, бид нар 2019, 2024 оны юун дээр Сонгуулийн хууль өөрчлөгдөөд, бүсчилсэн тойрог гэдэг юм руу яваад, бүсчилсэн тойрог маань өөрөө жалга довын үзлээсээ салъя, бодлогыг жоохон томоор нь харъя гэдэг тогтолцооны өөрчлөлт гэж үзээд тойргийн хуваарилалт явсан. Тэгтэл манай Монголчуудын хувьд яг үнэндээ ингээд харахаар зөвхөн өөрийн нутгийн хүнээ сонгох ч байдаг юм уу, таньдгаа сонгох гэсэн фактор маш их байгаад байдаг. Тэгэнгүүт бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрвээ бид нар бүсчилсэн хөгжлөөр, бүсчилсэн тойргоор сонгуулийг өөрсдийнхөө төлөөлөх хүмүүсийг сонгоно гэж байгаа бол энэ нөгөө нутаг нугын гэдэг юм уу зөвхөн юу гэдэг юм Увсынхан бол Увсынхныхаа сонгодог ч байдаг юм уу эсвэл юу гэдэг юм Ховдынхон бол Ховдынхныхоо сонгодог биш, энэ чинь бид нарыг төлөөлөх бүсээр нь харах ийм хүн байна уу гэдгийг чиглүүлэх гэсэн сонгуулийн өөрчлөлт болов уу гэж би хараад байгаа юм. Тэгэхээр хэрвээ Цэцийн дүгнэлтийг хүлээн авбал энэ бид нарын зорьж байгаа тойрог жижиг тойрог биш, жижиг жалга довын үзлээсээ салъя гэсэн зорилгод хэр хүрэх бол, ямар нөлөө үзүүлэх бол тэр талаар та итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд судалж, тайлбартаа оруулсан юм байдаг юм болов уу гэдгийг тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Нөгөө яг хуралдаанд оролцож чадаагүй чуулганы хуралдаантай давхацсан учраас. Тэгээд чуулган яг санал хураалттай байсан учраас очиж чадаагүй. Тэгээд ерөнхийдөө тайлбараа бичгээр хүргэсэн учраас нөгөө хүндэтгэн үзэх шалтгаанаар буюу миний эзгүйд хэлэлцэхийг зөвшөөрсөн, зөвшөөрлөө бичгээр өгөөд явсан. 93 оны Үндсэн хуулийн цэц хүчин төгөлдөр байгаа тохиолдолд дахиж тухайн хэргийг авч хэлэлцэхгүй байх ёстой гэдэг

үндэслэл дээр Цэцээс гарсан дүгнэлтийг дүгнэлтээс харахад Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлаас 19 оны 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72-н 72.1 дэх хэсэг хэсгийн тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцох заалтын талаарх маргааныг агуулгын хувьд хянан хэлэлцсэн Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргаагүй байна гээд үзчихсэн байгаа юм.

Өөрөөр хэлбэл 93 онд авч хэлэлцсэн асуудал нь 92 оны хууль Сонгуулийн хууль байсан. Тэр нь өөрөө яг агуулгад цаад агуулгаараа байгаа боловч яг дутуу гэдэг агуулгаар биш байсан учраас Үндсэн хуулийн цэц энийг дээр Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргаагүй гээд үзчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр 93 оныхоос өөр агуулгыг буюу 19 оны Сонгуулийн хуулийг дутуу гэдгийг авч хэлэлцлээ гэдэг байдлаар 3 дахь үндэслэлийг няцаасан байгаад байгаа юм тайлбар нь. Нөгөө талаасаа ер нь бол энэ асуудал өөрөө онолынхны хувьд ч болон судлаачдын хувьд, хуульчдын хувьд ч гэсэн яг ингээд маргаантай байдаг сэдэв. Яг энэ асуудлаар 93 оноос хойш удаа дараа Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан байдаг юм. Өөрөөр хэлбэл тухайн 93 он 92 оноос хойших Сонгуулийн тухай хуулиудад яг дутуу гэдэг агуулгаараа биш боловч тухайн мандатын тоотой тэнцүү санал өгсөн байх эсвэл нэг яг агуулга бол дандаа нөгөө хадгалагдаад явчихсан. Энэ бол дээр бол Цэцэд гомдол гаргаж байсан тохиолдлууд нэлээн олон байдаг, нэлээн хэд байгаа. Тэр болгонд 93 оны Цэцийн шийдвэрээ үндэслээд маргааныг мэдээллийг хүлээж авахаас маргаан үүсгэхээс татгалзаад ингээд шийдээд явчихсан байдаг.

93 оны яг Үндсэн хуулийн цэцийн дараа 96 онд Үндсэн хуулийн цэцээр ямар асуудал шийдвэрлэгдсэн гэхээр сая Үндсэн хуулийн нөгөө мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдагдсан байгаа буюу нөгөө сонгуулийн сонгуульд оролцох сонгуулийн саналын хуудаст заасан ганц ч нэр дэвшигчийг сонгохгүй байх. Энэ нь өөрөө хүчингүйд тооцогддог байсныг 96 оны Үндсэн хуулийн цэцээс яаж шийдсэн гэхээр энэ нь өөрөө сонгогчийн чөлөөтэй сонгох эрхэд нөлөөлж байна. Тэгэхээр энэ нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна. Хэрвээ тэр сонгуулийн хуудсанд ганц ч нэр дэвшигчийг дугуйлаагүй байсан ч гэсэн энэ нь хүчинтэй саналын хуудсанд тооцогдож явна гэдэг ийм Цэцийн шийдвэр гаргачихсан. Тэгэнгүүт сая Цэц шийдвэр гаргахдаа нөгөө энийг юу гэж нэрлэсэн байлаа одоохон, тохирсон байх зарчимд нийцэх, эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх, тэгээд дүгнэлтүүдээ хийхдээ болохоор нэг ч нэр дэвшигчийг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн 1 минут.

Г.Уянгахишиг: Нэг ч нэр дэвшигчийг дугуйлаагүй бол хүчинтэй үлдэж байхад яагаад тэр дутуу дугуйлсан нь хүчингүй тооцогдох ёстой вэ? Тэгэхээр энэ 2 нь хоорондоо тохирсон байх, ялгаваргүй байх гэдэг зарчмаа алдаж байгаа учраас энийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхээр байна гэдэг ийм дүгнэлт хийчихсэн байгаа. Уг нь Цэцийн дүгнэлт дээр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарт уг зохицуулалтын зорилго нь сонгогч эрхээ эдлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж буй явдал юм гэдгийг зорилготойгоо уялдсан байхаар байна гээд уг нь нөгөө үндэслэх хэсэгтээ тайлбарлаад явчихсан. Гэхдээ энэ нь нөгөө бусад зохицуулалттайгаа нэг хэсгийг ганцыг ч өгөхгүй бол Үндсэн хууль зөрчсөн гэххээд, дутуу дугуйлчихсан болохоор

Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байгаа нь өөрөө буруу байна гэдэг үндэслэлээр яг 72.1-ийг Үндсэн хууль зөрчсөн гэдгээр дүгнэчихсэн байгаад байгаа байхгүй юу.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Номинчимэг гишүүн тодруулж 1 минут.

О.Номинчимэг: Ойлголоо. Яах вэ бүсчилсэн хөгжил ямар нөлөө гарах юм, зориод байгаа бид нарын системд ямар нөлөө гарах юм гэдгийг нэг их ярилцаж судалж, гарах үр нөлөөг судлаагүй гэж ойлголоо. Тэгээд 93 оны Цэцийн дүгнэлтийг харахаар 93 оны тухайн үеийн хуульд тэр сонгогч саналын хуудаст бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн бөгөөд мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дэгс дугаарыг дугуйлан тэмдэглэнэ гэчихсэн юм байсан юм байна л даа. Тэгээд энийг, тэгэхдээ энэ бол бөгөөд гээд давхар нөгөө юу нь болохоор мандатын тоотой тэнцүү гэдэг нь уг нь одоогийнхтой адилхан байгаа юм байна. Гэхдээ Цэц яг яагаад энийг өөр гэж үзсэн гэдгийг нь би Цэцийн тайлбараас сайн нэг их ойлгохгүй байгаад байгаа учраас асуусан юм л даа. Тэгээд уг нь мэтгэлцээн дээр очсон бол энийг нарийн ярих байсан байх гэж бодоод байна.

Ц.Сандаг-Очир: Хариулах уу, санал уу? Санал байна. Бат-Амгалан гишүүн асуултаа асууя.

Э.Бат-Амгалан: Цэцийн 4 дүгээр дүгнэлтийг үндсэндээ хувь гишүүний хувьд дэмжиж байгаа юм. Тэгээд манай хүний эрхийн эрх, эрх чөлөө ярьдаг мэдрэмжтэй гишүүд мэдэрч л байгаа байх. Ер нь зүгээр шулуухан яривал тулгалт хийж байна л гэсэн үг. Хүнд сонгохгүй байх эрхийг нь үлдээхгүйгээр заавал чи 5 мандаттай газар 5 нэр дэвшигчийг 5-ууланг нь дугуйлах ёстой гэдэг ийм тулгалттай л 19 оны 12 дугаар сарын 20-нд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйл гарч байгаа юм. Тэгэхдээ яах вэ зүгээр Цэц дээр мэдээж Уянгахишиг гишүүн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр очсоны хувьд би ерөөсөө нэг ойлгохгүй байгаа энэ эсэргүүцээд байгаа гишүүдийн өмнөөс би ойлгохгүй байгаа юмаа нэг асуулт асууя гэж бодож байна. Цэц дээр мэдээж маргаанууд нэлээн яригдсан байх. Үндэслэл нь юу юм бэ? Заавал жишээ нь 5-ууланг нь зурах шаардлагатай гэж тавиад байгаа, тэр талыг хамгаалаад байгаа, тэр талыг өмгөөлж ярьж байгаа нөхдийн маань үндэслэл нь яг юу байгаа юм бэ гэдэг л байх. Тэгэхлээр яг талаар тэр Үндсэн хуулийн цэц дээр таныг оролцсон хурлууд дээр энэ тал дээр ямар үндэслэлүүд гарсан юм бэ? Тэгээд тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр анхнаасаа яагаад саналын томъёоллыг Сонгуулийн тухай хуульд оруулсан юм бэ гэдэг тухайн үеийн протокол юман дээр тодорхой тусгагдсан байгаа байх. Тэгээд талаар яг тайлбартаа тусгаагүй. Нөгөө талаасаа энэ маргааны гол үндэслэл нь болохоор Үндсэн хуулийн яг заалт нь өөрөө зөв үү, буруу юу гэхээс илүүтэйгээр Үндсэн хууль зөрчиж байна уу, үгүй юу буюу Үндсэн хуулиар чөлөөтэй сонгох эрхээ хэрэгжүүлж чадаж байгаа юу, үгүй юу, энэнд садаа учруулж байна уу гэдэг байдлаар Үндсэн хуулийн маргааны гол зүйл нь байсан учраас энэ тал руугаа илүү яг нөгөө Үндсэн хууль зөрчсөн зөрчил мөн эсэх дээр тайлбар юмнууд хийгдэж явсан байгаа.

Ц.Сандаг-Очир: Бат-Амгалан гишүүн тодруулж асууя.

Э.Бат-Амгалан: Тэгээд ингээд бодохлоор тавьж байгаа үндэслэл нь ер нь зүгээр тийм тодорхой нөхцөл бүрдсэн үндэслэл биш гэж харж байгаа юм л даа. Сонгуулийн тухай хуулийн асуудал яригдаж байгаа юм чинь сонгууль 5-ууланг нь юм уу, 10-ууланг нь зураагүй тохиолдолд тэр Улсын Их Хурлын парламент бүрдэхгүй байх магадлал өндөр судалгаанууд гарсан байх ёстой, ирц хүрэхгүй байх магадлал өндөр судалгаанууд гарсан байх ёстой. Олон улсын янз бүрийн байгууллагуудын туршлага ийм судалгаанууд гарсан байх ёстой. Сонгуулийн тухай хууль л ярьж байгаа шүү дээ. Улсын Их Хурал, Орон нутгийн сонгууль парламентаа бид нар байгуулахын тухайд сонгууль ярьж байгаа. Тэгэхлээр үндэслэл бол тийм ор үндэстэй, тодорхой шалтаг болохоор үндэслэл биш. Зүгээр бас нэг хувь хүмүүсийн ийм л санаагаар орсон юм болов уу гэж би бодож байгаагаа хэлье.

Ц.Сандаг-Очир: Санал хэлчихлээ. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бид их ул суурьтай хандах ёстой. Өмнө нь асуудлаар Үндсэн хуулийн цэц хоёронтой Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэр гаргаж байсан байдаг. 1993 он болон 2007 онуудад. Одоо 3 дахь удаадаа зөрчсөн гэдэг ийм агуулгаар гарч байна. Энийг хүний иргэний сонгох болон сонгохгүй байх эрхийг эдлүүлэх гэдэг агуулгаар Үндсэн хуулийн цэц гаргасан юм байна гэж ойлголоо. Сонгуулийн тогтолцооны асуудлыг бид нар ганцхан иргэний сонгох, сонгогдох эрхээс гадна сонгож байгуулж байгаа төрийн чадавх, чадамж, хөгжил, бодлого, бүр цаашилбал улс төрийн намуудын төлөвшилд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдэг их олон талаас нь авч үзэж байж сонгуулийн тогтолцооны асуудал яригддаг. Бид 2019 онд, 2012 онуудад хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгуулиа хийсэн. Энэний үр дүнд ч гэсэн манай Уянгахишиг гишүүн орж ирчихсэн байж байгаа.

Энэ хувь тэнцүүлсэн тогтолцооны гол агуулга дов жалга тойрогт өмчлөгдөхгүй улс орны хэмжээний цараатай асуудал дээр бодлогын чирч явах гэдэг агуулгаар хувь тэнцүүлсэн тогтолцоо орж ирсэн. Нөгөө талд 2024 оны сонгуулийн нэг онцлог Монгол Улс орныг дов жалга, тойрог руу тэр төсөв урсдаг биш, бүсчилж хөгжих тэр боломжийг олгох агуулгаар тойрог томсгосон. Тэгэхээр Үндсэн хуулийн энэ шийдвэр бол сонгуулийн тогтолцоонд нөлөөлөх нь байна. Мөн улс төрийн намуудын төлөвшилд нөлөөлөх юм байна. Өөрөөр хэлбэл амь амаа бодоорой гэдэг ийм тоглоомын дүрмийг сонгуулийн тогтолцоонд оруулж ирэх гэж байна. 3 ч бай, 10 ч бай мандаттай тойргийнхон бол одоо зөвхөн намайг дугуйлаарай л гэнэ. Энэ бол өөрөө улс төрийн намуудыг ханз татаж дотор нь хагална. Угаасаа 2008 оны 3 мандаттай тойрог дээр л намууд дотооддоо хагарсан, тэрний үр дагаврууд нь Засгийн газруудыг огцруулж байсан, намуудыг фракцад хувааж байсан. Тийм учраас энэ сонгуулийн тогтолцоог цаашилбал 76 жижиг мажоритар тогтолцоо руу энэ Цэцийн дүгнэлт чирэх гэж байна буюу 2019, 2002 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн шинэчлэлийн үр дүнг будаа болгох нь. Тэгэхээр энэ улс төрийн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут Энхбаяр гишүүний микрофон.

Б.Энхбаяр: Улс төрийн намуудын төлөвшил гэдэг их чухал байдаг л даа. Улс төрийн намуудын төлөвшил их чухал байдаг. Ер нь намууд дотроо юунаас болж задардаг вэ гэхээр сонгуулийн тогтолцоо дээр бие биетэйгээ муудалцаад л зөвхөн хар амиа бодоод ингээд ажилласан намын сахилга бат гэдэг юм уу энэ юм

алдагдсан гэдэг. Тэгээд тэр зураг нь парламент дээрээ орж ирэхээрээ томоохон ийм улс орны шинжтэй бодлого, хөтөлбөрүүд амилах ийм боломжуудыг ерөөсөө алдагдуулчихдаг юм. Хувь тоглолт руу явуулчихдаг. Тэгэхээр Үндсэн хууль дээр энэ том агуулгаар нь тайлбар юм яригдаж, мэтгэлцэж, өмнөх парламентын сонгуулиудын туршлага, алдаа, оноо сургамжийг үндэслэж ярилцсан зүйл байна уу?

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Яг сонгуулийн үйл явц гэдэг юм уу, сонгуульд нөлөөлсөн байдал гэдэг юм уу, тэгээд бол өөрөө тухайн хуулийг хууль тогтоогчийн хийх ёстой асуудал байх гэж хараад байна л даа. Тэгээд яах вэ ер нь Цэцийн маргаан дээр Цэцээс, одоо яг нөгөө Цэцийн төлөөлөл байхгүй байгаад байгаа учраас итгэмжлэгдсэн төлөөлөгч би чинь уг нь хуулиа хамгаалж орж байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө одоо яг ингээд нөгөө энэнд тайлбар хэлэх болохоор нөгөө Цэцийн талаас тайлбар хэлэх болчихоод байна л даа. Цэцийн дүгнэлт дээр юу гэж тусгасныг нь. Тэгэхээр одоо яг энэ Цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлтийг гаргахдаа уг нь ингэсэн байгаа. Монгол Улсад хуулийн эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлах болох ч уг хязгаарлалт нь эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх зэрэг зарчмыг хангахыг Үндсэн хуулиар шаардах бөгөөд аль нэг зарчмыг нь хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн үндэслэл болно гэж тодорхойлоод. Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх зарчмыг хангасан эсэхийг шалгаснаар чөлөөтэй сонгох эрхийг зөрчсөн эсэх нь тодорхойлогдоно гээд. Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх дээр нь болохоороо тус хуулийн заалт хоорондын нийцэл алдагдаж, зөрчилтэй байдал үүссэн байх тул эрх зүйн тодорхой байдлыг хангахгүй байна.

Тодруулбал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10 дахь хэсэгт сонгогч нэг ч нэр дэвшигч эсвэл нам, эвслийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тооцох бөгөөд энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудсанд тооцно гэж заасан бол мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэл санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж хуульчилсан байна. Тус хуулийн 71-ийн 71.10 дахь хэсэгт нэг ч нэр дэвшигч эсвэл нам, эвслийн төлөө санал өгөөгүй болон 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн гэсэн 2 ойлголт нь холбогдох нэр дэвшигч эсвэл нам, эвслийг дэмжихгүй гэсэн сонгогчийн сонголтыг илэрхийлэх утгаараа төстэй байна. Гэтэл нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй, огт тэмдэглэгээ хийгээгүй саналын хуудсыг хүчинтэйд тооцсон атлаа тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохоор заасан нь хуулийн зохицуулалт хоорондын зарчмын хувьд зөрчил үүсгэж, сонгогчийг төөрөгдөлд оруулж болохоор байна гээд тайлбарлачихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр яах вэ үндэслэлээрээ ямар ч байсан энэ өөрөө Үндсэн хуулийн зөрчил байна гэдгээр л дүгнээд гаргачихсан байна гэж ойлгосон.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн тодруулах уу, болсон уу? Болсон. Би ганц асуулт асууя. Цэц ингээд 4 дүгээр дүгнэлтээрээ Улсын Их Хурлын 19 оны Сонгуулийн тухай хуулийн 72.1 нь Үндсэн хууль зөрчсөн байна гээд үзчихэж. Онол талаасаа хүний сонгох эрхийг дэмжмээргүй байгаа хүнийг хүчээр дэмжүүлж байна. Та бол заавал 10 мандаттай тойргийг нь сонгочихвол заавал 10 хүн дугуйл. Гэтэл сонгогч тэнд байгаа сонгогч бол би 5 хүнийг дугуйлмаар байна, 6 хүнийг дугуйлмаар байна. Гэтэл надаар заавал 10 хүн дугуйлуулах гээд байх юм энэ чинь миний сонгох эрхэд нөлөөлөөд байна гэдэг ийм үндсэн Цэцийн дүгнэлтийн агуулга энэ гэж би хувьдаа ойлгож байгаа юм. Ийм байна.

Хэрвээ Их Хурал Цэцийн дүгнэлтийг хүлээж авъя гэж бодъё, хүлээгээд авчихъя гэж бодъё. Та итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцсон хүний хувьд, томилогдсон хүний хувьд Цэцийн дүгнэлтийг хүлээж авбал энэ дүгнэлттэй холбогдуулаад гарах, нийгэмд гарах улс төрийн сөрөг үр дагавар юу байж болох вэ? Энэ дүгнэлтийг хүлээгээд авчихъя. Эргээд ямар сөрөг үр дагавар нийгэмд улс төрийн үр дагавар бий болох вэ гэдгийг та итгэмжилсэн төлөөлөгчөөр ажилласан хүний хувьд юу гэж бодож, харж байна вэ? Би дараа нь үгэндээ саналаа хэлнэ.

Г.Уянгахишиг: Цэцээс Цэцийн шийдвэр эцсийнх байх гэдэг үндсэн зарчим байдаг. Тэгэхээр Цэцийн шийдвэрийг хүлээгээд авлаа гэхэд сая гишүүд маань хэлж байна л даа. Энхбаяр гишүүн, Сайнзориг гишүүн тийм ээ. Яг ямар үр дагавар үүсэж болох вэ, энэ дээр жишээлбэл улс төрийн намуудын хувьд ч болон сонгуулийн тогтолцооны хувьд асуудлууд үүснэ гэдэг тайлбаруудыг хэлж байна. Тэгэхээр яах вэ тиймэрхүү нөхцөл байдал байгаа болов уу, энийгээ угаасаа Байнгын хороон дээрээ болон Их Хурлын чуулган дээрээ ярилцах ёстой байх. Яг энэ дээр би дүгнэлт гаргах ч юм уу, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар оролцохдоо энэ хуулийн энэ заалт өөрөө Үндсэн хуульд заасны дагуу хуулиар зохицуулна, сонгуулийн системийг, тогтолцоог хуулиар зохицуулна гэсний дагуу Улсын Их Хурлаас Сонгуулийн хуулиа баталчихсан. Тэр сонгуулийн хууль дээрээ арга, аргачлалыг нь заагаад өгчихсөн. Энүүгээрээ Үндсэн хууль зөрчихгүй яваад байна гэдэг талаас тайлбарыг хийгээд явж байгаа.

Илүүтэйгээр энэ дутуу байх нь өөрөө дутуу дугуйлахгүй байх эсвэл дутуу дугуйлах боломжийг бий болгох гэдэг нь улс төрийн үр дагавар яаж үүсэх вэ гэдгийг бид нар ярилцах ёстой. Өөрөөр хэлбэл энэ нь өөрөө нөхцөл байдлын үнэлгээ юу эсвэл зарчмын асуудал үүсэх үү гэх мэтчилэн энэ бол өөрөө арай өөр төрлийн мэтгэлцээний агуулга гарч ирэх болов уу гэж харж байна. Тэгэхээр яг энэ дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд тайлбар гаргаагүй. Мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд тайлбар өгөх боломжгүй л гэж харж байна.

Ц.Сандаг-Очир: Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алтанхуяг гишүүнээр тасаллаа, Энхбаяр гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Би энэ Цэцийн шийдвэрийг их зөв зүйтэй ийм шийдвэр гарчээ, дүгнэлт гарч гэж бодож байгаа. Энэ жижигхэн юм хэлэхэд Монгол Ардын намын дарга Баяр байхдаа 76 суудалтай байхад 28-ыг нь пропорционалиар, 48-ыг нь тойргоос сонгоно гэсэн ийм холимог тогтолцоогоор анх удаа 12 онд сонгууль явуулсан юм. Би тэр үед Ардчилсан намын дарга байсан. Бид нар яагаад дэмжчихсэн гэхээр нийгэмд байгаа тэр үзэл бодлыг Их Хуралд пропорциональ бол

тусгаж байх учиртай. Тойрог бол ингээд хаягдуулаад байгаа гээд ийм агуулгаар дэмжсэн юм. Дараа нь яах вэ манай хэд маань Үндсэн хуульдаа оруулж байгаад хэдэн жилийн дараа ч байна вэ ер нь энийг авдаг хэрэг гээд хийж байгаа. Энэ бол буруу биш зөв зүйл. Цэц бол маш зөв юм хэлчхээд байгаа юм. Иргэн хүн ингээд 4 мандат дээр, 3 мандат, 4 мандат дээр ингээд 1 хүнээ сонгомоор байна шүү дээ. Чи яагаад миний сонгохгүй гэж бодож байгаа 3 хүнийг надаар хүчээр өгүүлээд байгаа юм бэ гээд яг Үндсэн хуулийн хүний эрх, иргэний эрхийн асуудлаар нь их зөв зүйл гаргаж гэж бодож байгаа юм.

Би сая Энхбаяр гишүүний хэлэхийг сонслоо. Хэдүүлээ ер нь ярилцах хэрэгтэй. Энэнээс болоод нэг мандаттай тойрог руу урсана гэсэн ойлголт бас биш. Иргэний эрх бол хамгаалагдаж байгаа, энэ бол маш зөв болсон. Нөгөө багцална гэдгээс чинь болж хачин балиар юмнууд энэ нийгэмд үүссэн шүү дээ. Тэгээд нөгөө энэ намын хоёр нь нөгөө намын хоёртоо паарлана ч гэнэ үү ер нь нэг их болохгүй юмнууд их байгаа. Тийм учраас манай улс төрийг зөв болгоход, Улсын Их Хурлын гишүүд маань шударгаар сонгогдох сонгогдоход парламент нь боломжийн хүмүүс гарч ирэхэд би хэрэг болж байна гэж бодож байна. Би Үндсэн хуулийн цэцэд бараг анх удаа баярлалаа гэж хэлж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүд нь солигдсоноор Үндсэн хууль жаахан юманд нухацтай ханддаг, мэргэжлийн түвшинд ингэж юмаа харах гэж оролдож байгааг нь би их баярлаж байна. Харин нэг ийм юм байна улс төрчид өө, бид мэргэжлийн хүмүүсийг буруутгахаас илүү өөрсдийгөө буруутгах хэрэгтэй. Тойргоо харин та нар ж... зурж байгаа шүү. Тойрог, тойрог дээр өөр, өөр санал өгдөг. Мөн нэг тойрог дээр нэг улсын иргэн 3 хүний төлөө өгдөг, нөгөөдөх дээр нь 7 хүнээ өгдөг ийм солиотой шүү дээ. Ийм юм дэлхий дээр байхгүй. Тэгэхээр улс төрчид харин ажлаа хийх ёстой тойргоо зөв байгуул. Яаж ийм байдаг юм бэ? Нэг нь 3 хүний санал, нөгөөх нь 10 хүний саналтай. Тэгэхээр энийг зурна, энийг ж..., ж-ыг бол эрх баригч хүчин зурж байгаа. Тэгэхээр та нар маань харин танайхан, манайхан гэхгүйгээр бид нар Монгол Улсын ирээдүй зөв байхын тулд, улс төр нь зөв байхын тулд тойргуудыг зөв байгуулах хэрэгтэй. Налайх, Багануур юу билээ, 3 жижигхэн юм нийлээд тэгээд 2 билүү, 3 билүү энэ, нөгөөдөх нь 10. Ийм, ийм бид нарт улс төрийн тогтолцоогоо зөв болгох, парламентаа зөв бүрдүүлэх энэ тал дээр хэдүүлээ хамтарч ажиллах хэрэгтэй. Танай, манай гэхгүй ээ, танай, манай гэж хоёрын хооронд хэрэлдсээр байтал чинь улс чинь нураад уналаа улс төрийн тогтолцоо.

Одоо харин эдийн засаг гэхээсээ илүүтэй бид нар улс төрийн тогтолцоог 30 хэдэн жилийн дараа дахин эргэн авч үзэх шаардлагатай боллоо. Тэгэхээр хэдүүлээ дээр хамтарч ажиллая. Эцсийн эцэст хоёрын хооронд жижиг маргаанаас бол улс хохирно, ард түмний ахуй амьжиргаа муудна, аж ахуйн нэгж тарч, бутарч, нурж дууслаа. Хэдэн залуучууд маань гадаадад гараад дууслаа. Энэ юунаас эхлэлтэй вэ гэхээр энэ бол улс төр буюу Улсын Их Хурлыг хэрхэн яаж бүрдүүлж байгаа юм, сонгогчдыг санал яаж өгүүлэх гэж хуульчилж албадаж байгаа энэнээс их хамаарч байгаа юм. Энийг л хэдүүлээ нэг ярья. Тийм учраас би Үндсэн хуулийн цэцэд бол дахин талархлаа илэрхийлье. Би бол одоо дэмжиж байна. Цэцийн шийдвэр юм чинь энүүгээрээ нэг юм ч гэсэн ингээд зөв болоод, аятайхан болоод явах юм байна. Ер нь би Номинчимэг гишүүн ярьсан байна лээ. Сонгуулийн хуультай холбоотой хэдүүлээ би бол таны саналыг дэмжиж байгаа. Маш чухал юм одоо мөнгөнөөс салгамаар байна шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүнд 1 минут.

Н.Алтанхуяг: Зөвхөн ухуулагч нарт гэдэг нэрээр л одоо бид хуульчилсан учраас 300 гаруй сая төгрөг өгнө шүү дээ. Ямар амьтан нь энийг чинь дийлэх юм бэ? Тийм учраас хэдүүлээ тэр амьтан эсвэл нэг юм зээл авч байгаад юм уу, наана, цаанаас нам төрөөсөө дэмжлэг авч байгаад гарч ирээд, буцаагаад яах юм бэ эсвэл хүний эрхээр кнопоо дарна эсвэл тойрог дээрээ нэг хэдэн төгрөг тавиулж байгаа нэртэй тэндээс нь жаахан юм хусах гэж, хулгай хийх гэж оролдоно. Энэ чинь бид нарыг тийм юм руу түлхээд байгаа тогтолцоо, хууль, механизм бий болчихоод байна. Энэнээс бид нар салмаар байна. Би Номинчимэг гишүүнд баярлалаа. Та бол яасан, би бас тэр саналыг чинь дэмжиж байгаа. Бид нээрээ мөнгөөр яаж залуучууд хэзээ, яаж гарч ирэх юм бэ? Гарч ирэхгүй шүү дээ. Одоо ингээд тэрбум төгрөг гарга гэхэд түүнийг гаргадаг ямар залуу хүн байгаа юм бэ? Гаргаж байгаа нь мөнгөтэй хүн гарч ирж байгаа шүү дээ. Ингэхээр улс төрийн бодлого байхгүй, Монгол Улсын хөгжлийн бодлого байхгүй.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энийг нэлээн сайн ярилцаж байж тал талаасаа ярилцахаас өөр аргагүй байгаа юм. Улсын Их Хурлын чуулган дээр хүлээж авах эсэх асуудал нэг талдаа гараад шийдэгдэх байх. Өнөөдөр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дүгээр илтгэл дээр сонгож, сонгогдох эрхийн асуудлаар нэлээн олон зохицуулалтыг сайжруулах боловсронгуй болгох ёстой гээд ороод ирчихсэн байгаа. Бид хэд энэний дараа хэлэлцэх байх. Тэгэхдээ яах вэ би зүгээр аливаа асуудлыг өргөн хүрээнд авч үзээсэй гээд онолын түвшиндээ өөрийнхөө өнцгөөс хэлээд байгаа юм. Ер нь зүгээр манай Үндсэн хууль right to elect гэдэг үгээр ингээд орчихсон байж байгаа юм сонгох эрх. Уг нь бусад орны Үндсэн хуулийн агуулга баяжуулалтыг харахаар right to vote буюу хэн нэгний төлөө санал өгөх. Олон санал өгөх эрхүүд нийлж байж сонгох эрх болдог гэдэг онолын углуургыг зөв иргэддээ өгдөг юм байна лээ. Ингэж байж хамтын эрх шүү, collective эрх болдог. Энэ collective эрхийг эдлэхийн тулд та хариуцлагатай байж сонгуульдаа оролцох ёстой байдаг юм гэдэг ардчиллын тэр углуурга эрх, үүргийн мэдрэмжийг өгдөг юм байна лээ. Бусад орны тэр үзэл санаа. Тэгэхээр бид хэд энийг нэлээн суурьтай судалж авч үзэх ёстой юм.

Манай цагаан хуудас шиг гэдгийг бол Үндсэн хуульдаа хатуу хуульчилчихсан бүүр биччихсэн орон чинь Энэтхэг шүү дээ. Чи санал өгөх эрхтэйгээс гадна нэг нэр дэвшигчийг онцолж санал өгдөггүй, бүх нэр дэвшигчдээс татгалзах эрх гээд бүүр ингээд тусдаа нүд байж байдаг. Тэгээд энийг манайх цагаан хуудсаар хийчихсэн байхгүй юу. Харин хэн нэг нэр дэвшигчээс татгалзах эрх гэж байдаггүй. Тэгэхээр би энийгээ уг нь өгч байгаа тэр боломжийг иргэд, сонгогч маань бүрэн эдлээд, үнэхээр тэр нь цагаан хуудсаараа явж байгаа бол үр дагавар нь Энэтхэгийн хуулийг би 10 жилийн өмнө харж байсан санагдаж байна. Тэгэхэд бол намууд нэр дэвшигчээ солих үр дагаврыг үүсгэдэг байхгүй юу. Манайд тэр нь байдаггүй дахин, дахин санал хураалтыг хамгийн олон санал авах хүртэл явчихдаг. Яг эцсийн дүндээ углуургаараа мөн чанарын хувьд байхгүй. Харин үр дагаврын хувьд юу вэ гэхээр нам дотроо толхилцох фракцлах, эргээд өнөөдөр бүсчилсэн хөгжлийн том тойргууд дээр нутаг усаараа хуваагдаж ийм юм руу зүгээр юмнуудыг бид хэд өнгөцхөн бодолцож байгаад хүлээгээд авбал юм руу явчихна.

Би Улсын Их Хурлын гишүүдийн олонхын гарсан шийдвэр дээр аль нэг талдаа гараад шийдсэн тохиолдолд энийг нэлээн том ажлын хэсэг гарч шийдэж, үр дагавар тэрээ бодолцохгүй бол эцсийн дүндээ улс төрийн намын төлөвшил байж чадахгүй бол иргэдийн сонгох эрх эдлэгддэггүй. Энийг бид нар ерөөсөө ойлгох хэрэгтэй. Улс төрийн намын тэр доторх бужигнаан гэдэг юм уу энэ төлөвшлийг саармагжуулах тэр улс төрийн соёл, зан үйл ороод ирэх л юм бол иргэд ч гэсэн тэр бүр улам дордуулж, тэгэхдээ яах вэ 60 чавганц уралдах нь 1 нь түрүүлдэг гэххээд тэгээд 1 нь гарч ирдэг байхгүй юу. Уг нь үүний чинь цаана 60 чавганцаас 1-ийг сонго гэсэн шүү дээ, тэр уралдах гэж байгаа 60 чавганцыг сольчихооч гэдэг үр дагаврыг хүсэх гээд байна уу эсвэл бас нэг өөрөөр. Тэгэхээр ийм зүйлүүд байгаа юм.

Би энэ дээр нэлээн бодолтой авч үзэх зайлшгүй шаардлага байна. Ер нь зүгээр яах вэ би өнгөрсөн 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт дээр ч гэсэн нэг зүйл дээр эмзэглэдэг. Сонгуулийн хууль тогтоомжид тодорхой цаг хугацаа заагаад өөрчлөлт оруулахыг хориглочихсон байгаа. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах цаг хугацааг хязгаарлаагүй байхгүй юу. Сонгуулийн жил зарлагдсанаас хойш Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гараад, энэ Сонгуулийн хууль тогтоомж зөрччихсөн байна гэхэд зөрчсөн хуулиараа сонгуулиа хийгээд бүгд гудамжинд гарах уу эсвэл сонгуулийн хууль тогтоомжоо засах гэж байна гээд сонгууль нь хойшлох уу гээд. Тэгэхээр бид хэд уг нь энэ цаг хугацаагаар аливаа зүйлүүдийг хязгаарладаг биш, аль болохоор ийм consensus-д хүрч, магадгүй сонгуулийн хууль тогтоомжийг цаашдаа ч гэсэн Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад хууль тогтоомжийг батлах квотыг 66 түүнээс дээш хувиар хүлээн зөвшөөрөгдөх байдал руу аваачих ёстой байхгүй юу. Ингэж байж юмаа зөв болгоод явдаг болохоос биш цаг хугацаа эсвэл ингэнэ, тэгнэ гээд 2 туйлд гараад мэтгэлцээд байж болохгүй гэдэг зүйлийг би эцэст нь хэлмээр байна. Тэгээд энэ дээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Бат-Амгалан гишүүн.

Э.Бат-Амгалан: Би анх удаа Цэцийн дүгнэлт, Норовын Алтанхуяг гишүүн хоёртой нэг зүйл дээр дэмжиж нэг талд байгаа юм. Анх удаа Алтанхуяг гишүүнтэйгээ. Яг ерөөсөө Үндсэн хууль хүний сонгох, сонгогдох эрх энэ тал дээр бид нар ардчилал зах зээлийн зарчмаар яваад 30 гаруй жил болчихлоо. Бид нар залуучуудад зөв үлгэр дуурайлалтай улс төрийн манлайлал үзүүлэх шаардлагатай. Тэгэхгүй манай ганц нэг гишүүд ярьж байна л даа улс төрийн намууд дотроо задарна, хагарна, ойлголцохгүй болно, жалга довын үзэл гарна гэж. Би бол эсрэг байр суурьтай байгаа. Энэ сонгогдсон 4 жилдээ тэр анхан шатан дээрээ тойрогдсон тойрог, сонгогдсон тойрог дээрээ тэр бүс дээрээ очиж ажиллаж, хөрөнгө оруулалт, тэр иргэдийнхээ итгэл сэтгэлийг татаж ингэж л ажиллах ёстой. Тэгэхгүй сонгогдчихоод энд ирээд Ордонд 4 жил дарга хийгээд алга болчихдог. Нөгөө сонгогдсон сонгогч, иргэд, сонгогчидтойгоо нэг ч уулздаггүй. Тэгээд ирээд тэр нэг намын далбаан дор ороод заавал 5-ууланг нь дугуйлах ёстой, намайг миний нэрийг хавчуулаарай гэдэг ийм л юм хатуухандаа ярьж байна шүү дээ.

Нөгөө талдаа яг хатуухан хэлбэл дарангуйллын системд шилжиж байгаа юм шиг л юм надад санагдаж байна. Нөгөө социализмын үед 1, 2 намтай ийм цаг үеийг санагдуулж байна. Бөөнөөр нь тэр сонгуулийн санал авах байр луу түлхэж оруулаад чи энэ 5-аас 5-ууланг нь зурна шүү гэдэг ийм л юм байгаа юм. Тэгэхлээр чинь сонгогч, иргэн өөрийнхөө үзэл бодлын дагуу хэчнээн намын гишүүд дэмжигч ч байсан, ер нь намын гишүүн дэмжигч биш ч байсан гэсэн өөрийнхөө дэмжих,

өөрсдийг нь төлөөлөөд төрийн түвшинд, улс төрийн түвшинд, хууль хяналтын түвшинд ажиллах энэ хүнээ л сонгох шаардлагатай ийм л эгзэгтэй цаг үе ирчхээд байгаа юм. Тэгээд зарим гишүүд маань нэлээн нухацтай авч үзэх шаардлагатай гээд ингэж байна л даа. Бид өөрснөө сонгогч нар. Тийм учраас бид өөрсөд дээрээ тулгамдаад байгаа 4 дүгээр дүгнэлтийг хүлээж авах ёстой.

Тийм учраас би энэ Цэцийн дүгнэлтийг, мөн дээрээс нь сая итгэмжлэгдсэн төлөөлөгч маань асуултад хариулахдаа улс төрийн ямар нэг сөрөг үр дагавар байгаа юу гэхэд ер нь бараг байхгүй гэж байна шүү дээ. Улс төрийн сөрөг үр дагавар байхгүй. Хоорондоо ярилцаад, нөхцөл байдлаа ярилцаж байгаад явна. Тэгэхлээр энэ дээр сонгууль хийхэд бид нар Сонгуулийн тухай хууль зөрчигдөөд ирц нь үүсдэггүй, парламент бүрдэхгүй ийм нөхцөл байдал ерөөсөө үүсэхгүй л гэж харагдаж байна шүү дээ. Тийм учраас би энэ Цэцийн дүгнэлтийг, мөн Алтанхуяг гишүүний дэмжиж байгаа байр суурийг дэмжиж байгаа юм. Тэгээд Байнгын хорооны гишүүд маань дэмжиж өгөөрэй. Бид нар улс төрийн нэг зоригтой ийм манлайлал гаргаж, энэ залуучууддаа 30 жилийн нэг угширсан асуудлыг задалж хийж өгөх хэрэгтэй гэж ингэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Сонгуулийн тогтолцоонд нөлөөлөх ийм улс төр, эрх зүйн үр дагавартай шийдвэр дээр мэдээж парламентын намууд, гишүүд ер нь нэлээд нухацтай хандах ёстой байх. Тэр дотроо мэргэжлийн Байнгын хороо хүлээж авсан эсвэл аваагүй гэдэг шийдвэр гаргасан нөхцөлд үндэслэлээ их сайн тодорхой боловсруулж, Улсын Их Хурлын чуулганд оруулж байх шаардлага үүсээд байгаа юм. Ер нь Дэгийн хуульд ч гэсэн өөрчлөлт оруулах шаардлагатай юм шиг байна лээ. Хэрвээ Байнгын хороо хүлээж авсан эсвэл аваагүй гэдэг шийдвэр гаргавал тэрнийхээ үндэслэлийг боловсруулж байж чуулганд оруулахгүй болохоор ийм болохгүй байгаад байна. Яагаад гэхээр Цэц маань өөрөө үндэслэлээ гаргаж байж энэ шийдвэрүүдээ гаргаад байгаа учраас Улсын Их Хурал мөн адил нухацтай энэ гишүүдийн ярьж байгаа саналыг тусгаж, үндэслэлээ боловсруулах шаардлагатай болов уу.

Тийм учраас би бол энэ үндэслэл хэсгийг хүлээж авсан, аваагүй Байнгын хорооны шийдвэр гарсны дараа ирэх долоо хоногийн дараагийн Байнгын хорооны хуралдаанаар үндэслэл хэсгийг танилцаж байж чуулганд оруулъя гэсэн ийм саналтай байгаа. Тэгэхгүй бол энэ гишүүдийн байр суурийг нэг хайрцагт ингээд шууд томъёолчхож болохгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр сонгуулийн тогтолцоо угаасаа нэг хайрцагт угаасаа ордоггүй. Бүх тогтолцоонд сайн тал байдаг, бүх тогтолцоонд сөрөг тал байдаг байхгүй юу. Заавал бүгд 2 талтай байдаг. Тухайлбал 2024 оны энэ удаагийн парламентын сонгуулийн үр дүнд манай сонгогчид их сэтгэл хангалуун байгаа гэж би ойлгодог. Ямар нэгэн асуудал гараагүй АН 42 суудал авсан, МАН 60 хэд гээд ингээд, ХҮН нам суудал авсан, парламентад 5 намын төлөөлөл орж ирсэн гээд ер нь ийм ардчилалтай, олонхтой, цөөнхтэй, сөрөг хүчинтэй, хяналттай парламент гарлаа гэж ингэж би сонгосон гэж бодож байгаа.

АН-ыг яг Засаг бариулчихъя гэж ард түмэн сонгоогүй шүү. Тамга тэмдгээ булаацалдаад зодолдоод нэр дэвшилтээ хийж байгаа намд ард түмэн бас итгээгүй. Тийм. Харин сайн хяналт тавьж, сөрөг хүчин болгочихъя гэдэг сонголт хийсэн. Ард түмэн юунд сэтгэл дундуур байна вэ гэхээр хянаад өгөөрэй гээд

сонгочихсон чинь сайд, дарга болоод явсанд харин сэтгэл ханамжгүй байгаа шүү дээ. Ард түмний сонголтыг зөрж явж байгаад нь харин сэтгэл ханамжгүй байгаа. Сөрөг хүчингүй болчихоод байгаа шүү дээ. Энийг 1800-гаад оны үед Английн нэг судлаач хэлсэн байдаг. Парламентын дарангуйлал гэж томьёолсон байдаг юм энийг. Парламентын засаглалтай мөртөө олонхоороо бүгдээрээ нийлж дарангуйлж ард түмнээ дарангуйлж байна гэж үздэг байхгүй юу. Энэ чинь өөрөө автократ дэглэмийн нэг хэлбэр гэж үздэг. Тийм учраас энэ нэгхэн хүнийг сонгох боломжтой ийм байдал руу ер нь түлхэнэ гэдэг нь өөрөө юу руу түлхэх вэ гэхээр парламентын намуудын төлөвшлийг эсрэгээрээ сөрөг нөлөөлнө.

2 дугаарт дов жалганы үзлийг бий болгоно. Манайд нэг жижиг аймаг байтугай нэгжээд аймгаар нь худалдаад авчих мөнгөтэй хүмүүс байгаад байгаа шүү дээ. Алтанхуяг дарга бол сайн мэдэж байгаа энийг. 1 дүүрэг байтугай Нийслэлээр нь худалдаад авчихаар хүмүүс байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр тойргийн чинь жижигсэх тусам дов жалганы атамнууд бий болдог юм. Ван ханлигууд бий болдог, тэгээд худалдаж авна. Харин мөнгөждөг худалдаж авдаг юмыг чинь улам гааруулах гээд байгаа байхгүй юу.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би түрүүн асуусан асуулттайгаа холбогдуулж үг хэлье. Түрүүнд Цэцийн дүгнэлтийг хүлээж авбал улс төрийн ямар сөрөг үр дагавар үүсэх вэ гэж олон сөрөг үр дагаврууд үүсэх нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй байгаа юм. Үндсэн хуулиар Улсын Их Хурлын сонгууль бол ард иргэд тухайн санал өгөх хугацаанд төрийн эрх барих үйл ажиллагаанд шууд оролцож байгаа нэг хэлбэр. Гагцхүү сонгуульдаа оролцохгүй хэр нь дараа нь сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрдөггүй гэдэг юм уу, төр засгийг муулаад байдаг нэг хэсэг сонгогчид байна. Тэгээд Улсын Их Хурлаас Сонгуулийн хуульд аль болох иргэн болгоныг, сонгогч болгоныг сонгуулиа өгөх нөхцөл бололцоог бий болгох чиглэлээр л хуулийг хийсэн. Зарим улс оронд бүүр тэр битгий хэл журамт үүрэг болгоод сонгуулиа өгөөгүй бол торгууль оногдуулдаг хүртэл улс орон байгаа шүү дээ. Энэ чинь цаанаа юу хэлж байгаа юм гэхээр төрийн эрх барих үйл ажиллагаандаа иргэн болгон оролц, дуу хоолойгоо хүргэ, саналаа өг. Өнгөрсөн хугацааны муу муухай болгоныг төр засаг руу чихэж байгаа бол тэр үйл ажиллагаанд та өөрөө оролцсон юм уу, оролцоогүй юм уу, саналаа ходоодоороо өгсөн юм уу, өгөөгүй юм уу энэ байдалтай шууд холбоотой.

Тийм учраас иргэн болгоныг саналаа өгүүлэх бололцоо боломжийг олгож, хуулийг гаргаад байхад харамсалтай нь манай сонгуулийн үр дүн, сонгуулийн ирц ямар байгаа билээ. Дөнгөж 50 гараад л сонгууль ирцтэй хийгдэж байгаа. Тийм учраас болж өгвөл цаашдаа сонгуулийг өндөр ирцтэй хийлгэх, оролцуулдаг байх, тэгчхээд төрийн эрх барих үйл ажиллагаандаа оролцуулчхаад дараа нь төр засагтаа асуудлаа ярьдаг байх энэ байдал руу орох ёстой юм байгаа юм. Тэгэхгүйгээр тэгж иргэн болгоныг оролцох үүднээс сонгуулийг бүр ажлын өдөр, ажлын өдрийг амралтын өдөр болгож байгаад хийлгэж байгаа шүү дээ. Гэтэл харамсалтай нь манай залуучууд эсрэгээр нь амралтын өдөр болгонгуут Тэрэлж рүү яваад өгч байгаа шүү дээ. Ийм л байдалтай байгаа. Тийм учраас сонгуулиа аль болох оролцож, сонгуульдаа оролцож, төрийн эрх барих байгууллагаа сонгох энэ үйл ажиллагаанд иргэд, сонгогчдыг ирц өндөртэй оролцуулах нь чухал байгаа юм.

Нөгөө талаар мандатын тоотой хамааралтай болж ирж байгаа. Улс төрийн намуудыг төлөвшүүлэх үйл ажиллагаатай шууд холбоотой болж байгаа. Одоо бол

ингээд Цэцийн дүгнэлтийг хүлээгээд авчихвал багаар ажилладаг улс төрийн баг байхгүй болох нь. Намын бодлого гэж байхгүй болох нь. Амь амиа бодоорой, намайг дэмжээрэй гэдэг ийм тоглолт руу орох нь, бодлогогүй болох нь. Нөгөө талаар тухайн тойргийн сонгогчдын бараг 50 хувьд хүрэхгүй хэмжээний саналаар Улсын Их Хурлын гишүүн болох тэр бололцоо боломж үүсэх нь. 100 гишүүний санал авчхаад ч Их Хурлын гишүүн болох бололцоо боломж үүд хаалга нээгдэх нь байна шүү дээ. Яагаад гэхээр эхний 10 санал авсан эрэмбэлээд л 10 мандаттай тойрог дээр ингээд л 10 санал авсан хүн ороод ирнэ. Тэгтэл 10 дахь хүн, 9 дэх хүн, 8 дахь хүн тухайн тойргийн сонгогчдын 10 хувийн, 20-хон хувийн саналыг авчихсан хэр нь парламентад ороод ирэх бололцоо боломж үүд хаалга нээгдэж байгаа юм.

Энэний цаана өөрөө олон нийтэд танигдаагүй гэдэг юм уу, туршлагагүй гэдэг юм уу ийм улс төрчид, ийм хүмүүс парламентад орж ирэх тэр бололцоо боломжууд тэр хэрээрээ үүд үүсэж байна. Тийм үүднээсээ би бол 19 оны Сонгуулийн хууль тухайн тойргийн мандатын тоотой тэнцүү хэмжээний нэр дэвшигчдийг дугуйлж байж таны санал хүчинтэй байна гэдэг нь өөрөө аль болох сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулах, төрийн эрх барих дээд байгууллагаа сонгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, эргээд Монгол Улсын төр засаг, Улсын Их Хурал сонгууль зохион байгуулалттай болох, хэл амгүй бүрдэх, тэгээд олон талын ач холбогдолтой ийм заалт байсан юм болов уу гэж би хувьдаа харж байгаа юм. Энэ байдлуудыг харгалзаж энэ хуулийн заалтыг оруулсан юм болов уу гэж харж байгаа юм. Тийм учраас би хувь гишүүнийхээ хувьд Цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаагаа хэлье. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт, ирц хүрч байна уу санал хураахад? Дуудаарай.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны дутуу гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжсэн болохоор тэгээд яах юм бэ? 13 гишүүнээс 6 гишүүн зөвшөөрч, 46,2 хувиар дэмжигдсэнгүй. Үндсэндээ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн үг шүү дээ. Харин тийм. Итгэмжлэгдсэн төлөөлөгч маань өөрөө, 46,2 хувиар санал дэмжигдсэнгүй. Байнгын хороонд, чуулганы, сая түрүүн Энхбаяр гишүүн санал гаргасан.

Энэ асуудлыг олон талаас нь нухацтай ярилцах хэрэгтэй байна. Маргааш шууд чуулганд оролцуулж болохгүй байна. Одоо их суудлын Цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурал яагаад энэ дүгнэлтийг хүлээж аваагүй юм бэ гэдэг асуудал яригдах учраас тэр эрх зүйн үндэслэлээ маш сайн ярилцах хэрэгтэй байна гэж үзэж ирэх долоо хоногийн Хууль зүй, Төрийн байгуулалтын байнгын хороогоор энэ асуудлыг дахин үндэслэлийг хэлэлцэж байж чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж ингэж бодож байгаа шүү. Ингээд 1 дэх асуудлыг хэлэлцэж дууслаа. Цэцийн 2025 оны дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн бэ, хэн танилцуулах вэ? Болох билүү? Итгэмжлэгдсэн төлөөлөгч Уянгахишиг гишүүн танилцуулна. 1 дэх асуудал дууслаа.

13.02 цаг

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг ХЗБХ-гоор явуулах бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг танилцуулна. Уянгахишиг гишүүнд танилцуулгыг нь сонсьё.

Г.Уянгахишиг: Эрхэм Байнгын хорооны гишүүдээ, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2025 оны 4 дүгээр сарын 11, 14-ний өдрүүдэд тус тус хуралдаж гаргасан санал, дүгнэлтээ Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулсан билээ. Үүний дагуу Байнгын хороо хуулийн төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэгт заасныг үндэслэн хууль зүйн дүгнэлт гаргуулах, түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын дээд шүүх болон Улсын ерөнхий прокуророос хуулийн төслүүдтэй холбогдсон санал авахаар шийдвэрлэсэн.

Үүний дагуу ирүүлсэн хууль зүйн дүгнэлт болон саналуудын талаар. Нэгдүгээрт Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтээр дараах санал дүгнэлтийг гаргасан байна. Үүнд 1.Зөвшөөрлийн тухай хуулийн зорилт буюу уг хуулиар зохицуулах харилцаанд төлбөрт таавар, бооцоо таавар, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг хориглох асуудал хамаарахгүй. 2-т Эрүүгийн хуулиар шинээр үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэж тооцох нь хүний эрхэд халдах хууль зүйн үр дагавар бүхий асуудал тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.7.1-ийг үндэслэн бие даасан үзэл баримтлалтайгаар хууль сахиулах байгууллагуудын болон тухайн салбарын мэргэжилтнүүдийн санал дүгнэлтийг авсны үндсэн дээр шийдвэрлэх. 3.Төлбөрт таавар, бооцоот таавар, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг хориглох зохицуулалтыг бие даасан хуулиар шийдвэрлэх боломжтой хэдий ч Байнгын хорооны санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг баримтлах шаардлагатай гэсэн байна.

Хоёрт Хүний эрхийн Үндэсний Комиссоос дараах саналыг ирүүлсэн. Үүнд Нийгэмд үүссэн сөрөг үр дагаврыг хязгаарлах, таслан зогсоох зорилготой тул төслийн үзэл баримтлалыг дэмжиж байна. 2-т Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан бооцоот тоглоомын гэмт хэргийн шинжийг илүү нарийвчлан тогтоох. 3.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан цахим мөрийтэй тоглоомын гэмт хэргийн шинжийг Эрүүгийн хуулийн 20.17 дахь хэсэгт заасан мөрийтэй тоглоомоос хэрхэн ялгах асуудлыг илүү

нарийвчлан тогтоох. 4.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоом зуучлах хэсгээс өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр тооцооны данс, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаягаа бусдад ашиглуулсан гэснийг хасах зэрэг болно.

Гуравд Монгол Улсын Ерөнхий прокуророос дараах саналыг ирүүлсэн байна. Үүнд, Эрүүгийн хуулийн 20.17 дахь хэсгээр мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зохион байгуулсан бол гэмт хэрэгт тооцохоор байгаа тул төслийн 20.18 дахь хэсгийг хасах. 2-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.5 дугаар зүйлд гэмт хэрэгт хамтран оролцсон төрлөөр нь журамласан, журамлан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан гэмт хэрэг үйлдсэн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх боломжтой тул төслийн 20.19 дэх хэсгийг хасах. 3-д Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд төлбөрт таавар, эсвэл бооцоот тоглоом эсвэл мөрийтэй тоглоомыг сурталчилсан, уриалсан бол зөрчилд тооцох заалтыг нэмж тусгах зэрэг болно.

Ажлын хэсэг 2025 оны 4 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд хуралдаж дээрх байгууллагуудаас ирүүлсэн санал, дүгнэлтийг нэг бүрчлэн хэлэлцлээ. Түүнчлэн хуулийн төслийг боловсруулахад оролцсон болон хууль хяналтын байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай санал солилцсоны үндсэн дээр дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна. Үүнд 1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор тусгасан зохицуулалтыг хасах. 2.Спорт бооцоот тааврыг зөвшөөрөлтэйгөөр эрхлэх асуудлыг хуулийн төсөлд тусгах. 3.Эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад хэлбэрээр бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэхийг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 20.18 дахь хэсгийг өөрчлөн найруулах. 4.Олон нийтийн газар эсвэл мэдээллийн технологи ашиглан мөрийтэй тоглоом зохион байгуулахад эсвэл ашиг олох зорилгоор хууль бусаар бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн бол гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 20.19 дэх хэсгийг өөрчлөн найруулах. 5.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжих хугацаа 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх.

Спорт бооцоот тааврын үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэхийг Зөвшөөрлийн хуулийн өөрчлөлтөд тусгахаар болсонтой холбогдуулан Зөрчлийн тухай, Зар сурталчилгааны тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүд дэх нэр томъёог нийцүүлэн өөрчлөх. 7.Монгол Улсын иргэн гадаад улсад казинод тоглох, бооцоот тааварт оролцох нь хуулийн хориглолд хамаарахгүй байх тул тухайн үйл ажиллагаанаас олсон орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулах, орлогыг оновчтойтой тогтоох. Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуулийн төсөлд спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор татвар ногдуулах биет хэмжээний төрөл, татварын хувь хэмжээ тогтоох асуудлыг нарийн тооцож хуульчлах шаардлагатай байх тул мэргэжлийн байгууллагуудын саналыг авсны үндсэн дээр хуулийн төсөлтэй холбоотой саналыг бэлтгэх нь зүйтэй гэсэн саналыг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй байна. Дээрх саналуудыг томъёолон та

бүхэнд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн ахлагчид баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя Г.Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Б.Батцэцэг ЗГХЭГ-ын дэд дарга, Б.Золбоо ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт, Б.Билгүүн Монополын эсрэг газрын дарга, И.Хайратбек Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Чанар хяналтын газрын дарга, Б.Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, С.Тайван Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, Лувсан-Очир ХХЗХ-ны ажлын албаны дарга, С.Гантулга Дотоод хэргийн их сургуулийн байхгүй байна уу? Ийм албан тушаалтнууд байгаа юм байна. Мөн Х.Сүрэнхорол ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ЗГ-ын ахлах референт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Гишүүдэд Тамгын газрын хууль зүйн дүгнэлтийг та бүхэнд тараасан байгааг та бүхэн танилцсан байх. Ингээд зүйл бүрээр хэлэлцье.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Хэн горимын санал гаргах вэ? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Даргаа уучлаарай, миний нөгөө ходоод өвдөөд байна, арьс сөрдийгөөд ингээд улайчихлаа, танихгүй байна. Дахиад санал хураалгах үүднээс сая санал хураалтыг хүчингүй болгоод өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд. 13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53,8 хувийн саналаар, Номинчимэг гишүүнийг дэмжсэнд оруулаарай гэж протоколд тэмдэглээрэй. Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11.4.спорт бооцоот тааврын үйл ажиллагаа эрхлэх;

тайлбар спорт бооцоот таавар гэж оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эсхүл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй спортын тэмцээн, цахим спортын тэмцээн уралдааны талаар үр дүнг тааварлаж тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавих үйл ажиллагааг ойлгоно. Биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 3.Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн нэрийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.18, 20.19 дүгээр зүйл нэмсүгэй. Санал хураалт, болоогүй байна. Санал хураалтыг цуцалъя.

20.18 дугаар зүйл.Бооцоот таавар зохион байгуулах

1.Эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад хэлбэрээр оролцогч болон зохион байгуулагчийн аль аль нь үр дүнг нь урьдчилан мэдэх эсвэл үр дүнд нь нөлөөлөх боломжгүй үйл явдлын үр дүнг тааварлаж, тогтоосон дүрмийн дагуу бооцоо тавьдаг бооцоот тааврыг ашиг олох зорилгоор олон нийтийн газар болон мэдээллийн технологи ашиглан зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.19 дүгээр зүйл.Мөрийтэй тоглоом, бооцоот таавар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах, эсхүл хууль бусаар бооцоот таавар зохион байгуулах гэмт хэргийн үйлдэлд өөрийн эсхүл бусдын нэр дээрх төлбөр тооцооны данс, цахим мөнгө, виртуал хөрөнгө, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим тодорхойлогчийг удаа дараа ашиглуулах замаар дэмжлэг үзүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,

эсхүл 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алтанхуяг гишүүн асуулт асууна, микрофоныг нь өгье.

Н.Алтанхуяг: 9 сарын 1 гэдэг нь мөн биз дээ? 2 дугаар зүйл чинь. Энэ харин яагаад үйлчлэх хугацаа нь ямар юмнаас болоод ингэж их хойшилж байгаа юм бэ? Зунжингаа тогложих вий дээ л гэж байхгүй юу. Тэр ямар учиртай юм бэ? Энэ хуулийг 25 оны 9 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэнэ л дээ. Тэгээд хуулийгаа хойшлуулж байгаагийн утга учир нь юу юм бэ? Энийг жаахан наанаас мөрдүүлэхэд ямар бэрхшээл байгаа юм бэ?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн ахлагч Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Ажлын хэсэг энэ саналыг боловсруулахдаа нөгөө мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөөд, тэгээд 2 зүйл, заалтаар эрүүгийн гэмт хэрэг шинээр бий болж байгаа, зүйлчлэл бий болж байгаа учраас хүмүүст таниулах ажиллагаа хийгдэх ёстой. Тийм учраас энд бол дор хаяж 3 сарын хугацаа байх шаардлагатай юм гэдэг ийм асуудал хөндөгдөж гарч ирсэн учраас 25 оны 9 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэдэг хугацааг тавьсан байгаа.

Ер нь Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулсан тохиолдолд дандаа нөгөө нэг мэдүүлэх, таниулах хугацааг зайлшгүй оруулж өгөх ёстой байдаг. Тэгэхгүй шууд батлагдаад үйлчлээд явчихвал яг энэ гэмт хэргийн талаар мэдээлэлгүй байгаад нөгөө хүний эрх зөрчигдөх гэдэг юм уу, тодорхой хэмжээнд энэ талаар мэдээлэлгүй байдлаар шууд эрүүгийн гэмт хэрэгт зүйлчлээд шалгаад эхлэх нь зохимжгүй юм гэдэг ийм үндэслэлээр 9 сарын 1 гэдэг хугацаа тавьсан.

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүн тодруулъя.

Н.Алтанхуяг: Тэгээд та нар ярьсан байгаа л даа. Заавал 3 сар 9 сарын 1 гэдэг чинь их хойно л байна л даа. Өдөр, хоног өнгөрөх тусам л өчнөөн амьтан хэрэг төвөгт холбогдож байгаа шүү дээ. Та нар 3 сарын хугацаанд таниулж байгаад тэгээд дараа нь хуулиа мөрдөнө гэсэн логиктой юм ярьж байна. Минийхээр бол энийг харин Их Хурал дээр сайн яриад, энүүгээрээ таниулаад. Үгүй ээ тэгээд сая нэг баахан юм болоо биз дээ “Ноорог”-ийн залуучууд тэглээ, тэгээд л тоглуулдаг хүн байдаг, цаана нь хэрэгтэй, хэрэггүй юм баахан юм болсон шүү дээ. Би бол нийгэмд нэлээн хүрчихсэн байх. Нийгэмд хүрэхээсээ гадна угаасаа энэ залуучууд чинь хийх ажилгүй учраас энэнийг чинь л хийдэг болчихлоо шүү дээ. Тийм учраас дээрээ хугацаагаа жаахан наашлуулаад өгөөч гэж би, асуугаад байх юм алга л даа хугацаагаа наашлуулах боломж байвал жаахан наашлуулаад өгөөч. Өнөөдөр чинь 5 сарын 1 болох гэж явна, 5 сар, 6 сар, 7 сар. Үгүй ээ ядаж 7 сарын 1 болж болдоггүй юм уу?

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүний асуултад ажлын хэсгээс хэн бэ? Сайнзориг гишүүн чинь ажлын хэсгийн гишүүн. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Алтанхуяг даргын хэлж байгаа үнэн. Тэгээд ер нь энэ асуудлыг нийгэмд үүсэж байгаа сөрөг үр дагаврыг нь хангалттай хэлж байгаа, ял хариуцлагын асуудлыг ер нь тал талдаа ярина шүү гэдэг зүйл байгаа учраас ажлын хэсгээс энэ саналаа зүгээр татаад авчихъя. 9 сарын 1-нээс гэдгээ, тэгээд ердийн журмаараа явъя.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл та нарын өргөн мэдүүлснээр энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж, эхлэн дагаж мөрдөнө. Энүүгээрээ явах юм уу, өргөн барьснаараа явах юм уу? Болно гэсэн үг үү Сайнзориг гишүүнээ? Өргөн барьснаараа, болж байна уу? Тэгвэл 2 дугаар саналаа татаж авлаа гэж ойлголоо тийм үү? Тэгвэл төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн саналаа татаж авлаа. 2 дугаар санал байхгүй байна. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 10.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсгийн “төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж тус тус өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 2.Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтын “төлбөрт таавар, эсхүл бооцоот тоглоом, эсхүл мөрийтэй тоглоомыг” гэснийг “мөрийтэй тоглоом, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бооцоот тааврыг” гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувиар дэмжигдлээ.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн ажлын хэсгээс гаргасан, төслийн 2 дугаар зүйлийн нэмэлт гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар дэмжигдлээ. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 18 дугаар зүйлийн 18.6.5 дахь заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом” гэснийг “спорт, бооцоот таавар” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,2 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 2.Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,2 хувиар санал дэмжигдлээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофон.

Н.Алтанхуяг: 1 ийм асуулт байна. Миний өнөөдрийг хүртэл амьдралдаа ойлгож авсан ЖДҮ дотор маань төлбөрт таавар, бооцоот тоглоом гэдэг ийм үгтэй ийм үйлчилгээ үзүүлэхээр, ийм үйлчилгээ үзүүлнэ гэж байгаа юм уу? Тэгвэл энэ үйлчилгээ үзүүлэхгүй гэж байгаа юм бол энэ ерөөсөө дотор байх ёсгүй. ЖДҮ гэдгийн цаана мөрийтэй тоглодог ийм үг үсэгтэй юм огт хармааргүй л байна миний хүсэл бол. Би буруу ойлгосон бол тайлбарлаад өг дөө Уянгахишигээ.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн ахлагч Уянгахишиг гишүүн хариулъя.

Г.Уянгахишиг: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7.1-д болохоор энэ хууль хамаарахгүй ажил, үйлчилгээг дурдчихсан байгаа юм. Тэр дотор нөгөө яг хуучнаар бол төлбөрт таавар, бооцоот тоглоом гэж байдаг байхгүй юу. Тэгэхээр нь одоо энэ нь спорт бооцоот тааврыг бид нар тусгай зөвшөөрлөөр эрхлэх боломжтой болгоод оруулаад ирсэн учраас энийг хэчнээн тусгай зөвшөөрөл эрхэлж байгаа ч гэсэн эн бол өөрөө ЖДҮ, жижиг, дунд үйлдвэрлэлийн төрөлд орохгүй шүү гэдэг тийм заалт байгаад байгаа юм агуулгаараа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу, Алтанхуяг гишүүн болсон уу? Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “төлбөрт таавар, бооцоот тоглоом” гэснийг

“спорт бооцоот таавар” гэж өөрчилсүгэй гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,5 хувиар дэмжигдлээ. Сайнзориг гишүүн ажлын хэсгийн гишүүн.

П.Сайнзориг: Даргаа уучлаарай, тэгээд гишүүддээ ХЗБХ-ны ажлын хэсэг ажиллаад хэлэлцүүлж байгаа саналыг дэмжиж өгсөнд. Энэ Зар сурталчилгааны хууль дээр хураасан 1 дүгээр хураасан 1 дэх саналыг ажлын хэсгээс хэдийгээр дэмжигдсэн ч гэсэн татаад авчихъя. Эдийн засгийн байнгын хороонд оруулах шаардлага байхгүй. Өөрөөр хэлбэл мөрийтэй тоглоом эсвэл хуулиар зөвшөөрөх бусад хэлбэрийн бооцоот тааврыг гэхчээр хуулиар зөвшөөрсөн буюу спорт тааврын үйлчилгээ эрхэлье гээд зөвшөөрөл авсан этгээд зар сурталчилгаа явуулж эхлэх гээд байгаа байхгүй юу. Энийг огт ажлын хэсэг дээр бид хэд яриагүй, энэ бас агуулгын хувьд томьёолол дээр орж ирээд яачихсан байна гээд. Тийм учраас би саналаасаа ажлын хэсгийн ахлагчтай ярьж байгаад татаж авч байна. Ерөөсөө огтоосоо зар сурталчилгаа байж болохгүй. Хэдийгээр зөвшөөрч байгаа ч гэсэн sport bet-ийг. Энийгээ бид хэд ажлын хэсгээс татаж авч байна. Нэг нь, үгүй ээ үгүй бүхэлдээ биш. 2 дахь нь угаасаа нэмэлт гэдгээ хасаж байгаа байхгүй юу, биш зүгээр. 1 дэх саналыг татаж авч байна даргаа.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс оруулсан саналаа ажлын хэсэг татаж авъя гэж байна. Алинтай, энэнтэй холбогдуулж уу? Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Хураачихсан байна. Тэгвэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн барьсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг, аль саналыг гаргах юм бэ? Энд ийм байна, түрүүний Алтанхуяг гишүүний гаргасан санал дээр үндэслээд ажлын хэсгээс Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн зүйлтэй холбогдуулж саналаа татаж авсан, хэрэгжих хугацаатай холбогдуулаад. Энэнтэй холбогдуулаад өмнөх өргөн барьсан заалт нь сэргэж байгаа учраас өргөн барьсан хууль дээр ийм өөрчлөлт орох юм байна. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Уянгахишиг гишүүн танилцуулах уу? Уянгахишиг гишүүн танилцуулна. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Тэгвэл Байнгын хорооны хурал давхцаж байгаа учраас Сайнзориг гишүүн танилцуулах юм байна.

13.33 цаг

Гурав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл

3 дахь асуудалдаа оръё. Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэнэ. Ажлын хэсгийнхнийг оруулъя. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг та бүхэнд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Г.Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, С.Дондов Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Б.Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Г.Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга, С.Тунгалагтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнүүд байна.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн талаарх товч танилцуулга болон сонгох, сонгогдох эрх 24 оны сонгуулийн үйл ажиллагаа сэдэвт 1 дүгээр бүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид танилцуулна. Сүнжид даргын 3 номерын микрофоныг өгье.

Д.Сүнжид: ХЗБХ-ны эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 24 дэх илтгэлийг Комиссын стратеги төлөвлөгөө, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалт, гомдол, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, төрийн болон төрийн бус бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, лавлагаа, статистик тайланд үндэслэн дараах 6 сэдвийн хүрээнд боловсрууллаа.

1 дүгээр бүлэг Сонгох, сонгогдох эрх 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ. 2 дугаар бүлэг Хүний эрх хамгаалагч болох өмгөөлөгч ба сэтгүүлчийн эрх зүйн байдал. 3 дугаар бүлэг Хүний эрх цахим технологи. 4 дүгээр бүлэг Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл. 5 дугаар бүлэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа хүүхдийн эрхийн зарим асуудал. 6 дугаар бүлэгт Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт хэмээх ийм 6 бүлгийн хүрээнд авч үзлээ. Ингээд нийтдээ 44 саналыг Улсын Их Хурлаас тогтоолд оруулна уу хэмээн санал болгож хүргүүлсэн болно.

1 дүгээр бүлэг сонгох, сонгогдох эрхийн хүрээнд дараах асуудлуудыг авч үзсэн. Хамгийн гол нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, Үндсэн хуульд заасан сонгууль сонгох, сонгогдох эрхийн үндсэн 4 зарчмын хэрэгжилт, 2024 оны 9 дэх удаагийн Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль хэрхэн хэрэгжив гэдэг дээр дүгнэлт хийлээ. Ингээд хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийн талаар дүгнэсэн. Түүнээс гадна зардлын үйл ажиллагаа, гомдол шалган шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой дэд сэдвүүдийг дүгнэлээ.

Эндээс үзэхэд 1 дүгээрт Улсын Их Хурлын болоод аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн хурлын, ИТХ-ын сонгуулийн хуулийг онцлогийг нь тусгасан байдлаар дахин зарим өөрчлөлтийг тусгах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ёстой байна гэдгийг дүгнэсэн. Нийтдээ хүрээнд 4 судалгаа шинжилгээг ХЭҮК-оос захиалан гүйцэтгүүлсэн болно. 4 зарчмын хүрээнд дараах асуудлууд байна гэж дүгнэсэн. Энэ 4 зарчим нь 1 дүгээрт бүх нийтээр, бүх нийтийн байх зарчим байна. Бүх нийтийн байх зарчмын хүрээнд дараах бүлгүүд иргэд сонгох эрхээ эдэлж чадахгүй байна гэж дүгнэсэн. Энэ нь 2005 оны Хүний эрхийн Үндэсний Комиссын 2 дахь удаагийн илтгэлд дурдагдаж байжээ. Оюутнууд байна, түрээсийн байранд амьдардаг иргэд, уртын ээлжээр ажилладаг буюу тухайн цаг үед өөрийн байнга оршин суугаа газрын харьяанд биш, өөр газар байрлаж ажиллаж байгаа барилга, дэд бүтцийн салбарын ажил хийдэг хүмүүс байна. Түүнээс гадна төрийн албан хаагчид ажлын шалтгаанаар өөр газар ажиллаж байгаа эсвэл эрүүл мэндийн шалтгаанаар ажиллаж байгаа хүмүүсийн хувьд байнга оршин суугаа газрынхаа санал өгөх байранд саналаа өгөх ийм зохицуулалт хууль тогтоомжийн хувьд үйлчилж байгаа учраас энэ бүлэг иргэдийн хувьд саналаа өгөх боломж өнөөдрийг хүртэл хангагдахгүй байна. Тийм учраас цахимаар эсвэл шуудангаар урьдчилан өөр бусад улс оронд хэрэгжиж байгаа хувилбаруудыг хуулиар зохицуулах нь зүйтэй гэж дүгнэсэн.

Дараагийн нэг хэсэг бүлэг асуудал хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэдийг шүүхийн шийдвэр тогтоол гарсан бол сонгох эрхийг эдлүүлэхгүй гэдэг. Тэгэхдээ ОУБ-ын зүгээс өгч байгаа зөвлөмж нь хүнд, хөнгөн хэлбэрийг нь гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзаад хэрвээ богино хугацаанд хорих ял эдлэхээр бол нийгэмших нөхцөл байдлыг нь бодолцон сонгох эрхийг олгох боломжийг эрэлхийлэх ёстой гэдэг зөвлөмжийг өгдөг. Үүнийг судлан үзэх нь зүйтэй байна гэж үзсэн. Тэгш байдлын зарчмын хүрээнд тойрог сонгуулийн эзлэх жин, төлөөлж буй сонгогчийн тоо гэдэг дээр асуудал байна. Энэ дээр Европын аюулгүй байдал, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагаас өгч байгаа зөвлөмж нь 10-аас 15 хувийн хэлбэлзэлтэй байгаа ч дунджаас гэдэг. Манайд энэ нь 15 нь хэтэрчихсэн Улсын Их Хурлын болоод орон нутгийн иргэдийн хурлын сонгуулийн хувьд, нэг төлөөлөгчдийг сонгогчдыг төлөөлж байгаа тоо бол харилцан адилгүй байгаа. Мандат тойрог байгуулж байгаа байдал өөр, өөр байна. Тиймээс дараагийн удаа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн тухай хуульд аль алинд нь сонгогчдын тоо, газар нутгийн хэмжээ, газар зүйн онцлогийг харгалзана гэж байгааг цаашид үндэслэх тодорхой шалгуур болгон хуульд өөрчлөх нь зүйтэй байна гэдэг дүгнэлтийг хийж байна.

Үүний дараагаар чөлөөтэй байх зарчмын хүрээнд. Чөлөөтэй байх зарчмын хүрээнд сая Үндсэн хуулийн цэцээр шийдэгдсэн мандатын тоотой тэнцүү саналыг дугуйлах гэдэг нь чөлөөтэй байх зарчмыг зөрчиж байна гэж үзсэн. Түүнээс гадна Үндэсний аудитын газраас урт хугацааны хөгжлийн бодлогод нэр дэвшиж байгаа нам, эвслийг мөрийн хөтөлбөрөө бүрэн нийцүүлэхийг шаардаж байгаа байдал нь энэ чөлөөтэй байх зарчимд бүрэн нийцэхгүй байна гэж анхаарах ёстой гэж үзэж байгаа.

Саналаа нууцаар гаргах зарчмын хүрээнд болон чөлөөтэй байх зарчмын хүрээнд харьцангуй бүх нийтээр байх зарчим, тэгш эрхийн зарчимтай харьцуулбал илүү хангагддаг гэж хэлж болно. Гэхдээ энд бид нэгэнт баталчихсан стандарт хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудал байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд саналаа нууцаар гаргах зарчимдаа итгэмжлэгдсэн

төлөөлөгч ажиллаж байгаа, ашиглаж байгаа тохиолдолд, туслалцаа авч байгаа тохиолдолд энэ тухайд бид яаж саналаа нууцаар гаргах эрхийг нь хангах вэ гэдэг асуудал байгаа. Түүнээс гадна саналын, санал авах байранд очиж саналаа өгч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бүрэн харахгүй байх тэр нэмэлт тоног, төхөөрөмж туслалцаа хэрэгтэй байна. Энэ дээр нь бид энэ гаргачихсан стандартыг хэрэгжүүлэх ёстой байна гэдгийг дүгнэж байна.

Сонгуулийн зардлын хувьд хуульд зааснаар бид нар сонгуулийн зардлыг хэмнэнэ гэдэг ийм зорилгыг дэвшүүлсэн боловч яг баталчихсан зардлыг нь аваад үзэхээр энэ сонгуулийн зардлын дээд хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, залуучууд, эмэгтэйчүүд, алслагдмал газар нутагт амьдардаг иргэд, орлого багатай иргэдийн хувьд ийм нэр дэвших боломжийг нь шууд хааж байгаа бас нэг шалгуур болж байна. Ийм учраас сонгуулийн зардлыг дахин авч үзэх ёстой. 2 дахь сонгуулийн зардалтай холбоотой заавал шийдэх ёстой нэг асуудал гэж дүгнэж байгаа нь тайлагнах байдал, хариуцлага тооцож байгаа байдал өнөөдрийг хүртэл дуусаагүй үргэлжилж байна. Татварын ерөнхий газар, шүүхээр үргэлжлээд явж байна. Энэ дээр тэгээд тайлангаа ирүүлээгүй 3 нам, эвсэл байгаа, тэгээд нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй тохиолдолд дараагийн удаа ямар арга хэмжээ авах тодорхойгүй, үр дагавар нь тодорхойгүй ийм нөхцөл байдал үргэлжилсээр байна. Хандивыг буцаах асуудал байна, хуулийн этгээдээс хандив авсан асуудал байна. Хэрвээ хандивыг зарцуулаагүй бол түүнийг цаашид ямар байдлаар төвлөрүүлэх асуудал гээд сонгуулийн зардалтай холбоотой асуудлуудыг хууль тогтоомжийн хувьд нь нэг мөр шийдэх ёстой гэдэг дүгнэлтийг хийж байгаа юм.

Хамгийн сүүлд нь сонгуулийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх байдлыг авч үзвэл 9 байгууллагаас хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байна. Энэ 9 байгууллагаас явуулаарай Мөнхтулгаа, энэ 9 байгууллагын харьяаллыг аваад үзвэл хамгийн их гомдлыг хүлээж авч байгаа нь ЦЕГ, бусад байгууллагууд нь ЦЕГ луу шилжүүлдэг. Ингээд нийт дүндээ 92 хувийн гомдлыг ЦЕГ-аас хүлээж авч шийдвэрлэж байна. Эндээс нийтдээ манай Хүний эрхийн Үндэсний Комиссын захиалгаар судалгаа хийсэн багаас дүгнэж байгаа нь мөнгө тарааж байгаа боловч мөнгө тараагаад байгаа нь ингээд баримт нотолгоотой өгөөд байгаа боловч түүнийг нь хянан шийдвэрлээд иргэдэд ил тод, нээлттэй хариуцлага хүлээлгэсэн байдлыг мэдээлдэггүй учраас ер нь шийдэгдэнэ гэдэг итгэл бага болсон байна иргэдийн хувьд хандалтын судалгаагаар. Шийдвэрлэж байгаа байдлыг нь аваад үзвэл 44 гэмт хэргийг шийдвэрлэсэн байна. Эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж. Тэгээд бусад нь зөрчлийн шинжтэй гэж үзсэн. Тэгээд нийт нөгөө 92 хувийн ЦЕГ хүлээж авсан гомдлынхоо 90 хувийг нь хэрэгсэхгүй болгосон. Оролцогч тодорхойгүй, бүрдүүлэх шаардлагагүй, хуульд заасан шаардлага хангахгүй байна гэж үзээд хэрэгсэхгүй болгосон ийм байдалтай байна.

Захиргааны хэргийн шүүхээр 5-аас 6 нэхэмжлэл шийдэгдсэн юм байна. Тэгэхээр цаашдаа гомдол маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой 2 янзын асуудал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд гомдол маргааныг тухайн жилдээ багтаан шийдвэрлэнэ гэж заасан байдаг бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр 30 хоног гэдэг хугацаа байдаг. Энэ хууль тогтоомжийн хоорондын зөрчлийг арилгах ёстой байна. Түүнээс гадна хэрвээ нэр дэвшигчийн хувьд сонгууль өнгөрсний дараагаар эрх нь сэргэвэл энийг хэрхэн яаж шийдэх вэ гэдэг

үр дагаврын тухай асуудал байна. Хууль тогтоомжийн нэгдмэл хэрэглээний тухай асуудал байгаа болохыг мэдээлье.

Үүнээс гадна мэдээллийн ил тод байдлыг хангах тал дээр бид бас юу хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна. Энэ хүрээнд ХЭҮК-оос 2 байгууллагад албан шаардлага хүргүүлсэн. Хуулиар мэдээлэл өгөх ёстой гэдгийг нь хэлчихсэн. Нууцад хамаарахгүй, нээлттэй мэдээлэл мөн боловч хүссэн ТББ, иргэнд өгөөгүй гэдэг ийм гомдол гарсан. Тэгээд үүний мөрөөр сонгуультай холбоотой, сонгуулийн явцтай холбоотой, статистик мэдээлэлтэй холбоотой гаргасан шийдвэр, дүгнэлттэй холбоотой асуудлаар нээлттэй мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас хүссэн иргэн, хуулийн этгээдэд өгөх ёстой байна гэдгийг дахин сануулж байна. Ингээд энэ хүрээнд сонгох, сонгогдох эрхтэй холбоотой нийтдээ Улсын Их Хурлаар тогтоолд оруулахаар 7 саналыг тоймлон саяын дээр дурдсан дэд сэдвийн хүрээнд хүргүүлж байгаа боллоо. 1 дүгээр бүлгийн танилцуулга дууслаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа Сүнжид даргад. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн хүний эрх хамгаалагч, өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал сэдвийн хүрээнд 2 дугаар бүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сангишаравын Дондов танилцуулна. Ажлын хэсгийн хэд дэх микрофон уу? 2 дугаар микрофон өгье.

С.Дондов: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд тухайн жилийн хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлыг үнэлж, Улсын Их Хуралд тайлангаар хүргүүлнэ гэсэн ийм заалттай. Энэ хүрээнд, энэ хуулийн заалтад үндэслэн 2024 оны хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдал ямар байна вэ гэдэг асуудлаар хүний эрхийн хамгаалагчийн гол бүрэлдэхүүн болох сэтгүүлч, өмгөөлөгчдийн өнөөгийн нөхцөл байдлын талаар товч мэдээллийг та бүхэнд хүргэх гэж байна. Хүний эрхийн хамгаалагч, өмгөөлөгчийн эрхийн хэрэгжилтийн талаар өмгөөлөгч болон өмгөөлөгчтэй холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээ, нөхцөл байдал нь ямар байна вэ, өмгөөлөгч хүний эрх хамгаалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд явж байхад тулгамдаж байгаа асуудлууд нь юу байна вэ, мөн цаашид энэ дээр анхаарах санал ямар санал гаргасан бэ гэдгийг нь товч гаргасан байгаа.

Мөн хүний эрх хамгаалагч сэтгүүлчийн эрхийн хэрэгжилтийн хүрээнд мөн анализ хийж үзсэн. Ингэхдээ сэтгүүлчтэй холбоотой мөн хууль тогтоомжийн хүрээ, олон улсын стандарттай хэрхэн нийцэж байгаа, сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад нь тулгамдаж байгаа бэрхшээл, цаашид анхаарах асуудал, анхаарвал зохих асуудлын талаар гаргасан байгаа.

Хүний эрх хамгаалагчийн гол бүрэлдэхүүн болох өмгөөлөгчийн талаар бол үндсэндээ Өмгөөллийн тухай хууль 2019 онд шинэчлэн батлагдсан. Энэ дээрээ үнэндээ хүний эрх хамгаалагч болох гол субъект болох өмгөөлөгчийн прокурортой эн тэнцүү мэтгэлцэх үйл ажиллагаа явуулах энэ процесс нь Өмгөөллийн тухай хуулиар тодорхой хэмжээнд баталгаажсан хэдий ч процессыг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх гэх мэтийн хуулиудаар нарийн тодорхой зохицуулагдаагүйгээс өмгөөлөгч мэтгэлцэх үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байна гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн.

Сэтгүүл, дараачийнхыг нь явуулчих. Энэ бол үндсэн, ингээд үндсэндээ олон улсын индексээр Дэлхийн шударга ёсны төслөөс гаргаж байгаа эрх зүйн ёсны индексээр манайх 2024 онд 142 орноос 66-д, мөн эрүүгийнх нь болохоор зэрэг 142 улсаас 65-д, 58-д, иргэнийх болохоор зэрэг 65-д ингэж жагссан байна. Энэ нөхцөл байдлыг аваад үзэхэд учиргүй сэтгүүлчийн индексээс харьцангуй тэгж их доошлоогүй. Гэхдээ ер нь байх хэмжээндээ, байх хэмжээнээс доогуур байна гэж үзэж байгаа. Хүний эрх хамгаалагч болох гол субъект өмгөөлөгчийн хувьд асуудал юунд байна вэ гээд тэгэхээр зэрэг, цааш нь ингээд хэнээ явуулчхаарай. Тийм. Тэгээд ер нь өмгөөллийн үйл ажиллагаа явуулахад дарамт шахалт, айлган сүрдүүлэлт зэрэг хөндлөнгийн нөлөөлөл эрсдэлээс ангид хамгаалагдсан байх эрх төдийлөн сайн хангагдаагүй байна гэж гарсан. Тухайн энэ жилийн нөхцөл байдлыг гаргахын тулд бид нар тодорхой хэмжээний судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, энэ судалгаа дээрээ тулгуурлаж энэ тайланг хийсэн. Ингээд өмгөөлөгчийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан саатуулах, эрх чөлөөтэй байх эрхийг нь зөрчиж хязгаарлах асуудал манайд гардаг байна. Мөн өмгөөллийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсний төлөө зүй бусаар шийтгэхгүй байх баталгаа төдийлөн хангалттай хэрэгждэггүй гэсэн ийм дүн гарсан. Мөн өмгөөлөгчийг зөвхөн шүүх хуралд л өмгөөлөгчөөр оролцох ёстой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон иргэн, захиргааны хэрэгт оролцохоос гадна Үндсэн хуульд заасан өргөн бусад үйл ажиллагаанд төлөөлөх, бусад үйл ажиллагаанд иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, бусад байгууллагууд тухайн иргэнийг төлөөлөн оролцох боломжийг нь тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна. Тийм учраас өмгөөлөгч бүрэн дүүрэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ийм боломж хязгаарлагдмал байна гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

Өмгөөлөгчийн өөрийн хэрэгжүүлдэг үйл ажиллагааны чиглэлийн хувьд аваад үзвэл үндсэндээ өмгөөллийн үйл ажиллагаа бол нийтлэг ихэнх хувийг эзэлж байна. Үүнд хамгийн гол чухал байр эзэлж байгаа асуудал бол хууль зүйн туслалцаа, үйлчилгээ, зөвлөгөө өгөх асуудал байдаг юм байна. Пробоно үйлчилгээг манай өмгөөлөгчид нийгмийн сайн сайхны төлөө сэтгэл гаргаад энэ дээр түлхүү ажилладаг юм байна. Ингээд нийтийн эрх ашгийн өмгөөлөл явуулах ажилд идэвхийлэн оролцдог гэсэн нь энэ дээрээс харагдаж байна. Боловсролын түвшний хувьд аваад үзвэл өмгөөлөгчдийн хувьд харьцангуй ихэнх нь талаас дээгүүрх хувь нь магистр болон түүнээс дээш ийм боловсрол эзэмшсэн, хууль зүйн хувьд тодорхой хэмжээнд манай Монгол Улсад өмгөөлөгчийн чадвар чадавх сайн байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзсэн. Ингээд энэ дээр дурдагдсан байгаа баталгаануудаас хамгийн хэрэгжихгүй байгаа баталгаа юу вэ гээд ингээд үзэхээр зэрэг өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах, бусдаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах энэ баталгаа бол төдийлөн хангалттай биш байна гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн.

2 дугаарт өмгөөлөгчийг мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд нь ямар нэгэн байдлаар хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэх явдал их байна. Тэр дундаа улс төрийн нөлөөлөл, мөн төрийн өндөр албан тушаалтнуудын хэрэг төвөгт оролцоход төвөгтэй байдаг. Тийм учраас аль болохоор улс төрийн нөлөө бүхий хүмүүс болон төрийн өндөр албан тушаалтнуудын хэргийг авч өмгөөлөхөөсөө бид аль болохоор татгалздаг гэсэн ийм юуг гаргасан байгаа. Ингээд үндсэндээ 2024 онд хэдэн өмгөөлөгч шүүхээр шийдэгдсэн юм бэ гэдэг асуудлыг бид нар шүүхийн шийдвэрт нь анализ хийж үзсэн. Одоогийн байдлаар 21 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэгдээд, 9, 2 хэрэг шүүхийн шатад хэрэгсэхгүй болгож

цагаатгагдсан байна. 19 хэрэг бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Энэ бүхнээс үзэхэд нэг жилд 21 өмгөөлөгчийг эрүүгийн хэрэг үүсгээд, мөрдөн байцаалтын шатад хэрэгсээгүй зөвхөн шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхээр явж байна гэдэг өмгөөлөгчийн баталгаатай үйл ажиллагаа явуулахад хөндлөнгөөс нөлөөлөх, тэдэнд дарамт шахалт байна гэдгийг тодорхой хэмжээнд үнэлж үзэх үндэслэлтэй гэж ингэж үзсэн. Тэрний урдхыг нь явуулчих даа. Ингээд энэ бүхэнд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой эрхийн хэрэгжилтийг бүхэлд нь ингээд аваад үзвэл үндсэндээ судалгаанд оролцсон өмгөөлөгчдөөс 29, 30 орчим хувь нь ерөөсөө бидний эрх хангалттай хэрэгжихгүй байна гэсэн судалгаа гарсан. Дээр ямар шалтгаан байна вэ гээд тэгэхээр зэрэг Өмгөөллийн тухай хуульд бол тодорхой заалтууд орчихсон, бусад процессын хуулиудад заалт байхгүй учраас бид нар тэрэндээ төвөгтэй байдалд орж байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Дараагийнх нь юуг явуулчихъя.

Хүний эрх хамгаалагч сэтгүүлчийн хувьд яривал хүний эрх хамгаалагч бол сэтгүүлч яалт ч үгүй хүний эрх хамгаалагчийн гол бүрэлдэхүүн хэсэг болно гэж олон улсын хэмжээнд ч үздэг, манай Монголд ч гэсэн 21 онд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан цаг үеэс хойш хүний эрхийн хамгаалагч болох сэтгүүлчдийн гомдлыг хүлээж авах тэдэнтэй холбоотой хүний эрхийн болон бусад эрх нь зөрчигдсөн асуудлаар тодорхой хэмжээний гомдлуудыг шалгах, дүгнэлтүүдийг гаргах үйл явц явагдаж байна. Дараагийнх нь явуулчихаарай. Ингээд үндсэндээ судалгаанд оролцсон сэтгүүлчдийн нөхцөл байдлыг үнэлээд үзвэл сэтгүүлчдийн насны байдал яг жинхэнэ жагсаж яваа энэ насандаа сэтгүүлчийн үйл ажиллагаа хийж яваа гэдэг нь харагдаж байна. Эдгээр хүмүүсийн үйл ажиллагаанд бас мөн хөндлөнгөөс оролцох, тэдний үнэн бодитой мэдээллийг авахад нь саад учруулдаг, мөн төрийн байгууллагаас дамаа мэдээллүүдийг авахад хүндрэлтэй байдаг, хүнд суртал ихтэй байдаг, асуусан асуултад тодорхой хариулахгүй байх, үнэн, иргэдийн үнэн бодит мэдээллийг авах тэр эрхийг хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсдэг гэсэн ийм судалгаа гарсан. Дараагийнх нь явуулчихаарай.

Ингээд үндсэндээ хүний эрх хамгаалагч сэтгүүлчдийн үйл ажиллагааны эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ямар асуудлууд байна вэ гэхээр улс төрийн хараат байдал, хуулийн байгууллагаар шалгагдаж буйгаас үүсэж буй дарамтууд бид нарт байна. Мөн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хязгаарлалт байсаар байна. Сэтгүүлчдийн эсрэг сэтгэл санааны дарамт үзүүлэх, тэднийг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхах, тэр битгий хэл зарим үед хүчирхийллийн шинжтэй үйлдэл гарах хүртэл тохиолдол байна гэж ингэж сэтгүүлчид өөрсдөө судалгаанд ярихдаа, гарахдаа хэлсэн. Мөн санхүүгийн хараат байдал нь бидний үйл ажиллагаагаа хэвийн явуулах, олон нийтийн мэдэх эрхийг хангах, сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд төвөг учруулж байна гэж хэлсэн. Үндсэндээ хүний эрх хамгаалагч болох сэтгүүлчийн яг олон улсын хэмжээнд манай индекс бол маш муугаар үнэлэгдсэнийг эндээс бид бүхэн харж болно.

Тийм учраас энэ сэтгүүлчийн олон улсад Монгол Улсын сэтгүүлчдийн үнэлэгдэх өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд бид Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдлын тухай хуулийг олон нийтээр хэлэлцүүлсэн, сэтгүүлчдийн эрх ашигт илүү бодитой нийцсэн байдлаар батлан гаргах явдал бол манай индексийг тодорхой хувиар дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна гэж бодож байна. Эндээс үндсэндээ дэлхий даяар бол дайны байдалтай байгаа цаг үед

сэтгүүлчдийн, сэтгүүлчдэд аюул занал учрах явдал нэлээн эрс нэмэгдсэн илтгэлийн түгээмэл байгаа гэдгийг эндээс харж болно. Дараагийнх нь явчих. Хамгийн их сэтгүүлчдэд тулгарч байгаа эрсдэл, бэрхшээл нь юу байна вэ гээд тэгэхээр зэрэг энэ дээрээс хэдэн юунаас харж болно. Хамгийн их нь юу бол эрсдэл бол үнэндээ сэтгэл санааны дарамтад байнга байна. Хажууд нь эдийн засгийн хувьд тийм төдийлөн хангалттай биш учраас амьжиргаагаа төдийлөн сайн хангалттай аваад явж чадахгүй байна гэж ингэж үзэж байна. 2 дугаарт дарамт шахалт байна гэсэн энэ 2 асуудал дээр илүү түлхүү сэтгүүлчид санаа зовниж байгаагаа илэрхийлж байгаа. Тэгээд эндээс бусад юунуудыг эргүүлэн сайн харж болно гэж бодож байна. Үндсэндээ, наадхыг нь явуулчих тийм.

Тэгээд байдлаас үнэлээд үзэхэд өмгөөлөгч, сэтгүүлчдийн өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд төр цаашид ямар зүйл дээр анхаарах ёстой вэ гэдэг дээр бид үндсэндээ 7 саналыг Улсын Их Хурлаар, Улсын Их Хурал тогтоол болгон гаргахыг зорьж гаргасан байгаа. Бүлгийн санал дээр бид нар зайлшгүй анхаарах ёстой, тэр салбарт нь явцын дунд хэрэгжүүлбэл зохих ёстой саналуудыг нэлээн олон саналуудыг дээр гаргасан. Гэхдээ тэрнээсээ түүвэрлэж аваад бид бүхэн яг өмгөөлөгч, сэтгүүлчтэй холбоотой 7 санал.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Таны, цаашдаа цагтаа багтаахыг бодоорой. Цаг чинь дууссан байна. Танд 3 минут өгье дөө.

С.Дондов: Баярлалаа. Өмгөөлөгчийн хувьд үндсэндээ 3 саналыг бид бүхэн 1 дүгээрт өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ бие даасан байдлаар ганцаарчлан уулзах боломжийг тусгайлан анхаарах шаардлагатай байна. 2002 оны Өмгөөлөгчийн тухай хуульд өмгөөлөгч өөрийнхөө үйлчлүүлэгчтэй шууд уулзах энэ боломжийг нь хангасан байсан. Гэтэл одоо энэ хуулиар бол өмгөөлөгчийг заавал зайлшгүй шууд ингээд оролцоод, очоод уулзах боломжийг нь тодорхой хэмжээгээр хязгаарласан байна. Яагаад гэвэл шууд тантай уулзах боломжгүй байна, хүлээж бай ч гэдэг юм уу ийм байдлаар саатуулах явдал их байна гэж өмгөөлөгчид хэлж байна. 2 дугаарт ер нь ганцаарчлан уулзах боломжийг хангахгүй байна. Бидний цагдан хорих төв дээр очоод уулзаж байгаа юмыг бид нарын дундаас чагнаж байна. Энэ бол маш их ээдрээ төвөгтэй байна гэдэг юмыг сэтгүүлчид, үгүй ээ өмгөөлөгчид хэлж байна. Ингээд өмгөөлөгчийн мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлж шүүхэд үр дүнтэй оролцох, өөрийнхөө үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бодит боломжийг процессын хуулиудаар баталгаатай сайжруулах шаардлага байна гэж ингэж үзсэн.

Сэтгүүлчдийн тухайд үндсэндээ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлах нэн шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн 13, 14 дүгээр зүйл заалтыг харгалзан үзэх шаардлагатай байна. Магадгүй сэтгүүлчийн ярвигтай мартсан, санасан ч юм уу асуудлаас болоод үүсэж байгаа энэ асуудлыг ямар нэгэн байдлаар 13, 14-өөр эрүүгийн хэрэг үүсгэж, өөрсдийнх нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг нь алдагдуулж, хэргийг хэрэгсэхгүй болгон хааж байгаа нь олон асуудал байна. Тийм учраас энийг анхаарах хэрэгтэй гэж үзсэн. Мөн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд сэтгүүлч хариуцагч тал байгаа бол тухайн хүний нотлох баримтаа бүрдүүлж ирэх боломжид нь сэтгүүлчийн нууц, өөрийнхөө нууц мэдээллээ хамгаалах боломжийг нь олгосон зохицуулалтыг оруулж өгөх шаардлагатай байна гэсэн саналыг оруулсан. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Дондов гишүүнд баярлалаа. Хүний эрх ба цахим технологи болон цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл сэдвийн хүрээн дэх 3, 4 дүгээр бүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ганбатын Нарантуяа танилцуулна. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье, цагтаа багтаагаарай.

Г.Нарантуяа: Тэгэхээр илтгэл Их Хурлын гишүүдэд тараагдсан байгаа. Мөн энэ 2 бүлгийн үндсэн дүгнэлтийг хураангуйлаад манай Тамгын газрынхан танилцуулсан байгаа учраас би тэр болгоныг энд давтаж ярих нь шаардлагагүй гэж үзэж байна. Тэгэхээр Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын 24 дэх илтгэлийн 3 ба 4 дүгээр бүлэг болох Хүний эрх ба цахим технологи, цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл сэдвийн хүрээнд тулгамдсан Улсын Их Хурал, ЗГ-аас ялангуяа анхаарч шийдвэрлэх шаардлагатай хүний эрх, эрх чөлөөний асуудлыг танилцуулъя.

ХЗБХ-ны хүндэт гишүүд ээ, нэг өглөө сэрэхэд таны эрүүл мэндийн, санхүүгийн, гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, захидал, харилцаа таны зөвшөөрөлгүйгээр, танд мэдэгдэлгүйгээр цахим орчинд тараагдаж, энэ нөхцөл байдлыг бодитой шуурхай залруулах боломжгүй байдалд орвол та яах вэ. Цахим технологи, цахим орчин ашиглаж, таны болон ойр дотнын хүмүүсийн талаар илт худал мэдээлэл тарааж, сэтгэл санаа, эрүүл мэнд, эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан боловч гэмт этгээдийг олж тогтоох, зохих хариуцлагыг хүлээлгэх, учруулсан гэм хорыг нөхөн төлүүлэх институтын болон эрх зүйн боломж хомс байдал үүсвэл бид яах вэ. Энэ бол ирээдүй, зөгнөл биш, өнөөгийн бодит байдал, болзошгүй тохиолдол юм. 2024 оны 11 сард Интермед эмнэлгийн цахим сүлжээ кибер халдлагад өртөж, 230 мянга орчим хүний хувийн мэдээлэл алдагдаж, уг мэдээллийг цахим орчинд 50 мянган америк доллароор худалдах, мэдээллийг задруулахгүйгээр буцааж авах тохиолдолд барьцаа төлөх шаардлагыг тус эмнэлэгт тавьж, Монгол Улсын иргэдийн овог нэр, регистрийн дугаар, утасны дугаар бүхий мэдээллийг цахим cracking.com хуудсанд тавигдсаныг бид мэднэ.

25 оны 4 сарын 22-ны өдөр долоо хоногийн өмнө мөн энэ цахим хуудаст Монгол Улсын мөнгөн төлбөрийн үйлчилгээ эрхэлдэг компанийн 300 мянган үйлчлүүлэгчдийн банкны карт, харилцагч байгууллагууд бусад хувийн мэдээллийг багтаасан 20 орчим гега өгөгдлийг 25 мянган ам.доллароор худалдах санал тавигдсан байгааг өнөөдрөөс эхлээд олон нийт ярилцаж эхэлж байна. Тэгэхээр орчин үеийн нийгэмд хүний хувийн мэдээлэл бүртгэгдэхгүй орон зай гэж хомс болсон. Ухаалаг тодотголтой утас, гар утас, таблет, цаг, видео тоглоом, олон нийтийн сүлжээнээс өгсүүлээд орон байрны аюулгүйн систем, гэрэлтүүлэг, телевиз гээд ухаалаг цахилгаан хэрэгсэл, бүх төрлийн ахуйн цахилгаан бараа, олон нийтийн орон зайд суурилуулсан камерын хяналт, нийтийн интернэт, автомашины дугаараар хянах систем зэрэг нийтийн орон зайд суурилуулсан цахим технологиуд хүний амьдралын талаарх мэдээллийг тасралтгүй бүртгэн цуглуулдаг эрин цаг үед бид амьдарч байна.

Хүний амьдрал бүхэлдээ ямар нэгэн цахим төхөөрөмжид бүртгэгдэж буй гэхэд хэтрүүлэг болохгүй бидний эрин үед нэг эх сурвалжийн мэдээллийг нөгөө эх сурвалжийн мэдээлэлтэй холбон шинжилж, хүний хэн болохыг тогтоож, хувийн нууцад халдах боломжтой. Хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж ажилладаг бизнес моделиуд өнөө эрин үед өндөр ашиг олж, хүний хувийн мэдээлэл алдагдах, гэмт хэрэгт ашиглагдах тохиолдол нэн түгээмэл байна.

Мэдээлэл цуглуулж боловсруулдаг энгийн цахим төхөөрөмжийн зэрэгцээ хүнийг тагнах, мөрдөх, хувийн цахим хэрэгсэл дэх мэдээллийг зайнаас татан авах өндөр хүчин чадалтай төхөөрөмжүүд хэрэглээнд нэгэнт нэвтэрчээ. Хувийн мэдээлэл, хувийн нууц, хувийн орон зайг чанд хамгаалах нь хүн халдашгүй эрх чөлөөтэй оршихын үндэс билээ. Дарамт хавчлагаас эмээх айдас хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрмэлзлийг бөхөөж, төрийн үйл хэрэгт оролцох эрхийг хэлбэр төдий болгож, улмаар ардчилал хэврэгшдэг.

Хиймэл оюуны тооцооллын алдаа хүмүүс ялгаварлан гадуурхагдах, хэлмэгдэх нөхцөлийг үүсгэж, алгоритмын ил тод бус байдал нь гаргасан шийдвэрийг хянах, шүүхэд хандах, эрхээ сэргээлгэх боломжийг хязгаарлаж байна. Цахим технологийн хөгжлийн үр шимийг нийгмийн зарим бүлгийн хүмүүс эс хүртэж, тэгш бус байдал гүнзгийрч байна. Цахим технологийн эрсдэлээс иргэдээ хамгаалах нь хүний эрхийн асуудлаас гадна төр ба иргэдийн итгэлцлийг бэхжүүлэх улс оршихуйн үйл хэрэг юм. Ийм учраас ХЭҮК Монгол Улсын Их Хуралд Хүний эрх ба цахим технологи сэдвээр илтгэж байгаа юм. Монгол Улс дахь Хүний эрх чөлөөний төлөв байдлын 24 дэх илтгэлийн 3 ба 4 дүгээр бүлэгт хийсэн дүгнэлт, тэдгээрийн мөрөөр тавьж буй 12 санал нь ХЭҮК төдийгүй бидэнтэй хамтран ажилласан Монгол Улсын болон олон улсын, түүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг олон улсын олон талт байгууллагууд, Швейцар, Англи, Австрали, АНУ зэрэг гадаад улсын, гадаад улс орнуудын академик болон мэргэжлийн байгууллагуудын шинжээчдийн 2 жил шахуу хугацаанд явуулсан судалгаа, үнэлгээний эхний үр дүн болно.

Илтгэлийн 3 дугаар бүлэгт цахим хөгжлийн суурь нөхцөлүүд болох бодлого, эрх зүйн орчин, засаглал, технологийн нэвтрэлт, иргэдийн цахим ур чадвар, цахим боловсрол, кибер аюулгүй байдлын асуудлыг хүний эрхийн үүднээс үнэлж, Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын хөгжил эхлэл шатдаа хэрэгжилт хангалтгүй, ялангуяа хүний эрхийн эрсдэлийг бүрэн тооцохгүй, нэн шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ үгүйлэгдэж байгааг анхааруулсан болно. Мөн бүлэгт олон нийтийн орон зай дахь камерын хяналт, зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох цахим гав, тагнах төхөөрөмжийн эрх зүйн зохицуулалтад анхаарах хүний эрхийн асуудлууд, Монгол Улс дахь хиймэл оюуны хөгжүүлэлт, хэрэглээний нөхцөл байдал, хиймэл оюуны үндэсний стратегид тусгавал зохих хүний эрхийн зарчмуудыг танилцуулж, Монгол Улсад цахим хуваагдал бодитой оршиж байгааг илтгэлээ.

Илтгэлийн 3 дугаар бүлгийн сүүлийн хэсэгт, 3 хэсэгтээ дотроо Цахим хөгжлийн эриний газрын тос гэгдэж буй хувийн мэдээллийг хамгаалах Монгол Улсын хууль зүйн үндсэн баталгаа болох Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хийдэл ба хэрэгжилтийг үнэлсэн. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар мэдээллийн эзэн, мэдээлэл хариуцагчийн мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагчийн үүргийг дэлхийн жишигт баталгаажуулсан боловч эрх зөрчигдсөн, үүргээ биелүүлээгүй үед хүлээлгэх хариуцлага албадлагын арга хэмжээг хэлбэрийн төдий тогтоосон нь уг хуулийг тунхаг болгож байна. Мөн цахим технологи хүний нийгмийн мөн чанарыг өөрчилж байгаа цаг үед мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг Монгол Улс зохих ёсоор бий болгож хөгжүүлэх нь чухал болохыг мөн анхаарууллаа. Илтгэлийн 3 дугаар бүлэг нь Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалтаар хүлээсэн тус комиссын чиг үүргийн хүрээнд хийсэн үнэлгээ болохыг мэдэгдэх нь зүйтэй.

Монгол Улс дахь Хүний эрх чөлөөний төлөв байдлын 24 дэх илтгэлийн 4 дүгээр бүлэг Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр бүлгийг, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтад заасан чиг үүргийн хүрээнд мөн илтгэж байгаа. Жендерээс үүдэлтэйгээр бусдын бие махбод, бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн засгийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл эс үйлдэхгүйг жендерт суурилсан хүчирхийлэл гэж нэрлэдэг. Харин мэдээлэл харилцаа холбооны технологи болон бусад цахим хэрэгсэл ашиглан энэ төрлийн үйлдлийг үйлдэхийг цахим технологи ашиглан үйлдэж байгаа жендерт суурилсан хүчирхийлэл гэж олон улсад тодорхойлдог. Энэ илтгэлд мөн энэ тодорхойлолтыг барьж нөхцөл байдлыг үнэлсэн.

Тэгэхээр цахим хөгжлийн нэг сүүдэр бол яахын аргагүй цахим технологи ашиглан үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийллийн асуудал юм. Олон нийтийн сүлжээ, цахим орчинд цахим технологи ашиглан хүний нэр төрд халдах, гүтгэх, доромжлох, өдөөн хатгах, мөрдөн мөшгөх, садар самуун зураг, бичлэг илгээх, дарамтлах, дээрэлхэх, уригдах зэрэг үйлдэл түгээмэл гарч байна. Ийм гэмт үйлдэл, үйлдэлд эмэгтэйчүүд, хүүхдүүд улам өртөмтгий байж жендерт суурилсан хүчирхийллийг дэвэргэж, агуулга, хэлбэрийг нь өөрчилж байна. Харин энэ шинэ нөхцөл байдалд Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон гэмт хэргийг мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх тогтолцоо бэлэн биш байна. Цахимжилтын суурь асуудлууд, тулгамдсан тодорхой асуудлыг хамруулж, өргөн хүрээтэй боловсруулсан хүний эрх ба цахим технологи, цахим технологи ашиглан үйлдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл сэдвүүдэд тусгасан тодорхой асуудлаар та бүхний асуултад хариулахдаа таатай байна.

Цахим хөгжлийг хүнд ээлтэй явуулах, цахим технологийн хүний эрхийн эрсдэлээс иргэдээ хамгаалах оновчтой бодлого гаргах, эрх зүй, институтийн орчин, нийгмийн суурь нөхцөлийг бий болгох, бэхжүүлэхэд Улсын Их Хурал идэвхтэй, ажил хэрэгч арга хэмжээ авна гэдэгт итгэж байна. Шинэ сорил энэ чухал үйл хэрэгт ХЭҮК бүх талаар хамтран ажиллаж, зөвлөн туслах эрмэлзэлтэй байгаагаа мөн илэрхийлж байна. Ингээд хэрвээ надад цаг байгаа бол би комиссын даргын эхний илтгэлд бүх саналуудыг танилцуулах байх гэж бодсон. 12 саналаа уншиж танилцуулбал чухал байх гэж бодож байна. Тэгэхээр цахим технологи ба хүний эрх бүлгийн хүрээнд 8 саналыг Улсын Их Хуралд тавьж байгаа.

Энэ нь цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах, уг аргачлалаар нэн тэргүүнд төрийн үйлчилгээ үйл ажиллагаанд нэвтрүүлж буй аливаа технологи, систем, платформ алгоритмыг үнэлэх зохицуулалтыг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд тусгах. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар тогтоосон мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн үүргийн зөрчлийг Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд бүрэн тусгаж гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх. 3 дахь санал улам бүр нэмэгдэх үүрэг хариуцлагыг нь тооцоолж, дэлхийн нийтийн түгээмэл чиг хандлагын дагуу хүний хувийн мэдээллийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл хамгаалах эрх бүхий бие даасан байгууллагыг ЗГ-ын бүтцэд байгуулах, бэхжүүлэх талаар үе шаттай хэрэгжүүлэх бодлогыг тогтоох. 4 хүнийг тагнах, мөрдөн мөшгөх боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмж,

нийтийн болон хувийн орон зайд байрших дууны, дүрсний, дуу, дүрсний бичлэгийн систем, хүний биометрик.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Танд 3 минут өгчихье, багтаагаад дуусгачихъя.

Г.Нарантуяа: Баярлалаа. Халдашгүй чөлөөтэй байх эрх чөлөөг хамгаалах. 5.Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалт, хүн төвтэй ялгаварлан гадуурхалтаас ангид, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг энэхүү илтгэлд тайлбарласан агуулгаар үндэсний хиймэл оюуны стратегид тусгах, улмаар Монгол Улсад хөгжүүлэх, ашиглахыг хориглох хиймэл оюуны төрөл, зорилгыг тогтоосон хиймэл оюуны хөгжүүлэлтэд, хөгжүүлэлт, ашиглалтад хүний эрхийг хангах удирдамжийг батлах. 6.Нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, нөгөө талаас худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэх илэрхийлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хоруу контентыг хязгаарлах, зохист тэнцвэрийг хангасан байдлаар олон нийтийн сүлжээг зохицуулах бодлогыг тодорхойлох. 7.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай болон хөдөөгийн өрх, Монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн практик ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинжлэх ухааны дэвшлийн үр шимээс хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг сөрөх бодлогыг батлах, хэрэгжүүлэх. 8 дахь санал Ковид 19 цар тахлын үеэр цугларсан хувийн мэдээллийн сан, түүний ашиглалтыг Засгийн газар Дотоод хяналтын хүрээнд хянаж, үр дүнг Улсын Их Хуралд танилцуулах гэсэн 8 саналыг 3 дугаар бүлгийн хүрээнд.

4 дүгээр бүлгийн хүрээнд цахим технологи ашиглан үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийллийн үйлдэж буй арга хэлбэр, хор уршиг, хохирол, хохирогчийн онцлогийг нарийвчлан судалж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуульд энэ төрлийн гэмт хэрэгтэй, гэмт үйлдэлтэй үр дүнтэй тэмцэх шаардлагыг хангахуйц нэмэлт, өөрчлөлт оруулах. Эрүүгийн хуулийн 14.1, 10.4 хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 11.7 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 13.1 хүн худалдаалах, 13.5 заналхийлэх, 13.12 хууль бусаар мөрдөн мөшгөх зэрэг гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байдалд цахим орчныг ашигласан үйлдлийг, үйлдлийн шинжийг нарийвчлан тусгах. 3.Цахим технологи, цахим орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлалыг боловсруулж, үе шаттай сургалт явуулах замаар цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон улсын олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх. 4.Цахим жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүүхэд, эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан мэдээлэл нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөж, бүх үүрэг хүлээгч талуудыг оролцуулан хэрэгжүүлэх. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Нарантуяа гишүүнд баярлалаа. Одоо, энэ 2 бүлгийг танилцуулсан Нарантуяа гишүүн тийм үү 3, 4-ийг. Тийм учраас одоо цаашдаа гайгүй явчихна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд 5 дугаар бүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан танилцуулна. Ажлын хэсгийн 4 дэх микрофон, цагтаа багтаана шүү.

Ж.Хунан: ХЗБХ-ны эрхэм гишүүдэд өдрийн мэндийг дэвшүүлье. Комисс 24 дэх илтгэлдээ энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудлыг хөндөж байгаа. Энэ хүрээндээ 2 зүйлийг онцлон тухайлан тэмдэглэж байна. Нэг нь насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн өсөлт маш хурдацтай явагдаж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар жил болгон өссөн ийм үзүүлэлттэй байгаад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байна. Тэр дундаа 14 насанд хүрээгүй буюу бага насны хүүхэд хохирогч болж байгаа тохиолдол маш өндөр байгаад бүгдээрээ шат шатдаа дүгнэлт хийж, энэ дээр арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна гэж байгаа юм. Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой судалгаанууд хийгддэг боловч эдгээр судалгаануудын үр дүн их хязгаарлагдмал хүрээнд ашиглагдаж, байгууллагуудын хоорондын уялдаа холбоо байхгүйгээс энэ бол үр дүн ерөөсөө гарахгүй, хэрэгжилт бол хангалтгүй байгаа гэдэг ийм дүгнэлтийг комиссоос хийж байгаа.

Бэлгийн хүчирхийллийн гол шалтгаан нөхцөл нь ядуурал, ажилгүйдэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн тогтворгүй байдал, сургууль завсардалт, эцэг, эхийн хайр, халамж анхаарал дутах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчил, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгчдийн таагүй харьцаа, найз нөхдийн сөрөг нөлөө, хяналтгүй цахим хэрэглээ, бэлгийн гаж зан үйлтэй холбоотой этгээдүүдэд тавих хяналт сул байгаатай гэж үзсэн байдаг. Тиймээс энэ асуудлыг онцгойлон анхаарч, хүүхэд багачуудаа хамгаалах хэрэгцээ шаардлага байна гэж харж байгаа. Насанд хүрээгүй бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаатай холбоотойгоор нэг асуудал бол анхаарал хандуулж, анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ нь юу вэ гэхлээр бэлгийн бойжилт эрт эхэлж байгаатай холбоотой үүсэж байгаа нөхцөл байдал. Өөрөөр хэлбэл өнөөдөр сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй эрэгтэй 39 хүүхдээс 17 хүүхэд нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр хүмүүжиж байгаа. Энэ нь 14-өөс доош насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг бол хэлбэрийн болоод агуулгын шинж шаарддаггүйтэй холбоотой гэж үздэг.

Тэгэхээр хуульчид, судлаачид, эрдэмтэд бэлгийн бойжилт эрт эхэлж байгаатай холбоотойгоор энэ зүйл, заалтын энэ гэмт хэргийн, энэ төрлийн гэмт хэргийн шинж агуулгыг дахин эргэж харах шаардлагатай байна. Эс тэгвээс хүүхдүүд хоорондоо үерхээд, сайн дурын үндсэн дээр бэлгийн харьцаанд орж хохирогч гэмт хэрэгтэн болж байгаа явдал сүүлийн үед эрс нэмэгдэж байгаа гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Насанд хүрээгүй хүүхэд, ялангуяа бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах ажлын хүрээнд бэлгийн боловсрол өөрийгөө болон бусдыг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг чадавхыг эрт буюу зохих наснаас нь олгох, олгож эхлэх шаардлага байна. МУИС-ийн Жендер судлалын төвөөс хийсэн судалгаагаар 6-аас 12 дугаар ангийн хүүхдүүд дунд явуулсан судалгаанд оролцсон 18 мянга гаруй хүүхдээс жендерийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг асуухад 1700 гаруй хүүхэд садар самуун зураг бичлэг илгээх үйлдэлд өртөж байсан. Мөн 1226 хүүхэд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох ийм халдлагад өртөж байсан, мянга зургаан зуу, 1064 хүүхэд секс илэрхийлэл бүхий дүрс бичлэг хийх, түгээх ийм үйлдэлд өртөж байсан. Тэгэхээр энэ нь юуг хэлж байна вэ гэхлээр энэ бид нар бэлгийн боловсролыг эрт цагаас буюу 12 наснаас нь эхэлж олгож, хүүхдүүдийг өөрийгөө хамгаалах бэлгийн боловсролыг олгох зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгтэй холбоотой нэг зүйлийг онцгойлон анхаарах шаардлагатай. Энэ нь судлаачдын илтгэл, судалгааны дүгнэлтэд ч гэсэндээ нэлээдгүй орсон. Энэ нь бэлгийн, бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж таашаал авдаг бэлгийн гаж зан үйл буюу педофил энэ асуудлыг зохицуулах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг олон тооны судалгаанд дурдагдсан байдаг. Манай улсад бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэгтнийг педофилийн эмгэгтэй эсэхийг тодорхойлдог, тогтоодоггүй, тогтоодог арга, журам байдаггүй. Дээрээс нь шаардлагатай сэтгэл зүйн болон эмчилгээ хийх ийм зохицуулалт байхгүй. Дээрээс нь педофил эмгэгтэй хүмүүс ял эдэлж дууссаны дараа гараад тэд нарт тавих хяналт бүртгэл байдаггүй. Өөрөөр хэлбэл энэ педофилийн зохицуулалт байхгүйтэй холбоотойгоор мөн бага насны хүүхдүүд өртөх, дахин өртөх ийм эрсдэл байна гэж харж байгаа. Бага насны хүүхдүүдийн бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа энэ явдлыг таслан зогсоох, илрүүлэх ажил учир дутагдалтай байгаа. Энэ нь магадгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маань өөрөө хүүхдэд ээлтэй биш байгаатай холбоотой гэж үзсэн. Энэ хүрээнд ХЭҮК-оос шийдвэрлэгдсэн 40 хэрэгт дүн шинжилгээ хийсэн байгаа.

Тэгээд эндээс ямар дүгнэлтийг хийж байна вэ гэхлээр энэ мэдүүлэг авах ажиллагаа үндсэндээ хүүхдэд ээлгүй, хүүхдийг залхаан цээрлүүлэх ийм байдлаар хийгддэгтэй, хийгддэгээс хүүхдүүд энэ талаар гомдол гаргадаггүй, хуулийн байгууллагад ханддаггүй. Дээрээс нь гомдол хүсэлт мэдээллээсээ татгалздаг байж болзошгүй гэдэг ийм дүгнэлтийг хийж байгаа. Дээрээс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдээс мэдүүлэг авч байгаа хугацаа, мэдүүлэг авч байгаа хүний хүйсийн байдал, дээрээс нь давтамж, асуултууд их хүндрэл учруулдаг. Хүүхдийг давхар хохироох ийм нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзсэн. Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хавтаст хэргийн 21 хэрэгт нь, 21 хэрэгт мөрдөгч мэдүүлгийн тэмдэглэл болон эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан худал мэдүүлэг өгсөн бол хариуцлага тооцох талаар сануулж эрх, үүргийг тайлбарласан баталгааны хуудаст гарын үсэг зуруулсан байдаг. Тэгэхээр энэ бол шаардлагагүй дарамт хүчийг хүүхдэд харуулж байгаа. Үүнээс шалтгаалж хүүхэд улам айдаст автах, түгшүүрт орох, ингэснээрээ үнэн зөв мэдээлэл өгөхгүй байх ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Дээрээс нь эсрэг хүйсийн хүн мэдүүлэг авч байгаа тохиолдолд мөн хохирогч хүүхдэд их таагүй сэтгэгдлийг төрүүлж, айдас түгшүүрийг бий болгодог байгаа. ОУБ-ын зүгээс мөрдөгч төдийгүй шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдыг хохирогч хүүхэдтэй ажиллахдаа ижил хүйсийн байхыг зөвлөдөг. Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэргээс 31 удаагийн мэдүүлэг авсан тохиолдолд эмэгтэй мөрдөгч байсан, 112 тохиолдолд эрэгтэй мөрдөгч байсан гэдэг ийм дүгнэлт таамгийг дэвшүүлсэн гаргасан. Мэдүүлэг авах хугацааны хувьд хуулиар 2 цаг гэж байгаа болов бидний хийсэн дүн шинжилгээний явцад 2 цагаас илүү хугацаагаар мэдүүлэг авах ийм ажил үргэлжилсэн ийм дүр зураг байсан. Тэгээд тасралтгүй 2 цаг түүнээс дээш цаг мэдүүлэг авах нь өөрөө хүнлэг бус ийм харьцаа, тэгээд хүүхдийг дахин хохироож байгаа ийм асуудал.

Мэдүүлгийн давтамжийн хувьд бас анхаарал татаж байгаа. Энэ дээр дүгнэлт хийх шаардлагатай. 40 хэргийн 7 хэрэгт нь мөрдөгч солигдоогүй, өөрөөр хэлбэл нэг удаа мэдүүлэг авсан байдаг. 10 хэрэгт 2 удаа мөрдөгч солигдсон, 16 хэрэгт мөрдөгч 3 ба түүнээс дээш удаа солигдсон ийм байдалтай байгаа, байсан.

Тэгэхээр мөрдөгч солигдох тохиолдол бүрд хүүхэд, хохирогч хүүхэд бол өөрт болсон явдал дээр өөр, өөр мөрдөгч мөрдөгчид хэлэх ийм ярих шаардлага гардаг. Энэ нь эргээд дахин сэтгэл зүйн таагүй байдалд хүүхдийг хохирогч хүүхдийг оруулдаг. Тийм учраас энэ мэдүүлэг авах давтамжийг багасгах, энийг ОУБ-аас ч гэсэндээ энийг багасгах ийм зөвлөмжийг өгдөг. Мэдүүлгийн асуулт насанд хүрсэн хохирогчоос асуудаг асуулттай ижил. Дээрээс нь хүүхдийн сэтгэл зүйн байдлыг харгалзахгүй, дээрээс нь нас сэтгэхүйн хөгжлийн үе шаттай харгалзаж, тэнд нийцүүлсэн асуулт асуухгүй, асуудаггүй явдал нийтлэг байгаа. Тэгэхээр энэ зохисгүй асуулт асууснаас болж хүүхэд дахин гэмтэх, дээрээс нь болсон явдлын талаар үнэн бодитой мэдээллийг ярихгүй байх ийм нөхцөл байдал бий болдог. ОУБ-ын зүгээс хүүхдийн, хүүхдээс асуух асуултыг нээлттэй байх тийм гэж, тийм, үгүй гэж хариулах боломжтой эсвэл хөтөлсөн асуулт.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 2 минут өгчихье.

Ж.Хунан: Баярлалаа. Үндсэндээ мэдүүлэгтэй холбоотой ийм асуудлуудыг комисс хөндөж байгаа. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхэд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлж чадахгүй ийм нөхцөл байдал бий болж байна. Учир нь 2017 оноос хэрэгжиж эхэлсэн, хэрэгжиж эхэлсэн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмгөөлөгч авах асуудлыг хууль ёсны төлөөлөгч эцэг, эхийн хүсэлтийг үндэслэж зохицуулалт хийдэг болсноос хүүхдүүд өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, дээрээс нь бусад эрх буюу хохирлоо барагдуулах асуудал орхигдож байгаа ийм нөхцөл байдал бий болсон. Комиссоос хийсэн дүн шинжилгээнд 21 хэрэгт нь өмгөөлөгчгүй оролцсон ийм явдал байгаа.

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдэд учирсан хохирлыг бүрэн дүүрэн тооцож шийдвэрлэдэггүй ийм практик хэвээр байна. Бие махбодын хүчирхийллээс гадна сэтгэл санааны хохирлыг бүрэн шийддэггүй. Сэтгэцэд учирсан хохирлыг тооцдог болсон боловч энэ бол хангалттай хэмжээнд шийдвэрлэгдэхгүй байгаа ийм явдал байна. Хүүхэд хамгааллын нэлээдгүй бүтэц бол хүүхдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх ийм боломжтой байдаг боловч өнөөдрийн байдлаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн оролцоо хангалтгүй байгаагаас хүүхэд хохирч байгаа ийм тохиолдлууд цөөнгүй байна. Эдгээр нөхцөл байдал, эдгээр тоо баримтыг үндэслэж, ХЭҮК-оос дараах 9 саналыг гаргаж байна.

Үүнд, насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллага.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минутад багтаагаад үлдээгээд саналаа голыг нь хэлчихье.

Ж.Хунан: Төлөөллийг оролцуулан дэлгэрэнгүй хийх, судалгааны үр дүнг үндэслэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг шинэчлэх. 2.Педафил буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж таашаал авдаг гаж зан үйлийн эмгэгтэй гэмт хэрэгтэнд, гэмт хэрэгт холбогдогчид сэтгэцийн шинжилгээ хийх журам, төрлийн эмгэгийг оношлох,

эмчлэх, эмгэгтэй хүнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалсан дахин хохирохоос урьдчилан сэргийлсэн тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан бий болгох. 4.Насанд хүрээгүй болон бага насны хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг мэргэжлийн бэлтгэгдсэн сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтнаар ярилцлага хийлгэх замаар дагнан нэг удаа чанартай, шуурхай явуулж, үүнийг дуу, дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцох хуулийн зохицуулалтыг бий болгох. Хүүхдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн газраас өөр тайван, хүүхдэд аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орчинд авах зохицуулалтыг хийх. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярлалаа, 3 минут нэмж өгсөн. Хунан гишүүнд баярлалаа. Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд 6 дугаар бүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд. Сүүлийн танилцуулга, ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

Б.Энхболд: Эрхэм ХЗБХ-ны гишүүдээ та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Шударгаар шүүлгэх эрхийн агуулга нь аливаа хүн эрүүгийн хэрэгт татагдсан үеэс эхлэн ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх үеийг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм. Гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүнтэй мөрдөн шалгах шүүх эрх мэдлийн байгууллагууд хэрхэн харьцаж байгаа болон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэж, хамгаалж байгаагаас тухайн улс орон дахь хүний эрх, эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар түвшинд хүрснийг илэрхийлэх шалгуур үзүүлэлт болдог. Монгол Улсын ХЭҮК-т 2024 онд ирсэн гомдол мэдээллийн 52,9 хувь нь шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл эзэлж байх ба агуулгаар нь авч үзвэл эрүү шүүлтээс ангид байх эрх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх, хилс хэрэг хүлээлгэсэн, хууль бусаар цагдан хоригдсон, орон байрны халдашгүй байдалд халдсан, гэмт хэрэг үйлдсэн мэтээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд зарласан, шүүх эрх мэдэл болон мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон зэрэг гомдлууд эзэлж байна.

Эрүү шүүлтийн нөхцөл байдлын талаар. 2017-гоос 2024 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар хууль хяналтын байгууллагуудад 414 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс 275 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. 2017-гоос 2014 оны хооронд нийт 33 хүнд холбогдох 16 хэргийг хянан шийдвэрлэж, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт цагдаагийн байгууллагын 24, тагнуулын байгууллагын 5, авлигатай тэмцэх газрын 1, прокурорын байгууллагын 1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1 албан хаагч, олон нийтийн цагдаа 1 тус тус холбогдон эрүүгийн хариуцлага хүлээсэн байна. Үүнээс 23 хүнд торгох ял, 6 хүнд хорих ял оногдуулж, 1 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 3 хүнийг Өршөөл үзүүлэх хуульд хамруулж шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хариуцлага хүлээсэн байдлаас үзэхэд эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хүлээлгэх ялын бодлого сул, ихэнх тохиолдолд торгох, нийтийн албанд ажиллах эрхийг хасах, зарим тохиолдолд өршөөл үзүүлэн суллаж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл ихэвчлэн камерын хяналтгүй орчинд, удирдах албан тушаалтны хяналт суларсан, хот,

суурин газраас алслагдсан газарт бие даан үйл ажиллагаа явуулж байхдаа үйлдсэн, ажлын ачаалал, стресс зэрэг хүчин зүйл нөлөөлсөн бол зарим тохиолдолд удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгаврыг биелүүлсэн, хариуцлага хүлээхгүй, эрүүдэн шүүсэн нь илрэхгүй гэсэн итгэл үнэмшил нөлөөлжээ. Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагууд бие биеэ шалгах зохицуулалт өнөөг хүртэл үйлчилж байгаа, ялын бодлого сул, мөрдөгч, прокурор, шүүгч, хорих байгууллагын албан хаагчдын талаарх мэдлэг, хандлага сул, нотлох ажиллагааны арга барил дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Мөн хорих анги байгууллагуудад хүнтэй хүнлэг бус харьцах явдал гарсаар байна. Гомдол мэдээллээс үзэхэд ХЭҮК-т ирсэн гомдол мэдээллийн 27,5 хувь нь хорих анги, цагдан хорих байранд хоригдож байгаа хүнээс ирсэн байна. Үүний 33 аравны, 33 буюу 9,2 хувь нь халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудлаар хандсан байна. Хүний эрх чөлөөнд халдах, хүнлэг бус хэрцгий харьцах явдал хорих анги, цагдан хорих байруудад удаа дараа гарч байгаагаар Комисс гомдол мэдээллийн мөрөөр шалгах ажиллагаа явуулж, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гомдол мэдээллийг холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэж байгаа хэдий ч жилд дунджаар 2 гомдол мэдээлэл шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг гэсэн статистик судалгаа байна. 2002 онд, 22 онд хорих ангид ял эдэлж байсан 1142 хоригдлоос авсан санал асуулгын дүнгээс алба хаагчдын зүгээс хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг доромжлон харьцдаг гэж 22,5 хувь нь хариулж байсан бол 2024 онд 274 хоригдлоос авсан санал асуулгад 27 хувь нь мөн тийм гэж хариулсан нь энэ үзүүлэлт 4,5 хувиар өссөн байгааг харуулах үзүүлэлт юм.

2.Мэдүүлэг авах үеийн хүний эрхийн асуудал мөн анхаарал татсаар байна. Мэдүүлэгт суурилсан нотлох ажиллагааны арга барил, мөрдөн шалгах ажиллагааны үндсэн арга хэлбэр хэвээр байгаа нь эрүүдэн шүүх нөхцөл байдлыг эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мэдүүлэг авах үед гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүнээс гэм буруугаа өөрөө нотлохыг шаардах, мэдүүлэг авахаар албадах, камерын хяналтгүй зориулалтын бус өрөө, тасалгаанд мэдүүлэг авах, албан ёсны мэдүүлэг эхлэхээс өмнө өмгөөлөгчгүйгээр уулзалт хийх, ярилцлага хийх, гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхийг тулгах хандлага гарсаар байгааг шүүмжлэн илтгэлдээ дурдсан. 2016-аас 24 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт гэмт хэргийн 60 гаруй хувь нь үндсэндээ мэдүүлэг авахыг албадсан ийм арга хэлбэрээр үйлдэгдсэн байгааг анхаарах нь зүйтэй.

Мөн мэдүүлэг авах ажиллагааны явцад хойшлуулшгүй тохиолдол үүсээгүй байхад ажил, амралтын өдөр, шөнийн цагаар мэдүүлэг авахаар дуудах, энэ тухайгаа ар гэрийнхэнд нь мэдэгдэх, таагүй нөхцөл байдал үүсгэх, хэл, хүүхэд, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсээс мэдүүлэг тайлбар авахдаа хүний эрхийн мэдрэмжгүй хандах, өөрт нь хэлмэрч орчуулагч олохыг даалгах зэрэг зөрчлүүд 2023, 2024 онуудад гарсныг энд дурдаж байна. Мөн сэтгэцийн шинжилгээний хүрээнд сэтгэцийн шинжилгээ хийх нарийвчилсан журам тогтоогүй, хүнээс сэтгэцийн шинжилгээг авахдаа ямар арга хэлбэр, процессыг нарийвчлан тогтоогоогүйгээс хүний хувийн халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөх, нэр төр, алдар хүнд нь гутаагдах явдал мөн гарч байгааг засаж залруулах шаардлага байна. Мөн зарим төрлийн сэтгэцийн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх замаар ялангуяа онц хүнд гэмт хэргийн, хэргээс урьдчилан сэргийлэх,

хариуцлагыг үр нөлөөтэй шийдвэрлэх шаардлага тулгарч байгааг судалгааны үр дүнгээс харагдаж болохоор байна.

Мөн төрийн нууцтай холбоотой хэрэг маргаан, нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл, санал хүсэлт комисст удаа дараа ирж байгаа ч шалгах ажиллагаа явуулж, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин дутмаг байна. Комисст авагдсан мэдээ, баримт мэдээллээс үзэхэд төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан гэсэн шалтгаанаар шүүх хуралдааныг хаалттай явагдах, нотлох баримт шалгуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, оролцогчдод танилцуулахгүй байх, нууцын баталгаа авч, өмгөөллийн үйл ажиллагааны цар хүрээг хумих, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болгож, хавтаст хэргийн материалд хамааралгүй төрийн нууц, түүнд хамаарах мэдээ баримтыг хавсаргаж, хэргийг бүхэлд нь нууцад хамааруулах зэрэг нөхцөл байдал илэрч байгаа нь шударгаар шүүлгэх эрхийг хөндөхөд хүргэж байна.

Мөн төрийн нууцтай холбоотой хэргийг хурдан шуурхай шалгаж байгаа боловч зарим хэргүүд дээр төдийлөн ижил түвшинд үйлчлэхгүй байна. Тухайлбал сэтгүүлчтэй холбоотой төрийн нууц задруулсан хэргийг маш шуурхай шалгаж, илрүүлж холбогдох хариуцлагыг хүлээлгэсэн боловч төрийн нууцыг задруулсан хүнд өнөөдрийг хүртэл хариуцлага оногдуулаагүй асуудал үргэлжилж байгааг шүүмжлэлтэй хандаж байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хувийн нууцыг задруулах гэмт хэрэг үйлдсэн мэтээр олон нийтэд зарлах, эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнөх үе шатуудад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гэмт хэргийн нууцыг задлах хандлага түгээмэл байгааг засаж залруулах шаардлага байна гэж үзсэн. Мөн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжүүлэхдээ цагдан хорьж байгаа үндэслэлийг оролцогчид бодитойгоор танилцуулах, шүүх хуралдааныг өмгөөлөгч болон прокурорын тэгш, эрх тэгш мэтгэлцээний зарчим дээр явуулдаггүй хандлага өнөөг хүртэл үргэлжилсээр байгааг засах шаардлагатай байна. Мөн цагдан хорих байранд хоригдож байгаа хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг шуурхай, тасралтгүй явуулахгүй байх, жирэмсэн эмэгтэй, хүүхдийн асуудалд анхаарал хандуулах шаардлага мөн сул байгааг энэхүү илтгэлд баримттайгаар дурдсан болно. Мөн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар үе шаттай арга хэмжээ авч байгаа боловч цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг сунгах шүүх хуралдаанд өмгөөлөгч, цагдан хоригдсон хүний аль аль нь оролцохгүйгээр хэргийг өмнө нь авсан баримтад нь тулгуурлан сунгах явдал түгээмэл байгааг засах шаардлага байна гэж үзсэн.

Түүнчлэн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрхийг хүндэтгэхгүй, ар гэрт нь байгаа өндөр настай, хүүхэд, хараа хяналтгүй орхигдсон хүүхдийн асуудлыг мөн нэг мөр хэрэгжүүлж чадахгүй байгааг шүүх цаашид анхаарах шаардлага байна гэж үзсэн. Мөн хилээр гарах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт оновчгүй, шүүх, прокурорын байгууллагын үүргийг тодорхой хуульчлаагүйгээс иргэд хохирох хандлага түгээмэл байна. Тухайлбал бид бүхний мэддэг ногоон автобусны гэх хэрэгт холбогдсон БНСУ-ын иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосноос хойш 4 сарын хугацаанд хилээр орох эрхийг нь хязгаарлаж, сэтгэл санааны болон бие махбодын шаналал зовуурьд оруулсан энэ кэйс 2024 онд бий болсон бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болсноос хойш 5 сарын дараа Монгол Улсаас гарч явсан энэ кэйс дахин үргэлжлэх нөхцөл байдал хэвээр байна. Мөн хорих ялыг

оногдуулах хандлага буурч байгаа боловч өнөөдөр хорих ангид ял эдлэгсдийн тоо нэмэгдэж байна. 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 4590 хүн хорих ял эдэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0,6 хувиар өссөн нь хорих анги дахь хүнлэг бус, хэрцгий харьцах, эрүүдэн шүүх нөхцөл байдал, төсөв санхүү, бусад хүний эрхийн асуудлуудыг бий болгож байгааг анхааран засах шаардлага байна.

Эцэст нь зөрчлийн хэрэгт давж заалдах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна. Зөрчлийн хэрэгт шийтгэх баривчлах шийтгэл авагдсан иргэдийн 47 хувь нь 7 хүртэл, 7 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл авч байгаа бөгөөд эдгээрийн дөнгөж 1,9 хувь нь давж заалдах эрхээ хэрэгжүүлсэн судалгаа байгааг анхаарах шаардлага байна.

Ц.Сандаг-Очир: 2 минутад багтаагаад саналаа хэлчих.

С.Энхболд: Эдгээр нөхцөл байдал дээр тулгуурлан ХЭҮК-оос дараах хэд хэдэн саналыг дэвшүүлж байна. 1 дүгээрт нь эрүүгийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх, хүнээс, хүний биеэс биологийн дээж авах зэрэг хүний халдашгүй чөлөөтэй байхыг хязгаарлах зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн зөвхөн шүүх шийдвэрлэдэг байх. Сэтгэцийн шинжилгээ хийх процессын зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна. Хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүс ялангуяа хэрэг хариуцах хязгаарлагдмал чадамжтай хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тэдгээр этгээдэд суллагдсаны дараа тавих хяналтыг сайжруулах шаардлага байна. Гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож, хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах талаар хүсэлт гаргасан даруй шүүхийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Мөн бусдыг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай мэтээр олон нийтэд зарлах, дүгнэлт хийх, түүний сөрөг үр дагаврыг олон нийтэд ойлгуулах, үүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭХХШТХ-ийн холбогдох зүйл, заалтуудыг нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Мөн гэмт хэргийн улмаас хохирсон хохирол нөхөн төлүүлэх тухай асуудлыг боловсронгуй болгож, Хохирол нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг судалж, шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төсвийг гэм буруутай этгээдээс гаргуулан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө, орлого, бусад эх үүсвэр бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль, эрх зүйн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг үзүүлэх бие даасан хуулийн хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг судалж, батлах шаардлага байна гэсэн саналыг гаргаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Энхболд гишүүнд баярлалаа. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн 6 бүлгийн танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд хувааж авч дэлгэрэнгүй танилцууллаа. Энэ танилцуулгуудыг бас энэ долоо хоногт Улсын Их Хурал дахь Ардчилсан нам, Ардын намын бүлгүүдээр танилцуулж, мэдээлэл хийсэн байгаа. Өнөөдөр Байнгын хороо, ингээд маргааш, нөгөөдөр чуулганаар хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа

асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт, үг тусдаа юм байна лээ шүү. Дараа нь үг хэлэх байгаа, нэрсээ өгнө үү асуулт асуух гишүүд? Таных байхгүй байна. Алтанхуяг гишүүнээр тасаллаа, Сайнзориг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Манай хүний эрхийн хэд маань ер нь их гайгүй л юмнууд хийгээд байна гэж би хараад байгаа юм. Овоо гайгүй юм хийж байна гээд бодож явсан чинь тайлангаа ёстой нэг залхуутай тавьдаг юм байна. Цаасаар юугаар өгчихсөн энийг нэг хэдүүлээ цаашдаа хялбарчилмаар юм байна ташрамд дурдахад. Ер нь ингээд би та нарыг нэлээн олныг нь бараг таньдаг болчихоод байгаа л даа. Хэдүүлээ энэ, би технологи л ярья даа. Би чинь их сургуульд багш байсан хүн. Энэ үргэлжилсэн үгийн зохиолыг л болимоор байх юм. Тэгмээр байна, тэгмээр байна, тэгмээр байна, ингэмээр байна. Үгүй ээ, тэгье л дээ, ингэе л дээ. Тэгээд яг хаана нь, яг юуг нь хийх юм гэдэг дээр та нар жаахан тайлан, илтгэл гэдэг юмыг нэг тийм хэлбэр лүү оруулчихмаар надад санагдаад байна. Жишээлбэл та нар сэтгүүлчдийн эрх ингээд зөрчигдөөд байна, үүгээрээ нэлээн тэг заачихлаа хамгийн сүүлд орчихлоо гээд л. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль явж байгаа шүү дээ манай Их Хурал дээр. Тэнд та нарын яриад байгаа юмнууд чинь хаана нь яаж шигдээд, шигтгэгдээд, эсвэл ерөөсөө ороогүй байгаа юм бэ энийгээ харьцуулаад бид нарт өгөөд юм уу, Их Хуралд өгөөд, Их Хурал ЗГ-т өгөөд, бүр анх ЗГ тэр хурлыг хийхэд нь энэ, энэ заалтуудыг ингэж, ингэж өөрчилмөөр байна гээд ингэвэл та хэдийн маань илтгэл ёстой нэг амьдралд хэрэг болохоор байх юм 1 дүгээрт.

2 дугаарт хууль бол Энхболд мэдэж байгаа шүү дээ, бид нар нөгөө ямар нэртэй болчихлоо тэр чинь Эрүүгийн хуульд нөгөө процессын хуульд өөрчлөлт оруулаад явж байгаа шүү дээ. Одоо өөрийн чинь тавьж байгаа илтгэл бол их чухал илтгэл явж байгаа байхгүй юу, бүгдээрээ чухал юм тавьсан л даа. Энхболдыг магтчихлаа гэх байх даа, шударгаар шүүлгэх эрх гээд. Ингээд энэ дээр бид их нэлээн ярьсан, өмнө нь ч яриад ингээд хуульд оруулсан. Одоо тэгээд би Их Хуралд нэлээн хэдэн жил сууж байна ингээд байна шүү дээ. ЗГ-ын өргөн барьсан концепцын хүрээнд л өөрчлөлтөө оруулна, тэгээд шинэ юм ярихаар наадах чинь байхгүй, наадах чинь тэгвэл дахиад шинээр эхэлнэ. Тэгээд та нарын энэ яриад байгаа юмыг жаахан цэгцлээд, гоё болгоод Их Хурал дээр нэг яриад, яриад гэдэг нь Байнгын хороон дээр ч юм уу яриад, ЗГ луу өгөөд, энэ чиглэлээр та нар бүүр комплекстой хийгээд ир гэмээр байна. Дахиад та нарын энэ ингээд тавьж, энэ бүлэглээд байгаа юмыг чинь харахаар би бол амьдрал дээрээ тэр хонгилоор чинь зөндөө явчихсан учраас өөрөөр бүлэглэмээр харагдаад байна.

Мөрдөн байцаах гэдэг юм уу тэр хэсэг дээр болж байгаа, болохгүй байгаа юмнууд нь юу юм. Тэр цагдаа, тагнуул, мөрдөн байцаах газрууд дээр. Дараагаар нь прокурорын байгууллага гэж босоо удирдлагатай маш хэцүү байгууллага байгаа шүү дээ. Тэднийх дээр ямар юмыг нь яаж өөрчлөөд байгаа юм. Түүн дээр иргэний эрх яаж зөрчигдөөд байгаа юм, иргэний эрхийгээ хамгаалахын тулд яамаар байгаа юм, та нар үүнийг би бол зөндөө сонслоо. Өмгөөлөгчийг бусад нөхөдтэй мөрдөгчтэй юм уу, бусад прокурортой ижил.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүнд 1 минут тодруулга.

Н.Алтанхуяг: Анхнаас нь нэг зиндаанд явуулъя гээд зөндөө ярилаа шүү дээ. Тэгээд энийг чинь энэ, энэ хууль дээр нь ийм, ийм өөрчлөлт хийчихвэл болно

гэдэг юм л олигтой гарч ирэхгүй, гарч ирсэн ч сэглэгдээд байгаа байхгүй юу ЗГ-ын өргөн барьсан юмны түвшинд явна гээд. Комплексны хиймээр байх юм.

Дараагаар нь шүүхийн түвшинд юуг өөрчилмөөр байгаа юм, хамгийн сүүлд нь хүмүүсийн би магадлангаар орж байгаа өргөдөл гомдол нэлээн олон хүнээс ирсэн. Шүүхийн дараах юу гэх юм процесс, тэгээд магадлангаар оруулахад хүртэл нийт ялынх нь хугацааны тал болонгуут нь магадлангаар оруулъя гэхлээр үүнийг магадлангаар оруулах гэдэг нь өөрөө үзэмжийн асуудал болж хувираад шүү дээ. Зарим нь 2 жилийн ял авсан хүн нэг жил болоод магадлангаар ороод явчхаж байхад заримыг нь чинийх болоогүй байна, чинийхийг дахиад явуулна гээд жил 6 сар, 7 сар, бараг 2 жилийг нь гүйцээгээд гаргаж байна гээд иймэрхүү эрх зөрчигдөж байгаа юман дээр та нар маань нэлээн анхаараад өгөөч. Би тэгээд хүний эрхийн эрх.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүний асуултад хэн хариулах вэ? Санал хэлчхэж байгаа юм уу? Санал хэллээ. Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу, та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Тэгээд манай ХЭҮК 24 дэх илтгэлээ 6 бүлэгт хуваарилж, нэлээн маш олон судалгаа шинжилгээг хамруулж нэлээн чамбай хийсэн байна. Тэгээд харамсалтай нь энэ ном бол, энэ зузаан ном бол ердөөсөө энэ Монгол Улсад хүний эрх хэрхэн яаж зөрчигдөж, хангагдахгүй байж, хамгаалагдахгүй байгаа вэ гэдгийн л том илрэл байна. Би энэ дундаас маш олон асуудлууд байгаа ч гэсэн ялангуяа хүүхдийн хүчирхийлэл, түүн дундаа хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудлыг онцолж харж байна. Ер нь Монгол Улс хүүхэд хамгааллын асуудал дээр сүүлийн 2005 оноос хойш нийт 7,5 их наядыг зарцуулсан гэж ийм дүн байдаг. Яг хүүхэд хамгааллын бодит хүүхдийг аливаа нэгэн эрсдэлт нөхцөл байдал, хүчирхийлэл, аливаа нэгэн гэмтэж бэртэхээс сэргийлсэн ажлуудад жилээс жилд төсөв нэмэгдэж явж байгаа. Өнгөрсөн он жилүүдэд 8 тэрбум, 10, 14 тэрбум гэж байсан, одоо 2025 оны төсөвт 20,5 тэрбум төгрөгийг хүүхэд хамгааллын зардалд тусгаж төсөвлөсөн. Одоо ингээд бүхэл бүтэн хагас жил нь болох гэж байна шүү дээ.

Тэгтэл ингээд энэ нөгөө талаараа хамгаалагдсан, урьдчилан сэргийлсэн байдал огт байхгүй байгаа нь энэ ном дээр байгаа маш олон том статистик үзүүлэлт, гэмт хэргийн золиос болсон хүүхдүүд, хүчирхийллийн улмаас болж үр хөндүүлж байгаа, бие махбод, сэтгэл санааны хохирол учирч байгаа хүүхдүүдэд нөхөн сэргээх эмчилгээ хийгдэж чадахгүй байгаа. Мөн түүнчлэн хамтарсан багийн ажил хүндээ хүрч чадахгүй байгаа тухай, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээг бид нар ерөөсөө авч чадахгүй байгаа учраас өдөр болгон нэг хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж байна гэсэн Хунан гишүүний энэ юу байгаа шүү дээ. Ер нь дунджаар яг ийм хүүхдийн бэлгийн хүчирхийлэл хаа сайгүй өдөр болгон нэг болж байна гэдэг чинь энэ өөрөө энэ төсөв мөнгө хэр их үр өгөөжтэй, үр бүтээмжтэй хуваарилагдаж, захиран зарцуулагдаж, үр өгөөжөө өгөөд байгаа вэ гэдгийн л илрэл. Тэгэхээр одоогийн байдлаар хүүхэд хамгааллын зардалд энэ оны 20,5 тэрбум төгрөгийн төсвийн дунджаар ядаж 40, 50 хувь нь зарлагадаад, энэ 50 хувь нь зарлагадсаны үр дүн, өгөөж гэж өнөөдөр хэмжигдэж байх ёстой.

Гэтэл өнөөдөр ингээд ийм эмгэнэлтэй статистик тоотой байж байна гэдэг магадгүй гэр бүл, хөгжил, хамгаалал, Гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газар ажлаа оновчтой, үр өгөөжтэй, байгаа оносон, нийтийг хамарсан байдлаар хийж

чадахгүй байгаа юм уу гэдэг ийм дүгнэлтэд би хүрч байна. Тэгээд нөгөө талаар миний бас шүүмжлэл.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Нарантуяа-Нара гишүүний асуултад. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Хунан гишүүн.

Ж.Хунан: Нарантуяа-Нара гишүүний хэлсэн зүйлтэй холбоотой хэдэн зүйлийг хэлье гэж бодож байна. Тэгэхээр өнөөдөр Монгол Улс хүүхдүүдээ хамгаалж чадахгүй байгаа нь үнэхээр харамсалтай. Ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон, болж байгаа хүүхдийн тоо бол жил болгон ингээд бүр тогтмол нэмэгдэж байгаа асуудал байгаад байгаа. Энэ дээр бид нар онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай. Урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг бид нар арга барилаа өөрчлөх, шинэчлэх, эрчимжүүлэх, дээрээс нь шат шатдаа, түвшин түвшиндээ хүүхэд 1 дүгээрт гэдэг зарчмаа бид нар дэлгэрүүлэх, энийг бүүр хатуу чанд мөрдөх, мөрдлөг болгох шаардлага байгаа. Статистик мэдээ бол энэ цагдаагийн байгууллагаас ирсэн нэг өөр, дээрээс нь шүүхийн шинжилгээний байгууллагад яг хүчингийн гэмт хэргийн хохирогч болж байгаа үндэслэлээр үзүүлж байгаа хүүхдийн тоо маш өндөр байгаад байгаа 2, 3 дахин өндөр байгаад байгаа юм. Тэгэхээр дээр бид нар дүгнэлт хийх ёстой. Тэгэхээр ажил бол хийгдэхгүй байна. Дээрээс нь төсвийн асуудал үнэхээр чамлалттай байна. Өнөөдөр хүүхэд хамгааллын зардал нэмэгдэж байгаа ч гэсэндээ үр дүн гарахгүй байгаад байгаа юм. Үр дүн ямар тохиолдолд гарах вэ гэхлээр төсөв, дээрээс нь мэргэшсэн боловсон хүчний асуудал. Тийм учраас төсвөөс гадна бид нар боловсон хүчнийг бодлогоор бэлдэх ийм хэрэгцээ шаардлага байгаа гэж харж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Нарантуяа-Нара гишүүн тодруулах 1 минут.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр манай ХЭҮК-оос ийм олон хүний эрхийн холбогдох асуудлуудаар ийм олон дүн шинжилгээ хийгээд, статистик шинжилгээ цуглуулаад, мэдээг цуглуулаад ингээд холбогдох байгууллагуудад та бүхэн санамж шаардлага хүргүүлдэг шүү дээ. Тэгэхээр жишээлбэл яг хүүхдийн кэйс дээр манай Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газар хэр та бүхний санал шаардлагыг хүлээж авч, ахисан үзүүлэлт түвшнийг та бүхэнд эргээд хариу болгодог вэ? Миний бодлоор ингээд энэ өнгөрсөн хугацаанд Хүүхэд, гэр бүл, хөгжлийн газар ерөөсөө нөгөө ийм удирдлага тогтвортой байгаагүй нэг ийм алдаа байсан. Тэгээд жилээс харьцангуй тогтворжоод, нэлээн үйл ажиллагаа өргөжөөд явах юм болов уу гэж харж байгаа. Харамсалтай нь ингээд нэг үйл ажиллагаа баяр цэнгэл ийм ой, үйл ажиллагаа нэг ceremony хийх ийм ажилдаа аягүй их ач холбогдол өгөөд байх шиг харагдаж байна. Тэгээд миний хувьд та бүхний зүгээс яг үнэлгээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хунан гишүүн хариулъя.

Ж.Хунан: Хүүхэд хамгааллын асуудалд комисс онцгой анхаарал хандуулдаг. Тэгээд Нарантуяа гишүүний асуусан хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байр, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд өнгөрсөн 2 жилийн хугацаанд тогтмол бид нар хяналт шалгалтыг хийж, судалгаа дүн шинжилгээ эд нар хийж Улсын Их Хуралд танилцуулсан байдаг. Тэгээд хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаанд үндсэндээ бид хангалтгүй гэдэг дүгнэлт өгсөн. Өөрөөр хэлбэл үр дүнгүй байна. Энэ нь төсөвтэй холбоотой, боловсон хүчинтэй,

боловсон хүчний бэлтгэгдсэн байдалтай холбоотой гэдгийг хэлсэн. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо мөн ялгаагүй өнгөрсөн 23 дахь, 22 дахь илтгэлдээ Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог бид нар оруулсан байдаг. Мөн хангалтгүй гэдэг үнэлгээг өгсөн. Энийг бол сайжруулах. Тэгээд энэ дээр хэд хэдэн асуудал бас.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулчих Хунан гишүүн.

Ж.Хунан: Түрүүн хэлсэн боловсон хүчний тогтворгүй байдал гэдэг бол том нөлөөлж байгаа хүчин зүйлийн нэг байдаг. Хамтарсан баг болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог ахалж байгаа хүмүүсийн хувьд асуудалтай зүйлүүд байгаа. Энэ нь юу вэ гэхлээр Засаг дарга, сумын Засаг дарга хамтарсан багийн ахлагч байдаг, дээрээс нь Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга нь Засаг даргын аймгийн Засаг даргын орлогч байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол энэ хоёр хоёулаа улс төрийн албан тушаалтан учраас энэ дээр нэгд бэлтгэгдсэн байдал хангалтгүй. Тийм учраас энэ асуудал орхигддог ийм асуудал гаргадаг. Тэгэхээр энийг бол бид нар эргэж харах шаардлагатай, энэ дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулсан. Илтгэлүүдтэй холбоотой жил болгон бид нар энэ тогтоолын хэрэгжилтийг танилцуулдаг. Комиссын гишүүний зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийг илтгэлд хавсаргадаг байгаа. Тэгэхээр дэлгэрэнгүй мэдээллийг бол та өмнөх нөгөө илтгэлүүдээс.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нарантуяа-Нара гишүүн дахиад тодруулъя гэж байна 1 минут.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр ялангуяа хүүхдийн хүчирхийлэгчдэд хариуцлага тооцох эрх зүйн орчин тэр дундаа ялын бодлого, тэгээд дээрээс нь авах арга хэмжээ, энэ дахин, дахин энд тэнд ийм хүмүүсийг үйлдэхгүй байх энэ арга хэмжээнүүдийг чангатгамаар юм шиг санагдаж байгаа. Тэгэхээр миний хувьд эрх зүйн хүрээнд ялын бодлогыг нь чангалах. Тэгэхгүй л бол угаасаа ингээд энэ хүмүүс чинь ойлгохгүй байна шүү дээ. Тэгэхээр зэрэг ялын бодлогыг нь чангалаад, дээрээс нь авах арга хэмжээ жишээлбэл цагдаагийн байгууллагаас хүүхдийн хүчирхийлэгчдийг зураг нэрийг нь ил болгож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг хийе гэж бодож байна шүү дээ. Тэгэхээр би бол нэгэнт хүмүүст нэр нүүрээ нуугаад юу эсийг хийж чадаад байгаа бол энийг хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм гэж бодож байна. Та бүхэн тал дээр юу гэж бодож байна вэ?

Л.Соронзонболд: 4 дүгээр микрофоныг өгье.

Ж.Хунан: Монгол Улсын хувьд хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэгт оноож байгаа ялын хувьд өндөрт тооцогддог. Ялын бодлогын хувьд чанга. Нэг асуудал байгаа нь энэ бол нөгөө хяналтын асуудал байгаад байгаа юм. Түрүүн яригдсан. Өөрөөр хэлбэл ял эдлээд гарч байгаа нөхдөд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, бүтэц энэ бол хангалтгүй байдаг. Мэдээлэл түгээх, урьдчилан сэргийлэх асуудал. Тэр бэлгийн гаж зан үйлтэй нөхдийн бүртгэлийн асуудлыг ХЗДХЯ-наас ажлын хэсэг гарчихсан судалж байгаа. Тэгэхээр энэ бол асуудал шийдэгдэх байх. Ер нь дээр маш хатуу хяналт байх нь зөв. Ингэснээрээ хүүхдүүдээ хамгаалах боломжтой. Бусад улсад энийг хэрэглэдэг ийм практик байгаа.

Ц.Сандаг-Очир: Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг нээе.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүд болон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн өдрийн мэндийг айлтгая. Хүний эрхийн Үндэсний Комиссынхны ажил үнэхээр хүнд. Би бас эд нар дээр очиж санал хүсэлт өгч явж байсан. Тэгээд нэг тодорхой хэдэн асуулт асуух гэсэн юм та хэдээс. Уг нь Улсын Их Хурлаас томилогдож байгаа байгууллага ХЭҮК, ЗГ ч ялгаагүй Улсын Их Хурлаас томилогдоод ажилдаа орж байгаа юм. Тэгээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбогдуулаад 2, 3 асуулт байгаа юм. Сэтгүүл зүйн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой нэлээн тайлан танилцуулсан учраас энэ дээрээс нэг хэдэн юм тэмдэглэж авч байгаад асууж байгаа юм. ЗГ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг өргөн барьж байгаа. Уг нь хэвлэл чинь өөрөө 4 дэх засаглал буюу ЗГ-тайгаа ижил тэнцүү хэмжээний эрхтэй байх ёстой байтал одоо бол ЗГ хэвлэлийн, юу гэж харж байгаа вэ? Тэгээд энэ хуультай та бүхэн танилцсан байх. Энэ дээр нэг саналаа хэлбэл зүгээр байгаа.

Тэгээд та бүхэн энэ тулгамдаж байгаа асуудал гээд биччихсэн байгаа энэ тулгамдаж байгаа асуудлуудыг чинь одоо энэ өргөн барьж байгаа хууль шийдэж чадаж байгаа гэж үзэж байгаа юу гэж? Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой ярихаар чинь нэг сэтгүүлч мэдээллээ хаанаас олж авснаа нуух бүрэн эрхтэй хүн хилсээр хоригдоод гараад ирсэн. Энэ дээр та бүхэнд очсон санал гомдол байдаг уу? Энэ дээр та бүхэн энэ сэтгүүлчийн эрхийг хамгаалах чиглэлд ямар ажиллагаа явуулсан бэ, эрхийг нь хамгаалсан гэж үзэж байгаа юу? Ер нь нөгөө ХЭҮК-т хандаж байгаа хүмүүс чинь эрх зөрчигдчихлөө, хамгаалаад өгөөч л гэж очиж байгаа шүү дээ. Тэгэхээр хамгийн сүүлчийн асуулт бол өнгөрсөн хугацаанд жил юм уу ингээд тайлангаа танилцуулж байгаа энэ хугацаанд та бүхэн нийтдээ хэдэн хүний эрхийг, яаж хамгаалж ажиллав гэдэг дээр нэг хариулт өгөөч.

Л.Соронзонболд: 2 дугаар микрофоныг нээе.

С.Дондов: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Манай ХЭҮК-т сэтгүүлчид эрх ашиг зөрчигдлөө гэдэг агуулгаар гомдол гаргадаг. Үүний нэг кэйс нь яахын аргагүй Өнөрцэцэг сэтгүүлчийн гаргасан гомдол байгаа. Энэ гомдлын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд ажиллаж байгаа Хүний эрх хамгаалагчийн орон тооны бус хороо гэсэн ийм хороо ажилладаг. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хуульчид, өмгөөлөгчдийн төлөөлөлтэй. Ингээд энэ ирсэн гомдлын дагуу бид ажиллагаа хийж, дүгнэлт гаргасан. Дүгнэлтэд хүний эрх, сэтгүүлч бол хүний эрхийн хамгаалагч юм, хүний эрх хамгаалагчийн эрх нь тодорхой хэмжээгээр зөрчигджээ гэсэн ийм дүгнэлтийг гаргасан. Үүнд 1 дүгээрт сэтгүүлч Өнөрцэцэгийн Нийтийн мэдэх эрхийг хангах хуулийн хүрээнд өөрийн олж авсан мэдээллээ, өөрийн сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх энэ үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд явагдсан энэ хэсэг нь хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаа байна. Тодорхой хэмжээнд эрүүгийн хэрэг үүсгэгдчихсэн, түүн дээр шалгах ажиллагаа хийгээд явж байгаа асуудал нь Хүний эрхийн Үндэсний Комиссын 22, хуулийн 22.2-т зааснаар бол хамаарахгүй юм гэдэг дүгнэлтийг гаргасан.

Дүгнэлтийн нэг хэсэгт Зариг.мн сайтыг 24 цагийн хугацаагаар бүхэлд нь хаасан. Энэ нь хүний эрхийн зөрчил байлаа. Тэнд магадгүй зөрчилтэй контент байгаа бол тэр контентыг нь тодорхой хугацаагаар хаах ийм асуудал хийгдэх ёстой байсан гэдэг ийм хүний эрхийн дүгнэлт хийсэн. 3 дугаарт шүүхээр гэм буруу нь

тогтоогдоогүй байхад сэтгүүлчийг элдэв янз үгээр доромжлох, олон нийтийн сошиал медиад элдвээр гүтгэх маягтай ийм үйл ажиллагаа явуулж байгаа нь сэтгүүлчийн сэтгэл санааны байдалд хүнд байдалд хүргэх ийм нөхцөл байдал үүсэж байна. Энэ дээр бол цаашдаа анхаарах шаардлагатай байна гэсэн ийм агуулга бүхий дүгнэлтийг хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчихсөн байна гэсэн ийм дүгнэлтийг гаргаад, Өнөрцэцэг сэтгүүлчид өөрт нь өгсөн байгаа. Мөн сэтгүүлчдэд бол гомдол гаргадаг. Гомдолд зайлшгүй дүгнэлт гаргах ёстой юун дээр хороо хуралдаж байгаад дүгнэлтээ гаргадаг. Бусад юун дээр бол тодорхой хэмжээний зөрчилтэй байгаа асуудлуудаар нь хүний эрхийн талаас нь анхаарах энэ юун дээр гомдлуудыг шийдэж байна.

Ц.Сандаг-Очир: Болсон уу, нэмэх үү, өөр хэн хариулах юм бэ? Хэвлэлийн эрх чөлөөнөөс гэж байна. Нарантуяа гишүүн.

Г.Нарантуяа: Тэгэхээр Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурь, дүгнэлтийн талаар асуултад хариулъя. Тэгэхээр 22 дахь, Хүний эрх чөлөөний төлөв байдлын 22 дахь илтгэлд комисс хэвлэл мэдээллийн байгууллагууд хараат бус, олон ургалч, ил тод ийм зарчмаар ажиллах ёстой гээд энд шаардагдах эрх зүйн зохицуулалт ямар байвал зохих вэ гэдэг саналаа маш тодорхой оруулсан. Энэ санал бол Хууль зүйн яамнаас боловсруулсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд нэлээд хэмжээгээр тусгагдаж, суурь нь болсон байна лээ.

Гэхдээ энэ дээр бол асуудал нэг асуудал байгаа юм. Үнэхээр Монгол Улсын хэвлэл мэдээллийн орчныг, мэдээллийн эко системийг гэж өргөн хүрээгээр нь харвал эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг хүний эрхийн хэм хэмжээ, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд, олон улсын стандартад нийцүүлбэ гэвэл Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулахаас гадна, бас тээг болж байгаа бусад хууль тогтоомжуудыг зайлшгүй сайжруулах.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд Нарантуяа гишүүний микрофоныг өгье, хариулчих.

Г.Нарантуяа: Эрүүгийн хуулийн 13.14 худал мэдээлэл тараах энэ гэмт хэрэг бол гүтгэлэг, доромжлолыг хязгаарлахгүй, харин хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах ийм хөшүүрэг болж байна гэдэг дүгнэлтийг ХЭҮК олон удаа танилцуулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, зарим төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад давуу эрх олгодог Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. Ер нь яаж Монгол Улсын олон ургалч хэвлэл мэдээллийн байгууллагыг дэмжих юм, яаж улс төр, эдийн засгийн нөлөөллөөс хэвлэл мэдээллийн байгууллага хараат бусаар ажиллах энэ нөхцөл бололцоог бий болгох юм бэ гэдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. ХЭҮК Улсын Их Хуралд тусгайлан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулга бусад хамааралт хууль тогтоомжийн талаар дүгнэлтээ танилцуулахад бэлэн байна. Та бүхэн бид нарыг уриарай.

Ц.Сандаг-Очир: Сүнжид гишүүн, дарга ажлын хэсгийн 3 дахь микрофоныг өгье.

Д.Сүнжид: Цогтбаатар гишүүний асуулт. 2024 оны байдлаар тоо баримт танилцуулахад 122 удаагийн хяналт шалгалтыг хийсэн байна. Эндээс гишүүдийн

санаачилгаар ихэнх нь буюу 89 удаагийнх нь байгаа. Яг гомдол мэдээллийг хүлээж авч шийдвэрлэсэн байдал 1311. Үүнээс гадна хууль зүйн зөвлөгөө тухайлан өгсөн 1234 гэдэг ийм тоон мэдээллийг танилцуулж байна.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Боллоо. Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд яах вэ хүмүүс нэг их анзаарахгүй байх шиг байгаа юм. Комиссын хууль шинэчлэгдээд удаагүй байгаа. Энэний үр дүн байхгүй юу. Хүний эрхийн асуудлыг хамгаалах гэдэг асуудал маань ерөөсөө бас яг энэ нийгмийн амьдралын хувьд ийм процессын шинжтэй үйл явц юм. Түүнээс биш нэг өдөр ингээд бүх зүйл гоё болох гээд байгаа тухай, ийм сэтгэгдэл төрүүлэх тухай ерөөсөө байж болохгүй. Бид хэд 92 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш хүний эрхийн ойлголтуудыг тодорхой түвшинд ойлгоод, энийгээ улам агуулгыг баяжуулаад, энийгээ хэрэгжүүлэх арга механизм, төсөв, хүний нөөц, дэд бүтцийг бүрдүүлэхээс эхлээд ингээд үе шаттай явж байгаа л ийм улс. Тийм учраас хэдүүлээ бас энэ зүйлүүдийг нэг ойлголтыг зөв болгохгүй бол энэ нийгмийн сэтгэл зүйн уур амьсгал дотор хэт их ийм хатуу дүгнэлтүүд хэлээд байхаар хүний эрх гэдэг зүйл ерөөсөө бидэнд байдаггүй юм байна гэдэг мэдрэмжийг өөрсдөө олон нийтдээ өгдөг байгаа. Байгаа юмыг яаж сайжруулах вэ, тэр байхгүй байгаа зүйлүүдийг нь харин яаж бид хууль, эрх зүйн талд баталгаажуулж өгөх вэ гэдэг зүйлүүдтэй байх ёстой шүү. Тэр мэдрэмжээр ингээд хандахгүй бол өнөөдрийн би ингээд хариултууд болон асуултуудаас ингээд харахаар хэт ингээд зарим зүйлүүдээ хүнд санагдаад байна. Энийг хэлмээр байгаа юм.

Ийм чухал 6 сэдэв байна. Асуултын асуух хугацаа маань богино. Тэгэхээр би яах вэ эхний асуудал буюу сонгох, сонгогдох эрх рүү чиглүүлээд 2 зүйлийг асуумаар байна. Би сонгох, сонгогдох эрхтэй холбоотойгоор сүүлийн үед Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг бараг 4, 5 Цэцийн маргаан үүсгээд явлаа. Сонгуулийн хуулийг дагаж орсон Зөрчлийн хууль дээр хүртэл маргаан үүсчихсэн байгаа. Ингээд бодохоор сонгуулийн жилд Цэцэд яг сонгууль явуулах гэж байгаа хууль тогтоомжоор маргаан үүсгэхэд Цэц хэлэлцэхгүй гэсэн тийм хэлэх эрх байхгүй, эргэж гомдлоо гаргаж болно. Тэгээд би энэ дээр нэг зүйлийг хэлээд байгаа. Ерөөсөө энэ асуудлыг бид хэд зөв цэгцэлж авч явахгүй Монгол Улсын Үндсэн хууль буюу 92 оны Үндсэн хуулийн утга, агуулга энэ улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ардчилал, хүний эрх чөлөөнд ерөөсөө хамгийн том нөлөө үзүүлэх, алдагдах эрсдэлийг нэг заалтаар бий болгочоод байгаа юм. Энэ харамсалтай. Энэ улс, Үндсэн хуульдаа бид нар 19 онд өөрчлөлт оруулахдаа Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахаас өмнө нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэхихсэн.

Цэц өөрөө эргээд нэг жилийн энэ хугацаан доторхыг барьж ерөөсөө шийдвэр гаргахгүй байхгүй юу. Үндсэн хууль зөрчихөөд байна, хүний эрхийг дордуулчихаад байна гэхэд энийгээ өөрчлөлт оруулж чадахгүй Үндсэн хууль зөрчсөн Сонгуулийн хуулиараа сонгуулиа явуулах гээд үр дүнг нь хүлээн зөвшөөрөхгүй гудамжинд гаргах, эсвэл Улсын Их Хурлын сонгуулийг хойшлуулж тодорхой.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн 1 минут тодруулга.

П.Сайнзориг: Сунгах ийм нөхцөл байдал руу ингээд том эрсдэлийг бид нар оруулчихсан. Тэгээд энийг ингээд хэлж ярихгүйгээс болоод хуулийг нөгөө өөрчлөлт оруулахыг цаг хугацаагаар ерөөсөө хязгаарлаж болдоггүй. Аль ч ардчилсан парламентад олонх буюу хүлээн зөвшөөрөгдөх тэр квот дээр аваачиж хуулийг баталдаг, нэмэлт, өөрчлөлт оруулдаг consensus явсны дараа. Тэгэхээр энэ асуудлаас эхлээд Үндсэн хуульд хэдийгээр 19 оны өөрчлөлт бол засахаас өөр аргагүй, хожим нь нэг үр дагавар л гарна. Монголын ардчилал гудамжиндаа гарч, сонгуулийн үр дүнгээ хүлээн зөвшөөрөхгүй байдал руу орох эрсдэл байгаа юм. Тэгээд энэ цахимаар сонгууль өгөх асуудлыг дурдсан байна лээ. Би энийг дэмжиж байгаа. Хотын захирагчаас эхлээд цахимаар явах ёстой гэдэг дээр Улсын Их Хурлын тодорхой чиглэлүүд гарсан байгаа. Тэгэхээр ер нь зүгээр өөр энэ дээр ингээд дүгнэлтүүд гарсан. Тэгэхээр би энийг бол ер нь дэмжиж байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийг Хүний эрхийн Комисс юу гэж үздэг юм бэ? Тэгээд би яах вэ комиссын удаагийн Улсын Их Хуралд санал тавьж байгаа саналуудыг дэмжиж байна. Хуучин бас.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хариулъя. Хэн хариулах вэ? Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид дарга ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Д.Сүнжид: Сайнзориг даргын асуултад хариулъя. Сонгуулийн жилтэй холбоотой 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явах үеэр үр дагаврын үнэлгээ Монгол Улсад үүсээд байгаа асуудлыг юу гэж дүгнэсэн бэ гэхээр Үндсэн хуулийн цэцээс юм уу эсхүл хууль тогтоох байгууллагаас ингэж тулгуу хугацаанд ялангуяа сонгуулийн тогтолцоог өөрчлөх нь нэр дэвшигчдэд ч, намд ч, олон нийтэд, сонгогчдод ч эерэг биш сөрөг ийм үр дагавар үүсгэж байна, танин мэдэх боломж олгохгүй байна, гарааны тэгш нөхцөлийг хангахгүй байна гэдэг ийм шүүмжлэлийг дагуулаад, ийм дүн шинжилгээнд үндэслээд л 2019 оны Үндсэн хуульд энэ нэмэлт, өөрчлөлтийг хийсэн л дээ. Тэгээд энэ, тийм учраас одоо ХЭҮК бол яг жил танилцуулж байгаа учир нь жилийгээ хугацаагаа тулгахгүйгээр өмнө нь хийчихсэн энэ сургамждаа тулгуурлаад бид энэ хуулиуддаа 2 хуульдаа нэмэлт, өөрчлөлтөө оруулбал зохистой гэж үзэж санал болгоод байгаа юм.

Тэгээд сая Сайнзориг гишүүний саналыг, тийм бодох ёстой асуудал мөн, мөн. Бид нар Үндсэн хуулийн цэцээс мэдээлэл авсан юм энэ сонгох, сонгогдох эрхтэй холбоотой бид нар дүн шинжилгээ хийж байна илтгэлийн хүрээнд гэсэн чинь чинь тэнд оччихсон гомдлын тоо сүүлийн жил маш их юм байна лээ 69 гомдол Улсын Их Хуралтай холбоотой, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуультай холбоотой бол түүнээс цөөн, 50 дахин цөөн ийм гомдлууд ирчихсэн байна гээд. Тэгэхээр шийдэж чадахгүй энийгээ хуримтлуулдаг ийм асуудал үүсэж байгаа юм байна лээ. Тэгэхээр цаашдаа энэ нь ямар үр дагавар гарах вэ гэдгийг тооцох ёстой гэдэг Сайнзориг гишүүний саналтай бол бодож үзэх ёстой гэдэг дээр санал нэг байна.

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн ахиад 1 минут тодруулга.

П.Сайнзориг: 6 илтгэл маань явчихна, 1-хэн, 5-хан минутад амжиж байгаа учраас хэцүү байна. Бусад уг нь илтгэлүүдээс асууя гэж бодсон. Тэгэхдээ би Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлээс хандлагын бөгөөд нэр томьёоны агуулгыг зөв болгох олон оролдлогууд хийж гэдэг дээр сайшаалтай хандмаар байна. Жишээ нь шударгаар шүүлгэх эрх гээд одоо оруулж ирж байгаа байхгүй юу. Бид хэд Үндсэн хуульдаа юу гээд хэлчихсэн бэ гэхээр шударга шүүхээр шүүлгэх гээд

хэлчихсэн. Шүүхийн шудардгаа биш, процессын шударга байдлын явдлыг бид хэд анхаарах ёстой гээд. Энэ хандлага, нэр томьёог ингээд залруулах гэж оролдож байгаа зүйлүүдийг би үнэхээр дэмжиж байна. Ингэж байж бид сэтгэлгээний хувьд, хандлагын хувьд өөрчлөлтүүд авчирна. Тэгээд яах вэ Улсын Их Хуралд энэ илтгэлтэй холбоотойгоор саналуудаа өгч байгаа, энэ дээрээс бид Улсын Их Хурлын тодорхой тогтоолын төслийг ЗГ-т өгөх чиглэлтэйгээр батлах энэ бололцоог бүрдүүлж өгч байгаад таатай байна.

Ер нь яах вэ зүгээр өмнөх тэр илтгэлүүдээс харахаар Хууль зүй, дотоод хэргийн яам дээр явж байсан хуулийн төслийг шууд ардаа хавсрангуутаа энэ хуулийг батал ч гэдэг юм уу арай жоохон тийм бүтээлч бус юмнууд байдаг байсан. Яг наад.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Санал байна тийм ээ. Би ганц нэг асуулт асууя. Сүнжид даргаа 21, 22, 23 дугаар илтгэлийн дагасан гарсан Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтүүд дээр та бүхэн нэг дүгнэлт хийж үзсэн үү? Бид нар ингээд та бүхэн ингээд асар их материал дээр ажиллаад, асар их тоо судалгаан дээр ажиллаад, холбогдох бүх байгууллагуудаас мэдээллийг аваад ингээд өдөржин, шөнөжин сууж байгаад илтгэл гаргаад, дүгнэлт гаргаад байна. Тэгээд ингээд Их Хурал хэлэлцдэг болсон, тогтоол гаргадаг болсон. Энэний хэрэгжилт ямар үр дүнтэй байна вэ? Энэний хэрэгжилт хэрэгжихгүй байгаа бол бид нар олон хуудас товхимол тайлан бэлдээд, бэлдэхийн хэрэг юу байна вэ? Улсын Их Хурал өөртөө яаж дүгнэлт хийж байна вэ хууль батлах үйл ажиллагаандаа, ямар арга хэмжээ авч байна вэ? Засгийн газар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр, энэ чиглэлээр гарсан тогтоол шийдвэрийн биелэлт дээр хэрхэн ач холбогдол өгч, анхаарал хандуулж, төсөв мөнгө баталж, хүний нөөцөөр хангаж, бүх талын арга хэмжээг хэрхэн, яаж авч байна вэ? Холбогдох байгууллагууд, шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэл ямар арга хэмжээнүүдийг өнгөрсөн хугацаанд энэ гарсан шийдвэртэй холбогдуулж авч хэрэгжүүлсэн байна вэ? Ахиц өөрчлөлт яаж гарч байна вэ? Хандлага нь ямар өөрчлөлт орж байна вэ? Энэ дээр нэг та хариулт өгөөч.

Та бүхэн сургалт сурталчилгааны чиглэлээр энэ салбарын холбогдох байгууллагуудтай яаж уялдаж ажиллаж байна вэ? Жишээ нь шүүх. Жишээ нь тэр Энхболд гишүүн хэлсэн. Ногоон автобусны хэрэг дээр гэхэд гадаадын иргэн цагаадсан гээд байгаа боловч 4 сарын дараа хилээр гарах эрхийг нь нээж өгч байна, 4 сар Монгол Улсад хилээр гарах эрхгүй хоригдсон юм. Хязгаарлагдсан байна эрхээ. Энэ дээр тэр шийдвэр гаргасан шүүгч хүний эрхийн чиглэлээр ямар ойлголт хандлагатай байна вэ? Тэр аль, хэн Хунан гишүүний дүгнэлтэд гарсан. Тэр насанд хүрээгүй хүүхдийг хүчирхийлсэн, түүнээс мэдүүлэг авч байгаа мөрдөн байцаагч ямар ёс зүйгүй гэдэг юм уу, ямар хүний эрхийн зөрчилтэй асуултыг асууж байна вэ гэж. Тэгээд тэр мөрдөн байцаагч ямар ойлголттой байна вэ хүний эрхийн чиглэлээр? Тэгээд танай байгууллагаас зөвхөн Их Хурал, ЗГ гэхгүйгээр энэ холбогдох дандаа хүний эрхийн зөрчил, шийдвэр гаргаж байгаа, эрхийг нь хязгаарлаж байгаа, тагнаж байгаа, цагдаж байгаа, шийдвэр гаргаж байгаа энэ холбогдох байгууллагууд маань тэнд ажиллаж байгаа хүмүүс маань ямар ойлголттой байна вэ, ямар мэдээлэлтэй байна вэ, тэр шийдвэрийг чинь тэнд нэг хүүхэд хохироод, хэргийн хохирогч болоод явж байхад энд Их Хурал огт мэдэхгүй шүү дээ. Тэнд мөрдөн байцаагч тийм зүй бус, хүний ёсноос гадуур тийм асуулт асуугаад явж байгаа шүүгч байна, мөрдөн байцаагч байна тэгээд энэ улсууд чинь ингэж ямар ойлголт хандлага байгаад байна вэ? Энэ байгууллагуудтай яаж

уялдаж, хандаж ажиллаж байна вэ энэ тайлан юмаа? Энэ дээр нэг та нэг хариулт өгөөч. Баярлалаа. Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Д.Сүнжид: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Өмнөх жилүүдийн ХЭҮК-оос Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг үнэлээд дүгнээд өгсөн илтгэлийн мөрөөр өмнө жил ХЗБХ-той хамтраад ямар хэрэгжилттэй байна вэ гэдгийг холбогдох байгууллагууд буюу голчлон ЗГ-ын харьяа агентлаг, яам, Засаг дарга нарын түвшинд оролцуулаад илтгэлийг хэлэлцүүлж байсан. Энэ жилийн илтгэлийг хэлэлцүүлэх саналыг ХЗБХ-нд хүргүүлээд байгаа юм. Үнэлэлтийн биелэлтийг харвал 19, 20 дахь илтгэл 71 хувьтай, 21 дүгээр илтгэл 62 хувьтай, 22 дахь илтгэл 60, хамгийн сүүлийн илтгэл буюу өнгөрсөн жилийн илтгэлийн хувьд 51 хувьтай гээд 2025 оны 3 сарын 20-ны байдлаар ийм байдалтай байгаа. Энэ дунд ямар асуудлууд байдаг вэ. Шууд батлах ёстой хууль тогтоомжууд батлагдаагүй хэвээрээ байгаа. Жишээлбэл Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг, Жагсаал цуглааны эрх чөлөөний тухай хуультай хамт батлаач гэдэг чиглэлийг өгсөн. Энэ өнөөдрийг хүртэл батлагдаагүй хэвээрээ явж байгаа ийм асуудлууд байна.

Боловсролын салбарт ямар асуудлууд байна гэхээр үе шаттайгаар дотуур байрыг шинэчлээч, стандартад нийцүүлээч, мөн сургуулийн орчин, сургуулийг өөрийг нь анги танхим, багтаамж хүрэлцээний хувьд багшийн хувьд хүний нөөцийг бүрдүүлээч, бэхжүүлээч гэдэг асуудал нэг дор шийдэгдэхгүй үе шаттайгаар явж байна. Хөрөнгө нөөцийг төсөвт суулгууллаа, төлөвлөгөө гаргалаа, арга хэмжээ авсан бодлогыг тодорхойлсон гэдэг байдлаар явж байгаа ийм асуудлууд байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд шаардлагатай эмийн хүрэлцээний асуудал бас ЭМЯ-наас судалж байна, энийг бид нар энийг шийднэ гэдэг ийм байдалтайгаар хариулт өгөөд явж байгаа асуудал байна. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх гээд байгаа усны, хөрсний, агаарын бохирдлын эсрэг арга хэмжээ бас шууд үр дүн гарахуйц биш байгаа. Бид бүтцээ бол байгуулчихсан Орчны хороо гэдгээ байгуулчихлаа. Энэ дээр бид төсөв тавьсан. Цаашдаа эрчимжүүлж байна гэж байгаа боловч үр дүн талаасаа буюу яг Улсын Их Хурлын тогтоолд тусгасан байдлаар үр дүн гарсан гэж үзэхэд хүндрэлтэй эхлэлийн шатад байна гэж бид нар дүгнэж байгаа. Ийм, ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр хууль тогтоох дээр ч зарим хууль тогтоомж батлагдаагүй, өргөн баригдаагүй, хэлэлцэгдээгүй ийм асуудал бол байгаа. ЗГ-ын түвшинд ихэнх нь мэдээж ноогдож байгаа. Яагаад гэвэл бүх бодлого тодорхойлдог яаманд нь, хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд нь байдаг учраас, мөн орон нутгийн түвшинд Засаг дарга нартай холбоотой хэрэгжилтийн асуудал дээр анхаарах шаардлага байгаа. Хамгийн гол сануулах зүйл юу вэ гэхээр уялдаа холбооны асуудал. Нэг дагнан гэхээсээ илүү заримдаа жишээлбэл таны анхаарал тавьж байгаа энэ хүүхэд хамгааллын асуудал бол уялдаа холбоотой байж үр дүнд хүрнэ. Тэгэхээр энэ дээр бид анхаарах хэрэгтэй байна. Төсвийн нөөцийн асуудал байна, төсөв хүрэлцээтэй юу гэдэг асуудал байна. Үр дүн талаасаа яг арга хэмжээ авсан гэж тайлагнах биш, үр дүнд хүрсэн үү гэдэг талаасаа тайлагнах.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмээд та гүйцээгээд тайлбарлачихъя. Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Д.Сүнжид: Энэ тайлагнах байдал ч гэсэн бид тэрэндээ, шат шатын төрийн байгууллагууд, ЗГ-ын байгууллагууд энийг анхаарах хэрэгтэй байгаад байгаа юм. Бид нар тэдэн төгрөг зарцуулчихлаа, эдэн арга хэмжээ хийлээ гэхээсээ илүүгээр

ямар үр дүнд ингээд хүрсэн юм бэ, энэ салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал яаж дээрдэв, ямар ахиц дэвшил гарав, ямар сургамж авч үлдэв гэдэг дээр бол анхаарах шаардлага байна гэж үзэж байгаа юм.

Сургалтыг 2 дахь асуултын тухайд сургалтыг бид нар бүх шатанд хийж байна. Ялангуяа төрийн байгууллагууд руу чиглэж байгаа. Энэ жилээс эхлээд хувийн хэвшлүүдтэй хамтаръя гэдэг ийм бизнес ба хүний эрхийн хүрээнд хамтаръя гэдэг явж байна. Тэгэхээр илүү хэнтэй хамтардаг вэ гэвэл сургалт дээр хууль сахиулах чиглэлийн байгууллагууд, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин Штаб, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эд нартай бол хамтарч энэ ажлыг бид нар хил хамгаалах байгууллагатай санамж бичиг байгуулчихсан, хөтөлбөрийн хүрээнд анхан, давтан гээд сургагч багш нарыг бид бэлдээд явж байгаа. Түүнээс гадна хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай, мөн нийгмийн ажилтнууд, багш нар гээд, эрүүл мэндийн салбарын ажилтнууд, эмч нар гээд бид нар ер нь төрийн байгууллагууд руу хандаад, хамгийн их өргөдөл гомдол ирдэг салбар, хамгийн их асуудал дагуулдаг энэ гэж үзэж байгаа энэ асуудалд дурдагддаг салбаруудын удирдлагууд болон албан хаагчид, гүйцэтгэх, удирдах аль, аль түвшинд нь сургалтыг бол бүх хэлбэрээр зохион байгуулаад явж байна.

Ц.Сандаг-Очир: Түрүүн Хунан гишүүний илтгэлд гарсан насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг буурахгүй байна, хурдацтай өсөж байна гэдэг асуудал. Тэгээд энэ асуудал одоо ч яригдаж байгаа биш, өмнө нь яригдаад, өмнөх парламент бид анхаарал хандуулаад энэ чиглэлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалаад ингэсэн. Тэгээд аливаа гэмт хэргийн ялыг чангаллаа гээд тухайн гэмт хэрэг буурдаггүй юм байна гэдэг нь эндээс харагдаж байгаа шүү дээ. Тэгээд та бүхэн бол ялын бодлого сул байна гэдэг илтгэлдээ дурдсан. Энэ чиглэлээр Улсын Их Хурал бас яг энэ бодлогын арга хэмжээ авсан хуульд. Цаашдаа яах вэ Их Хурал ялын бодлогыг нь чангалчихлаа. Энэ төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр яавал зохистой байна вэ, ямар арга хэмжээ авбал, хаанаа бид нар алдаад байна вэ? Энэ тал дээр зөвхөн мэдээлэл ингэж өсөөд байна гэхээсээ илүүтэй та бүхэн бас ямар арга хэмжээ, арга замыг авбал энэ гэмт хэргийг бууруулах нөхцөл бололцоо манай улсын нөхцөл байдалд таарч, нийцэж болохоор байна вэ гээд ийм төрлийн судалгаа юм байна уу? Энэ тал дээр та бүхэн нэг хариулт тайлбар өгөөч. Ажлын хэсгийн 4 дэх микрофон.

Ж.Хунан: Бага насны хүүхэд хүчингийн гэмт хэргийн хохирогч болж байгаа, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсан судалгаанууд уг нь хийгдээд байгаа юм. Цагдаагийн байгууллага, прокурор, эрдэмтэн судлаачид үндсэндээ төрлийн гэмт хэргийг судлаад шалтгааныг нь тодруулж байна, саналуудыг гаргаж байгаа юм. Тэгэхээр зөвхөн урьдчилан сэргийлэх эсхүл энэ гэмт хэрэгтэй, гэмт хэргийг илрүүлэх биш ер нь бол бүгдээрээ нийлж урьдчилан сэргийлэх хяналтыг сайн хийх ёстой юм. Эцсийн бүлэгтээ бол энэ шалтгаан нь ядууралтай холбоотой гэж байгаа. Өрхийн орлого багатай, эмзэг бүлгийн хүүхдүүд өртөх магадлал аягүй өндөр байна. Тэгэхээр энэ бүх хүчин зүйлийг бид нар харгалзаж, хүнээ хөгжүүлэх ийм арга хэмжээг авах шаардлагатай байгаад байгаа юм.

Дээрээс нь хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, Хүүхэд хамгааллын тухай хууль өнгөрсөн оны 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байна. Энэ оны 1 сарын 1-нээс хороо болгон хүүхэд, гэр бүлийн

асуудал хариуцсан нийгмийн ажилтантай болж байна. Тэгэхээр эдгээр хүмүүсийн илрүүлэх ажиллагаа, өөрөөр хэлбэл тухайн хүүхэд ямар эрсдэлд байна, энэ нь өөрөө бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл байна уу, үгүй юү гэдгийг бол тодруулдаг, энийг судалдаг, энэ талаарх мэдээллийг гаргадаг, хэрвээ тийм эрсдэл байгаа бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг энэ механизмыг бэхжүүлэх, санхүүжилтийг нь нэмэгдүүлэх, дээрээс нь энэ хүмүүсийг мэргэшүүлэх ийм шаардлагатай байгаад байгаа юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөвхөн цагдаагийн байгууллага аль эсхүл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл биш, энийг ер нь бид нийт ард түмний дунд хүүхэд нэгдүгээрт, хүн бүр хүүхэд хамгаалагч гэдэг энэ соёлыг бид түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага байгаа. Өнөөдөр эцсийн бүлэгтээ хүүхдийн ойр дотнын хүмүүс, ар гэрийнх нь хүмүүс л хүчирхийлж байгаа ийм статистик байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол бүх түвшиндээ нэгдсэн байдлаар арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх арга барилаа өөрчлөх, шинэчлэх, дээрээс нь бусад төрийн байгууллагуудын ажил энэ уялдаа холбоог сайжруулах замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах боломжтой гэж харж байгаа. Мэдээжийн хэрэг энэ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ямар ч байсан ХЭҮК-оос боловсруулж, оруулж ирж байгаа Хүний эрхийн эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд, хүний эрхийн асуудал бол зөвхөн ХЗБХ-ны асуудал биш, ер нь парламент цаашдаа анхаарч, юун дээрээ бодлогын шийдвэрээ гаргах, юуг нь зохион байгуулалтын хувьд бусад байгууллагуудаа шахаж ажиллах юм бэ гэдэг зүйлээ бодох нь зөв байгаа.

2 дугаарт яах вэ би зүгээр энэ бол би саналаа хэлж байгаа гэдгийг манай комиссынхон ойлгоорой. Оруулж ирж байгаа саналуудыг би сайшаалтай байгаа боловч дотор нь жоохон ангилмаар байна. Аль нь бодлогын шийдвэрийн, аль нь зохион байгуулалтынх юм, аль нь төсөв мөнгө хүрэлцээгүйгээс ийм байдалд хүрээд байгаа юм. Тэгээд та хэдийн юм болохоор ерөнхий байгаад байгаа байхгүй юу. Тэг, ингэ гээд ингээд нэг ингээд байдаг. Тэгэхдээ үнэхээр юу гэдэг юм тавигдсан төсөв нь хүрэлцэхгүй байдлаас ийм болоод байгаа бол төсвийг нэмэгдүүлэх энэ тэр гээд жоохон тодорхой болгомоор байна. Тэгэхгүй ингээд үндсэн дата буюу та хэд маань анализ хийсэн хүмүүс маань ерөнхий байдлаар ингээд зөвлөмж өгөхөөр Монгол Улс огтоосоо энэ дээр нэг төсөв тавьдаггүй ч юм шиг, ер нь нэг тийм болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр юм ийм юу гэдэг юм хүний эрхийг хангах асуудал ингээд үйл явц буюу энэ урт удаан хугацаанд үргэлжилж байгаа процессын шинжтэй үйл явц юм гэдэг зүйлийг ойлгуулах гээд байгаа юм. Тэрнээс биш өнөөдөр ингээд нэг босож ирэнгүүтээ ингээд л төсвийг ингээд бүтэн тавиач, хэдэн тэрбум болгоод тавьсан ч энэ чинь шийдэгдэхгүй байхгүй юу. Бид хэдийн хандлага, ойлголт байгаа төсвийг үр ашигтай яаж зарцуулах, энийгээ дараа нь давтаж нэг удаагийн шинжтэй биш, яаж ингэж давтамжтайгаар энэ бодлогоо үргэлжлүүлэх вэ гэдгээс бүх юм хамаарна. Тийм учраас саналуудаа бас яг тэр өнцгөөс нь бодож, жоохон ангилж саналаа дэвшүүлж байгаач гэдэг зүйлийг би хүсэж байгаа юм.

Эцэст нь энэ дээр сонгуулийн жил биш, 28 он юу юугүй л болно. Тэгэхээр сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилттэй холбоотой үүсэж байгаа, цаашдаа үүсэж болох хүний эрхийн зөрчил, эрсдэлийг одоо анхааруулж бичиж орж ирсэн нь туйлын чухал байна. Энэ дээр ч гэсэн хурал даргалагчаас чиглэл өгөөд, ТББХ-н дээрээ бүх зүйлүүдийг үнэлэлт, дүгнэлт өгөөд, ажлын хэсэг гараад, сонгуулийн хууль тогтоомжийг бас нэг эхнээс нь авч үзэхгүй бол ер нь зүгээр ингээд цаашдаа сонгуулийн хууль тогтоомжийн маш олон зүйлүүдийг Үндсэн хуулийн цэцэд өгчихсөн байгаа. Тэгээд Цэцэд өгөхийнхөө хэрээр концепцууд нь эвдэрч байна. Ингээд сонгуулийн жилд Цэцэд өгөөд эхэлбэл сонгуулиа явуулж чадах юм уу, үгүй юү гэдэг Үндсэн хуулийн хязгаарлалттай болоод ирж байна. Энэ нь өөрөө эргээд Монгол Улсын ардчилал, тусгаар тогтнолын, тогтнолд томоохон эрсдэл оруулах ийм зүйл болж байна. Тэгээд зүйлийг ХЭҮК бодлогын хүрээнд дэвшүүлж байгааг бид хэд анхаарч хууль тогтоогч нар ажиллах ёстой байна гэдэг зүйлийг би ингээд эцэст нь хэлмээр байна.

Тэгээд 2 дахь тэр нэг илтгэл уг нь сонирхолтой байсан. Би нэгэнт асуулт асуух бололцоогүй учраас саналаа хэлчихье. Энэ технологиос хүнээ хамгаалах цаг болжээ гэж дүгнэж болохгүй шүү комиссын гишүүдээ. Технологийг ашиглаж явах нь гарцаа байхгүй. Эндэх технологийг эзэмшиж байгаа, технологийг ашиглаад тэнд үүсэж байгаа хүний эрхийн гэдэг юм уу, хүнтэй холбоотой мэдээлэл байдаг юм уу энийг процессын үйл ажиллагаа ч байгаа, энд харин хүний эрхийн зөрчлийг яаж гаргуулахгүй байх вэ гэдэг зүйлийг зөвлөмөөр байна. Түүнээс биш би сая ингээд илтгэлийг чинь өрөөндөө хараад суугаад байлаа. Технологиос хүнээ хамгаалах цаг болжээ тэр гээд аймар дүгнэлттэй үг орж ирж байна шүү. Энэ бол тийм биш шүү. Эндээс бид зайлах аргагүй. Харин энэ хүрээндээ хүний эрхээ яаж балансжуулж авч явах вэ, аль хэсэг дээрээ технологи эзэмшиж байгаа хүмүүсээ хариуцлагатай байлгах вэ энэ зүйлүүдээ бодъё гэдэг зүйлийг би эцэст нь нэг ийм бодлогын залруулга хэлмээр байна. Тэгээд энийг Улсын Их Хурлаар хэлэлцээд, тодорхой бодлогын шийдвэрүүдийг гаргаад, ялангуяа дэвшүүлж байгаа энэ сонгох, сонгогдох эрхтэй холбоотой юмыг цаг алдалгүй ажлын хэсэг Улсын Их Хурлаас гаргаж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг эхлүүлэх ёстой гэдэг зүйлийг би эцэст нь хэлмээр байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлж дууслаа. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулчихъя даа, танилцуулъя. Комиссын дарга, гишүүдэд баярлалаа.

15.24 цаг

Дөрөв.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлан

Байнгын хороо 4 дэх асуудалдаа орж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцэнэ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр эрүү

шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг Улсын Их Хурлын ХЗБХ-нд ирүүлсэн. Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.7 дахь заалт, 115.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланд хийсэн дүн шинжилгээг гишүүд та бүхэнд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Я.Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Ш.Үнэнтөгс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Р.Нэнсэндэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн сургалт хариуцсан референт, Г.Дэлгэрбаяр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн сурталчилгаа хариуцсан референт, Д.Нямдорж Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Д.Оюун-Эрдэнэ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн хэвлэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн албан тушаалтнууд оролцож байна. Ингээд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн танилцуулна. Ажлын хэсгийн 3 дахь микрофоныг өгье.

Я.Цэлмэн: Баярлалаа. Улсын Их Хурлын ХЗБХ-ны хуралдааныг даргалагч, эрхэм Улсын Их Хурлын гишүүдээ, та бүхэнд өдрийн мэндийг хүргэн мэндчилье. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар бүлэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд ХЗБХ-нд танилцуулж, хэвлэн нийтэлнэ гэж заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024 оны тайланг боловсруулан танилцуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2024 оны 4 дүгээр сараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны статистик мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт болон ОУБ-ын дүгнэлтэд үндэслэн 2024 оны тайланг боловсруулж, 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр ХЗБХ-ны даргад өргөн барьж, хэвлэн Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн. Мөн parliament-д байршуулан олон нийтэд танилцуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн дүн шинжилгээний танилцуулгын дүгнэлт, зөвлөмжид дурдагдсан асуудлыг анхаарч, хүний эрхийг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан саналыг хүндэтгэн хэрэгжүүлж ажиллалаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2024 оны тайланд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 онд хийж гүйцэтгэсэн ажиллагаа, хүрсэн түвшин, урьдчилан

сэргийлэх, хяналт, шинжилгээ, сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа, хүний эрхийн, хүний эрхийн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлт, мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022-оос 2024 онд холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмж, түүний биелэлт, хэрэгжилт, үр дүн, ахиц дэвшлийн талаар гэсэн ийм 6 бүлэгтэйгээр дүгнэлт, саналыг боловсруулан танилцуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үүнд, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа тогтмол явуулах гэсэн хуулиар үзүүлсэн үндсэн 4 чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажилладаг.

Өөрөөр хэлбэл богино, дунд, урт хугацаанд эрх нь хязгаарлагдаж байгаа олон хүний эрхийг хамгаалах, төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх механизмыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд 2024 онд 4, 2023 онд 5, 2024 онд 6 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34.1.11-д заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-аас 2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг тус тус батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц түүний нэмэлт протокол, Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зарчимд нийцүүлэн алсын хараагаа бол эрүү шүүлтгүй Монголын төлөө гэж тодорхойлон, эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй энэ тогтолцооны шалтгаан нөхцөлийг судалж, үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч нь байх эрхэм зорилгыг баримтлан ажилласан ажилласан.

Энэ удаагийн удаагийн тайланг боловсруулахдаа 2022, 2023, 24 оны тайлант хугацааны үйл ажиллагааны хүрсэн түвшнийг харьцуулан дүгнэх, үр дүн, цаашид хүлээгдэж буй гүйцэтгэлийг танилцуулахыг зорьсон болно. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд бид тайлант хугацаанд нийт 57 удаагийн хяналт шинжилгээг хийсэн. Үүнд хүүхдийн асрамж халамжийн байгууллагуудад 10, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асрамжийн газруудад 5, Цагдаагийн ерөнхий газар нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэх албаны төв, орон нутгийн байгууллагуудад 16, ШШГЕГ-ын харьяа салбар нэгжүүдэд 22, СЭМҮТ-д 3, Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн сахилгын байранд тус тус ажилласан.

Уулзалт ярилцлагын хүрээнд тухайн тайлант хугацаанд 1623 иргэн, 311 төрийн албан хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар

асуумж авч, нэгтгэн дүгнэсэн. Үүнээс эрх чөлөөгөө хязгаарлуулсан 415 иргэн, тухайн газарт үүрэг гүйцэтгэж байгаа 311 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийсэн. Энэ нь тодорхой асуудлыг шийдвэрлэх талаарх шийдвэрлэх талаарх гишүүний энэ үндэслэлүүдийн нэг гол эх сурвалж болж ирсэн бөгөөд цаашид эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх суурь тавигдсан гэж үзэж байна. Тухайн тайлант хугацаанд хийсэн онцлог ажлуудаас дурдвал тайлант хугацаанд анх удаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороо НҮБ-ын мандаттай ОУБ болон хууль хяналтын байгууллагатай хамтарсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг Монгол Улсад хийлээ.

Тухайлбал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тухай хуульд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын дэд хороотой хамтран 2024 оны 5 дугаар сарын 8-наас 11-ний өдрүүдэд ШШГЕГ-ын 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, ШШГЕГ-ын баривчлах болон ачлалт хүүхдүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний үндэсний төвд Үндэсний төвд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Мөн АРТ буюу олон улсын эрүүдэн шүүхийн урьдчилан сэргийлэх олон улсын нийгэмлэгтэй хамтран эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавх, арга зүйгээ сайжруулах, олон улсын хяналт шинжилгээний арга барилд суралцахад анхаарч, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажиллалаа. Энэ нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ хийх арга зүйг нутагшуулахад чухал алхам болж байна.

Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тухай хуулийн 33.1.1-д заасныг үндэслэн БЗД-ийн прокурорын газрын ерөнхий газартай хамтран, албан хаагчидтай хамтран БЗД-ийн нутаг дэвсгэрт байх хүүхдийн асрамж халамжийн байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн нь үр дүнтэй ажил боллоо. Мөн Нийслэлийн удирдах Цагдаагийн удирдах газартай хамтран нийслэлийн хүрээний эрүүлжүүлэх, саатуулах байрны нөхцөл байдлыг сайжруулах, стандартад нийцүүлэх, албан хаагчдын болон иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээнүүдийг хамтран хийж хэрэгжүүлсэн. Иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж тодорхой 24 онд, 25 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан ажиллаж байна. Энэ чиглэлээр тодорхой саналуудыг нэгтгэн хэлэлцүүлэг зохион байгуулж, ЗГ-т хүргүүлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний гол эрх зүйн байдлаар хүргүүлдэг энэ зүйл бол зөвлөмж гэсэн ийм бичиг баримт байгаа. Зөвлөмж гэсэн энэ асуудал заавал албан тушаалтан 30 хоногийн дотор биелүүлж, эргэн хариу мэдэгдэх гэсэн ийм зохицуулалт 2020 оны шинэчилсэн найруулгатай Хүний эрхийн Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад орсон нь бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлэхэд туйлын чухал алхам болж байгаа гэдгийг энд дурдах нь зүйтэй. Зөвлөмжийг, тайлант хугацаанд 15 зөвлөмжийг хүргүүлсэн. Нийт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хэрэгжиж эхэлсэн 22 оноос хойших өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 50 зөвлөмжийг холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргүүлсэн.

Нийт зөвлөмжийн биелэлтийг бид дүгнэж үзсэн. Нийтдээ 80 хувийн ийм, 80 хувьтай байгаа. Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар тодорхой арга хэмжээ аваагүй 10 албан тушаалтныг тайлант хугацаанд холбогдох томилсон, эрх олгосон байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлж, арга хэмжээ тооцуулж ажилласан. Зөвлөмжийг хүлээн авсан байгууллагуудын үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн хүрээнд гарсан ахиц дэвшлүүдээс онцлон жишээ татах нь зөв гэж бодож байна. Энэ бол тодорхой үр дүнгийн талаарх танилцуулга байгаа. Зөвлөмжийн дагуу хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхэд, 200 залуучуудыг хүлээн авах хүчин чадалтай 23,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй асрамж, халамжийн газрын барилгыг барихаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны багцын хөрөнгө оруулалтын төсөвт тусган батлагдсан, одоо барилгын ажлыг 2025 онд эхэлнэ.

Зөвлөмжийн мөрөөр Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалал ерөнхий газарт албан хэрэгцээнд зориулан хуваарилсан таблетаас хэмнэлт үүсгэж, Өнөр бүл хүүхдийн төвд амьдардаг хүүхдүүдийн цахим хичээлд суралцах эрхийг хангах зорилгоор *eduten person* хичээлийг суралцагчид хүртээмжтэй байдлаар олгох зорилгоор ингэж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид суралцаж байгаа оюутнуудыг мөн энэ төхөөрөмжөөр техникээр хангасан байна. Ахмад настны тухай хуульд 2024 оны 6 сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж, ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөгжих, эрүүл идэвхтэй амьдрах, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжтой байх, үл ялгаварлах зарчмыг бол хуульчлан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх нь хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зохицуулалтыг тусган баталсан байна. Асрамжийн газруудад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусад хүний адил үндсэн эрх, эрх чөлөөг эдлэхэд зориулсан хэрэгцээт тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, орчин нөхцөл, үйлчилгээний чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тодорхой үр дүн гарсан ийм тайлан мэдээтэй.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд дагаж мөрдөгддөг нийт 5 журмыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж эхэлсэн. Ахмад настны үндэсний төвд анх 2022 онд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхэд тус төвийн дарга, удирдлага, ахмад настнуудаас танилцуулж байсны танилцуулж байсан энэ 7,7 км замыг хатуу хучилттай болгох асуудлыг Зам, тээвэр хөгжлийн сайд тухайн үеийн сайд Бямбацогт, Халтар сайд нарт зөвлөмж хүргүүлсэн. Энэ төсөвт хөрөнгөөр баригдаж, энэ ондоо эцэслэн баригдаж дуусахаар ийм 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа юм байна. Нийслэлийн дүүргүүдийн эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцөлийг холбогдох стандартад нийцүүлж, хүний эрүүл мэндээ хамгаалуулах, амьд явах эрхийг зөрчиж байсан зөрчил дутагдлыг арилгасан. Энд харамсалтай нь орон нутагт ер нь эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байранд байсан зарим иргэд нас барсан ийм дүн мэдээнүүд байгааг тайланд оруулсан байгаа. Уг стандартыг олон улсын хүний эрхийн зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулж эхэллээ.

Улсын хэмжээнд цагдаагийн газар, хэлтсүүдийн мэдүүлэг авах бүх өрөөнд дуу, дүрсний хяналтын төхөөрөмжийг суурилуулсан явдлыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг олон улсын байгууллагын шинжээч бол Монгол Улсад ажиллах үеэрээ сая онцлон олон улсад сайн жишээ болохуйц үр дүн хэмээн

сайшааж, бүс нутгийн хэмжээнд нэвтрүүлэх ийм зорилготой байна гэдгээ илэрхийлсэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажил цагдаагийн байгууллагын алба хаагчдад хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх мендезийн зарчмыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд олон улсын шинжээч нартай хамтарч үе шаттай сургалтыг зохион байгууллаа. Ингээд үүний үр дүнд ЦЕГ-ын удирдлагаас гишүүний нэр дээр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийн хариу дээр бол эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдож шалгагдсан цагдаагийн албан хаагчийн тоо өмнөх жилүүдээс эрс буурсан. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэргийн тоо, гомдол, мэдээллээр цагдаагийн албан хаагч холбогдоогүй гэсэн дүн мэдээг ирүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тусгайлсан чиг үүргээ биелүүлэхэд шаардагдах зардлууд буюу өмнөх оны өр төлбөртэй холбоотой, албан хаагчдын хувцас хэрэглэл болон алба хаагчдын цалингийн шатлалыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 38,2 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэх хүсэлтийг Сангийн сайдад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд холбогдох судалгааг хийж хүргүүлсэн. Сангийн сайд тухайн дүнгээр шийдэж, төсөвт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв өмнөх оны өр төлбөр барагдаж, үйл ажиллагаа бол хүний эрхийг хангахад чиглэсэн байдлаар сайжирч эхэлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад удаа дараа дурдагдсан олон улсын шинжээчдийн дүгнэлтэд дурдагдсан улаан шугамд суулгаж байгаа буюу хүнийг удаан улаан улаан шугамд удаан байдлаар суулгаж, эрүүл мэндэд бусад байдлаар хохирол учруулж байгаа асуудлыг таслан зогсоогооч гэсэн асуудлыг 2023 оноос хойш хэрэгжүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагаас гишүүний нэр дээр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийн хариу дээр улаан шугам суулгах асуудал байхгүй буюу хоригдлын чөлөөтэй дотор зорчих журмыг бид нар шинэчилсэн гэсэн ийм дүн мэдээтэй байна. Хоригдлыг гэр бүлийнхэнтэйгээ чин сэтгэлийн харилцаа үүсгэх боломжийг олгож, түр уулзалтын хэсгүүдээр ковидын үеэр бүтэн хаасан байсан хаалтуудыг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 3 минут өгчихье, 3 минутад багтаагаад дуусгаарай.

Я.Цэлмэн: Баярлалаа. Ингээд тодорхой ийм үр дүнгүүдийг танилцууллаа. Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц түүний нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байгаа. Тайлант хугацаандаа анх удаа НҮБ-ын гэрээний хороо болон НҮБ-ын мандаттай байгууллагуудтай ингэж хамтарч ажилласан. Энэ жил НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны ерөнхий чуулган 11 сарын 20-ны өдөр болсон. Энэ 20-ны өдрийн чуулган дээр Монгол улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтдээ 3 дахь удаагийнхаа тайланг танилцуулсан. Энэ үеэр Монгол улсыг эрүү шүүлгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ахицтай ажиллаж байгаа юм байна гэдэг тодорхойлолтыг гаргасан. Мөн олон улсын эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Монгол Улсыг Ази Номхон далайн бүс нутагтаа эрүү шүүлгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон механизмыг бэхжүүлэх чиглэлээр тэргүүлэх туршлагыг хуримтлуулж ажилласан байна гэж дүгнэсэн. Мөн олон улсын Эрүүдэн шүүхийн дэд хорооны бүрэлдэхүүн Монгол Улсад 7 жилийн дараа 2 дахь удаагаа ирж айлчлахдаа мөн тодорхой дүгнэлтийг хийгээд, 3Г болон бидэнд ирүүлсэн байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурал, ХЗБХ үе үеийн ХЗБХ-ны дарга, гишүүд, Их Хурлаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой хууль зүйн шийдвэрүүдийг гаргаж ирсэн нь олон улсын байгууллагуудын дүгнэлтээр Монгол Улс хүний эрх ялангуяа эрүү шүүлтээс ангид байх эрхийн чиглэлээр үсрэнгүй ийм бодлого, төрийн бодлого хэрэгжүүлж, үр дүн нь сайшаалтайгаар гарч байна гэсэн ийм асуудлыг олон улсын байгууллагууд дүгнэсэн байна. Энэ бол бидний хамтдаа хийж хэрэгжүүлсэн 3 жилийн үйл ажиллагааны үр дүн гэж харж байна.

Бид Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаанаас дараах саналыг гаргаж байна. Энд бол 1-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй болгох. Эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд зориуд саад учруулах үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох. Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлгүүдэд буй эрүүдэн шүүх үйлдлийг нэгтгэн Эрүүгийн хуулийн 1 бүлэг болгож эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх. Нотлох баримтыг эрүү шүүлт тулгаж, хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж цуглуулж, бэхжүүлж, шалгаж, үнэлсэн нь тогтоогдсоныг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэлд тооцох. Эрүү шүүлтийн хохирогчийн хохирол, хор уршгийг төр эрхлэн барагдуулж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагуудад орон тооны бус зөвлөл байгуулах, үндэсний хөтөлбөр боловсруулах гэсэн эдгээр саналуудыг гаргаж байна. Анхаарал хандуулсан та бүхэндээ баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Цэлмэн даргад баярлалаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлантай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ нөгөө үйл ажиллагааны тайлан гээд нэг ийм зузаан юм өгчихсөн. Би бол Улсын Их Хуралд тайлагнах хэмжээнд ийм өдөр тутмын үйл ажиллагааны ч байдаг юм уу, хийсэн харсан бүх юмаа ингээд бичих, тайлагнах хэрэг ер нь хэр байдаг юм доо? Энийг ер нь уншсан хүн байгаа юм уу манай Байнгын хорооноос гайхаж л байна. Тэгээд яах вэ сая Цэлмүүн даргын юуг тайлангийн юуг сонслоо, танилцуулгыг. Ихэвчлэн тийм газар төсөв нь тэглээ, тийм үйл ажиллагаа дээр очиж шалгасан, цагдаа нь тийм байна гээд яг үнэндээ бол нэг үйл ажиллагааны танилцуулга байна. Тэгэхээр энэ та бүхний уг нь чиг үүрэг бол яг энэ эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийг Монголд хангуулахын тулд, ялангуяа системийн асуудал бид чинь эрүүдэн шүүхийн олон ч сонсгол хийлээ, олон ч ажлын хэсэг ажиллаж байна. Юундаа байна гэдгийг гол учрыг нь бол олчихоод байгаа шүү дээ тийм ээ. Хяналтын тэнцвэргүй байдал байна, энэ ил тод

байхгүй байгаагаас болоод иймэрхүү юмнууд ингээд хууль хүчний байгууллагад орж ирж байна. Ойлголтын зөрөөнүүд байна гээд системийн шинжтэй юмнууд байгаад байгаа. Энэ системийн шинжтэй юмаа яаж засаж залруулж, урьдчилан сэргийлэх ажиллагаагаа цар хүрээтэй явуулах юм бэ гэдэг асуудал нь хамгийн чухал.

Тэрнээс та бүхний өдөр тутамдаа аль газар очоод, юу хийсэн гэдэг бол энэ бол байгууллагын үйл ажиллагааны хүрээндээ байхад болох байх. Улсын Их Хурлын хэмжээнд бол энэ бол яг асуудлууд нь хаанаа системийн тогтолцооны хувьд бид байна гэж харж байна. Тэрийгээ шийдвэрлэх арга замууд нь юу гэж харж байна? Тэрний талаар бид Улсын Их Хурал хууль тогтоомж гаргахдаа юун дээр анхаарах ёстой байна гэдгийг л ер нь товчхондоо чухал шүү дээ. Тэгээд дээр л илүү би хариулт, өөрийн чинь мэдээлэл хамгийн түрүүнд юу анхаарах ёстой байна, ямар арга замууд байна л гэдгийг сонсмоор байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Цэлмэн дарга ажлын хэсгийн 3 дахь микрофон, асуултад хариулъя.

Я.Цэлмэн: Баярлалаа. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Хуульчлан зааснаар бол тайлан яг үйл ажиллагааны, үндэсний үйл ажиллагааны тайлан гэж байгаа учраас ингэж тайлан танилцуулах ийм хуулийн үүрэгтэй. Тэгээд олон улсын Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн дэд хорооноос өгсөн зөвлөмж болон бусад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа буюу олон улсын үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага байгуулагдсан тайлангуудын хэв шинжийн яг адилхан ийм загвартай ер нь явж байгаа. Тийм учраас бас нэлээдгүй бичих, ажлуудаа бичих шаардлагатай байдаг.

Ер нь хүний эрхийг хамгаалах, ялангуяа урьдчилан сэргийлэх гэдэг бол өөрөө нэлээн төвөгтэй ажил байна. Энэ ажлыг хийж хэрэгжүүлэхийн тулд чухам юу, юу хийв гэдгийг тайланд заавал дурдаж үлдээж байх ийм шаардлагатай. Ялангуяа Монгол Улс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаагаа байгуулаад, энэ жил 3 дахь жилтэйгээ золгож байгаа учраас энэ тайлан дээр бүх зүйлийг нарийн бичиж ингэж үлдээх ийм зөвлөмжийг бидэнд ОУБ-аас өгсөн. Энэ тайлан маань мөн орчуулагдаад НҮБ-ын дэд хорооны сайт дээр албан ёсоор байршдаг. Тэгээд яг энэ байрших шаардлагад бид нар аль болох нийцүүлэхийг хичээдэг.

Дараагийн асуулт хамгийн чухал асуулт бол энэ системийн хувьд, тогтолцооны хувьд эрүү шүүлтээс яаж урьдчилан сэргийлэх вэ гэж. Бид 2022 оны тайлан, 23 оны тайландаа ХЗБХ-нд танилцуулсан. ХЗБХ нь бидний өгсөн яг энэ танилцуулсан саналыг бүрэн хэлэлцэж дэмжээд, 4 асуудлыг үндсэндээ шийдсэн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд. Энд 2023 оны 35 дугаар тогтоолд Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-ийн холбогдох заалтуудыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын холбогдох заалтуудад нийцүүлэх шаардлагатай гэж Их Хурлаас тогтоол гарсан. Дараа нь бие даасан Мөрдөх албыг байгуулах шаардлагатай байна. Энийг судалж, танилцуулах үүргийг ЗГ-т өгсөн. 2024 оны тайланд бол 2024 оны 37 дугаар тогтоолд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр гаргасан санал зөвлөмж, олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу бол энэ эрх зүйн зохицуулалтыг тодорхой болго гэсэн.

Тэрний дараагийн хамгийн чухал зүйл бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эрүү шүүлт тулгасан талаарх төрийн байгууллага шалгаад эцэслэн шийдээгүй гэж үзвэл гомдлоо НҮБ-ын, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн хороонд гаргах энэ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлд заасан эрхийг нээх мэдэгдлийг хүргүүл гэсэн ийм тогтоолыг мөн гаргаж дэмжсэн. Энэ нь ингээд бид жил, жил үе шаттайгаар яг тогтолцоогоор нь явж байгаа. Энэ жил бидний хамгийн хийсэн гол чухал ажил ХЗБХ-той хамтран бүх их, дээд сургууль буюу эрх зүйн боловсрол олгож байгаа бүх их, дээд сургууль буюу нийтдээ 13 их, дээд сургууль байна. Тэр их, дээд сургуулиудын яг хичээлийн агуулга, хөтөлбөрт хяналт шинжилгээ хийж, танилцуулсан байгаа. Энэ хяналт шинжилгээ хийхэд үндсэндээ хүний эрхийн хичээл ордог сургууль 10 орчим сургууль байна. Энэ хүний эрхийн хичээлтэй сургуулиудын хөтөлбөр дотор эрүүдэн шүүхээс ангид байх чиглэлээр 7,6 хувийн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмээд хариулчихъя, ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл сургалтын агуулга бол хичээлийн хөтөлбөрт 7,6 хувьтай, ялгаварлан гадуурхалт болон бусад хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг зөрчих байдалтай холбоотой хүний эрхийн хичээл 24,7 орчим хувьтайгаар ингэж дүгнэгдсэн. Ингээд бид үндсэндээ энийг юу гэж харж байна вэ гэхээр бүх хичээл сургуулиуд өөр өөрсдийн онцлогоор хичээл зааж болох боловч гагцхүү энэ хүний эрхийн холбогдолтой, ялангуяа хүний эрхтэй холбоотой хичээл, эрүү шүүлтээс ангид байхтай холбоотой хичээл сургалтын хөтөлбөрийг бол үндэсний хэмжээнд нэг хөтөлбөр боловсруулж, баталж бүгдээрээ бүх сургуульд харилцан бүгдээрээ яг энэ хөтөлбөрийн дагуу хичээл орох нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр энэ 13 их, дээд сургуулиас бэлтгэгдсэн хүний нөөц Монгол Улсад өнөөдөр хууль, эрх зүйн болон бусад төрийн албаны, төрийн албаны албан тушаалын тодорхойлолт эрх зүйч байна гэж заасан энэ хүрээнд ажил мэргэжил эрхэлж байгаа хүрээнд ажиллаж байгаа хүмүүсийг энэ их, дээд сургуулиуд л бэлтгэж байна. Мөн дээрээс нь бид энэ жил криминологи судалгааг Криминологичдын холбоогоор хийлгэсэн. Энэ бол Монгол улсад анх удаа гэмт, эрүүдэн шүүх гэмт явдлынх нь хүрээнд ямар учраас энэ гэмт хэрэг гараад байна гэдэг тэр шалтгаанд судалгаа хийж, Их Хурал, Хууль зүйн байнгын хороо, ажлын хэсэг дээр танилцуулаад, ингээд тодорхой чиглэл гараад, мөн Өмгөөлөгчдийн холбоо, бусад Хуульчдын холбоо, прокурор, цагдаагийн байгууллагад танилцуулаад санал авах ажил үргэлжилж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох албаны хүмүүс оролцож байгаа. Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Отгонсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх, Г.Нямдэлгэр Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын референт гэсэн албан тушаалтнууд нь оролцож байгааг хэлье.

Ганц нэг асуулт асууя. Та бүхний тавьж байгаа санал байна 9 төрлийн. 7 дахь санал дээр асуулт асууя. Эрүү шүүлтийн хохирогчийн хохирол, хор уршгийг төр эрхлэн барагдуулах ёстой, энэ талын эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой байна гэж байна. Үүнтэй холбогдуулаад өнгөрсөн хугацаанд ер нь энэ төрлийн гэмт хэрэг

ер нь өсөж байна уу, буурч байна уу? Эрүүдэн шүүлтийн асуудал ер нь байсаар байна уу, цаашдаа яах хандлага байна вэ? Өсөх хандлага байна уу, буурах хандлага байна уу, тоо судалгаа юу байна вэ? Энэний улмаас хэчнээн хүн хохироод байна вэ нэр төрөөрөө, эрүүл мэндээрээ, амь насаараа, энэний хохирлыг яаж тогтоож байгаа юм бэ, тогтоох ёстой юм бэ, хэн тогтоох ёстой юм бэ? Энэнтэй холбоотой өнөөдөр төртэй заргалдаад явж байгаа хохирлоо нөхөн төлүүлэх барагдуулах асуудлаар явсан, тавьсан гомдол чирэгдэл юу байна вэ? Асуудлаа шийдүүлж чадахгүй байгаа улсууд юу байна вэ? Өнөөдөр энэ асуудлыг нөхөн төлбөрийн асуудал, гэм хорын асуудлыг барагдуулах асуудлыг хууль зүйн ямар хуулиар, ямар эрх зүйгээр зохицуулж байна вэ? Зохицуулалт байна уу, байхгүй юу? Байгаа зохицуулалт нь хэрэгжихгүй байгаа юм уу эсвэл огт зохицуулалт байхгүй байгаа юм уу? Энэ саналаа нэг тодорхой тайлбарлаж өгөөч. Ажлын хэсгийн хэн, 3 дахь микрофон уу? Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Сандаг-Очир даргын асуултад хариулъя. Хохирол нөхөн төлөлтийн асуудал буюу 7 дугаар санал дээр холбоотой асуудлыг бол, асуусан дарааллаар хариулъя. Эрүүдэн шүүх гэмт хэрэг бол ямар төлөвтэй байна вэ өсөх байна уу, буурах байна уу гэж. Эхний 3 жилд бол иргэдийн болон төрийн албан хаагчдын эрүүдэн шүүхээс, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх ойлголтыг, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийсэн. Эхний 3 жилд үндсэндээ эхний жилд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 11 гомдол, дараагийн жил бол 66 гомдол, энэ жил бол 99 гомдол ирсэн. Энийг бол хуульд заасны хүрээнд холбогдох байгууллагуудад хэрвээ гэмт хэргийн шинжтэй бол хуульд заасан хугацаанд шилжүүлж шалгуулсан ийм байгаа.

Энэ жилээс үндсэндээ эрүү шүүлт тулгах гэмт хэрэг бол яг үндсэндээ шүүхээр шийдвэрлэх шинж бол дараагийн 3 жилийн буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа шатанд, шалгагдах тоо хэдийгээр өсөж байгаа ч гэсэн дахин үйлдэгдэх хэв шинж, дахин үйлдэгдэх прогноз урьдчилсан мэдээлэл бол багасна гэж үзэж байгаа. Яагаад гэхээр Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн энэ дүн мэдээн дээр тухайн алба хаагчид бол оны эхний байдлаар энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож шалгагдаагүй байна гэсэн ийм дүн мэдээг ирүүлээд байгаа нь бидэнд, бид сайн мэдээ гэж харж байгаа.

Ер нь бол энэ эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдож байгаа ихэнх албан хаагч нар цагдаагийн болон бусад байгууллагын мөрдөх албаны алба хаагчид байдаг. Мөрдөх албаны хаагчдаа, алба хаагчид энэ төрлийн гэмт хэрэгт холбогдуулахгүйн тулд мендезийн зарчмыг бүрэн прокурорын байгууллага болон цагдаагийн байгууллагад үе шаттайгаар 3 жилийн хугацаанд нутагшуулж дууссан. Тэгэхээр ингээд энэтэй холбогдуулаад мэдээлэл, мэдүүлэг авах өрөө болон бусад бүх газар ингээд эрүү шүүлт явуулах нөхцөлгүй болох байдлаар бүх талын санал санаачилга гаргаж ажиллаж байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Эрүү шүүлт тулгасан энэ гэмт хэргийн хохирогчдын хохирол нөхөн төлөлтийн асуудал ЗГ-ын тусгай сангийн тухай хууль дээр бий. ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал бий. Энэ дээр бол 3 асуудлыг нөхөн төлж байгаа. 1 дүгээрт нас барсан бол оршуулгын зардал, 2 дугаарт эрүүл мэндийн эмчилгээний зардал, дараа нь хөдөлмөрийн чадвараа алдсанаас үүдсэн хөдөлмөрийн хөлсний зөрөөг олгох гэсэн ийм заалтууд байгаа. Өнөөдөр үндсэндээ Монгол Улсад эрүү шүүлтээс, эрүү шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо гэсэн ийм төрийн

бус байгууллага байгуулагдсан. Энэ ТББ анх байгуулагдахдаа 47 хүнтэйгээр байгуулагдсан, өнөөдөр тухайн холбоонд орж төрөөс гомдлыг барагдуулаач гэсэн иргэдийн тоо нэмэгдэж байгаа. Иргэд хамгийн гол нь юу хүсээд байна вэ гэхээр тодорхой ингээд мөнгөн дүн хүсэж байгаа хэдий ч зарим сэтгэл санааны хохирол болон яг чиглэлийн асуудлыг заавал мөнгөн дүнгээр биш, уучлалт гуйлгах хэлбэрээр зохицуулж өгөөч. Тэгвэл төр уучлалт гуйх, тухайн буруутай албан тушаалтнаар уучлалт гуйлгачихвал.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмээд хариулчих 3 минут, ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Ингээд хохирогчийн энэ дотроо бол ийм төрлүүдтэйгээр бид нар санал болгож байгаа. Энэ дээр хохирогчийн нэр төрийг сэргээх тухай албан ёсны мэдэгдэл хийх, олон нийтийн өмнө уучлалт гуйх, хохирогчдын дурсгалыг хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх гэсэн олон улсад хэрэглэгддэг бусад аргыг Монгол Улсад нэвтрүүлэх нь зүйтэй байна гэж харж байгаа юм. Ялангуяа энэ талаар ХЗБХ-н дээр ажлын хэсэг гарчихсан. Ингээд ажлын дэд хэсэгт ороод энэ чиглэлээр санал, дүгнэлт, саналаа өгөөд ажиллаад явж байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Чимгээ, Содномдаржаа нарын асуудал эрүүдэн шүүлт мөн үү, танайх юу гэж дүгнэсэн, танайхаас энэ асуудалтай холбогдуулж ямар нэг шийдвэр гаргасан уу? Хэрвээ мөн бол энэ улсууд өнөөдөр эрх чөлөөтэй явж байгаа, эрүүл мэндээрээ, амь амьдралаараа хохирсон байж таарна. Энэний асуудал, хохирлыг нөхөн төлүүлэх асуудал танайх ямар холбоотой ажиллаж байна вэ, ямар зөвлөмж, дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтарч ажиллаж байна вэ? Энэ улсууд танай байгууллагад хандсан зүйл байна уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Сандаг-Очир даргын асуултад хариулъя. Тухайн этгээдүүдийн асуудлаар тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдтэй холбоотой асуудлаар болон хохирсон иргэдтэй холбоотой асуудлаар эцэслэн шийдвэрлэх асуудал шүүхийн бүрэн эрхэд байдаг учраас эцэслэн шийдэх ёстой. Гэхдээ нэгэнт энэ хүмүүсийг бид улс даяараа мэдэж байгаа. Энэ үйлдлийг би бас та бүхэнтэй адилхан ийм анх бол зурагтаар харсан хэмжээнд харж байсан. Сүүлд энэ иргэд бүгд ирж уулзсан. Одоо болтол ингээд энэ хэлмэгдүүлэлт Эрүү шүүлт, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоонд эдгээр хүмүүс байгаа. Энэнтэй холбоотой ажлын хэсэг гараад ингээд судлаачид яг хууль зүйн дүгнэлт гаргах гээд ажиллаж байгаа. Манайхаас бид ер нь яг энэ эрүү шүүлт мөн, биш гэж дүгнэдэг ийм эрх хэмжээ байдаггүй. Гагцхүү гаргуулахгүй гэдэг урьдчилан сэргийлэх зорилгыг л ингэж хэрэгжүүлдэг ийм механизм байгаа гэдгийг тухайн тэр иргэдэд танилцуулдаг. Иргэдийн хүлээлт бол шууд манайхыг эрүү шүүлт гэдэг нэртэй учраас ирж хандаад, танайх тогтоох ёстой гэдэг. Бид бол харьяалах байгууллагуудад нь ингээд тогтоож өгөөч гээд ингээд явуулдаг.

Монгол Улс анх удаагаа хүний эрхийн чиглэлээр явуулсан хяналтын сонсгол нь эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн чиглэлээр бол өнгөрсөн 2024 оны 11 сарын 20-нд явсан. Энэнтэй холбоотойгоор, энэ хяналтын сонсголтой холбоотойгоор тухайн иргэд ирж оролцсон. Мөн ХЗБХ-ны тухайн иргэдтэй холбоотой асуудлаар дүгнэлт гарсан. Бидний зүгээс яаж тусалж, дэмжиж байгаа вэ гэхээр ерөөсөө өнөөдөр энэ оруулж ирж байгаа саналын хүрээнд энэ хохирлыг

маш хурдан төрөөс барагдуулахгүй бол гэм буруутай этгээдийн гэм бурууг тогтоох гэсээр байтал хуулийн тодорхой процесс хугацаа бол жил, сарыг авч байна. Тэгэхээр тэр хугацаанд энэ хүмүүсийн хохирсон тэр хохирол, эрүүл мэнд, сэтгэл санаа, амьдрал ахуй, чанарын доройтсон байдал эдгээр бүх зүйлийг нөхөн барагдуулахгүй бол тухайн хүний амьдрал мэдээж хугацаатай, тоотой юм гэдгийг анхаарах шаардлагатай байна гээд. Тэгээд яаралтай шаардлагатай энэ хохирлуудыг бол нэгэнт эрүүдэн шүүгдсэн нь тодорхой байвал төрөөс богино хугацаанд нөхөн сэргээдэг энэ боломжуудыг хангаж өгөөч гэсэн энэ саналыг энэ хүрээнд томъёолж оруулсан байгаа юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Сая хохирогчийн талаас асуусан бол одоо тодорхой албан тушаалтнуудад эрүүдэн шүүлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн байх, ямар, ямар албан тушаалтнууд өнгөрсөн хугацаанд энэ хэрэгт холбогдсон бэ? Танайхаас ямар арга хэмжээ авсан бэ хариуцлагын? Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

Я.Цэлмэн: Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Статистик мэдээ ингээд гарсан. Ер нь 2017 оны 7 сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 21.12-т бол эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бүрэлдэхүүний хувьд төрийн бүх субъект гэж зааж өгснөөрөө Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын энэ тодорхой ойлголтод нийцүүлсэн ийм тодорхойлолтой гэмт хэргийн бүрэлдэхүүний тодорхойлолт болсон. Энийг бол төрийн албан хаагчид нийтээрээ анхаарах шаардлагатай. Өмнө нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч гэсэн дөрөвхөн субъектийг 2002 оны Эрүүгийн хуульд хуульчилсан байсан бол 2017 онд ингэж өргөн субьекттэй болсон. Хэдийгээр тийм боловч ойлголт хандлагын удаан бид, бидний зүгээс үйл ажиллагааны хувьд зарим нэгэн дутагдалтай зүйл, нөөцийн дутагдалтай зүйл байдгаас хамаарч бүх төрийн албан хаагчид бол хүрч үйлчилж чадахгүй байгаа гэдгээ бол хүлээн зөвшөөрөх ёстой.

Урьдчилан сэргийлэх ажлыг үндсэндээ бид хариуцлага тооцох асуудлыг өнгөрсөн жил 10 албан тушаалтанд хариуцлага тооцсон. Энд бол цагдаагийн газар, хэлтсийн дарга нар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих ангийн дарга нар, прокурор, шүүгч гээд энэ албан тушаалтнуудад 10 тооны албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн. Энэ бол урьдчилан сэргийлэх зөвлөмжийг биелүүлээгүй буюу тухайн зөвлөмжийг авсан албан тушаалтан тухайн жилдээ хийж хэрэгжүүлэх арга хэмжээгээ хийгээгүйгээс улбаалж, хүний энэ эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн асуудал байгаа. Өнгөрсөн хугацаанд нийт 16 хэрэг шүүхээр шийдэгдсэн 5 жилийн хугацаанд, 17 оноос хойш. Энэ хугацаанд шийдэгдсэн хэргүүдийг харахад бол дандаа цагдаагийн байгууллага болон энэ мөрдөх албаны чиглэлийн энэ албан тушаалтнууд байгаа. Мөн хорих байгууллагын албан тушаалтнууд байгаа. Тэгэхээр эдгээрээс авч үзвэл цаашид бид нар чиглэлийн салбарын алба хаагчид руу өнгөрсөн 3 жилд түлхүү бодлого боловсруулсан. Тэгээд үр дүн гарч байгаа гэж харж байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайлангаас гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцэж дууслаа. Комиссын гишүүдэд баярлалаа.

Тав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Дараагийн асуудалдаа оръё. 5.Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж, 16.2-т Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш 15 хоногийн дотор Тамгын газар, Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр дүн шинжилгээ хийж, танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж, 16.3-д Байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг энэ хуулийн 16.2-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хэлэлцэнэ гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон ХЗБХ-ны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланд хийсэн дүн шинжилгээний танилцуулгыг та бүхэнд тараасан. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Э.Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Д.Үүрийнтуяа Засгийн газрын Хяналт үнэлгээний Үндэсний хорооны Мониторингийн газрын дарга, Ш.Бумаажав Засгийн газрын Үнэлгээ, мониторингийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт, Б.Отгонцэцэг Засгийн газрын Үнэлгээ, мониторингийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан ахлах шинжээч, энэ байгаа юм уу? Ү.Амарбат Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Отгонсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх, А.Амармэнд Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын референт гэсэн хүмүүс оролцож байна.

Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаяр танилцуулна. Ажлын хэсгийн 4 дэх микрофоныг өгье.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын ХЗБХ-ны гишүүн, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж ЗГ-т танилцуулах гэж заасныг үндэслэл болгон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 8.5, ЗГХЭГ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, дүнг ЗГ-ын хуралдаанд танилцуулан, холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлнэ гэсэн заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр ЗГХЭГ-аас ХЗБХ-нд тайлан хүргүүлсэн болно. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ЗГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан, unelgee.gov.mn-д ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны нийтлэг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийн тухайд Цахим санд Монгол Улсын нийт 89 хууль, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын Байнгын хорооны 79, нийт 272 шийдвэрийн 1550 заалт бүртгэлтэй байна.

Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт нь 66,4 хувь байна. Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй байгаа Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрүүдийн үнэлгээний ангиллаар авч үзэхэд 569 заалт буюу 36,7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 390 буюу 25,2 хувь нь хэрэгжих шатдаа, 224 буюу 14,5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 196 буюу 12,6 хувь нь хэрэгжээгүй гэж дүгнэгдсэн байна. Харин хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй үндэслэлээр 170 заалтыг үнэлэх боломжгүй байна. Хэрэгжилт нь дунджаар 66,4 хувь байгаагаас, байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилт бүрэн хангагдсан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, шийдвэр хүчингүй болсон зэрэг 519 заалтыг хяналтаас хасуулах саналтай байна. Ингээд Байнгын хорооны гишүүд та бүхэн Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцана уу. Тэгээд тарааж өгсөн байгаа.

Ц.Сандаг-Очир: Одбаяр даргад баярлалаа. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан болон тайланд хийсэн дүн шинжилгээний талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга уу? Алга байна. Гишүүд, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа. Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

16.05 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

